

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-10

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 11-91

1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 15-91

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтаншагай, Э.Бат-Амгалан, Р.Эрдэнэбүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Б.Энхбаяр, Б.Пүрэвдорж, Н.Номтойбаяр нар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Б.Энхбаяр нар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг түр хойшлуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 11

Бүгд: 20

45.0 хувийн саналаар горимын санал дэмжигдээгүй тул уг асуудлыг хэлэлцэхээр тогтов.

Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Усны газрын дарга З.Батбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын

дарга Э.Нямдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, Геологи, Уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Г.Жамсрандорж, Я.Ганболд, Л.Жаргалсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, П.Наранбаяр, Д.Цогтбаатар, С.Ганбаатар, П.Сайнзориг, Н.Наранбаатар, Д.Ганбат, Г.Дамдинням, Э.Болормаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр;

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, П.Сайнзориг, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Г.Уянгахишиг;

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлэв.

Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, 8.1.4.Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах эсэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар шийдвэрлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Б.Пүрэвдорж нар үг хэлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, 9.1.9.Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, 9.1.10 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх” гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5/20¹ дүгээр зүйлийн 20^{1.3} дахь хэсэгт “борлуулалтын үнэлгээний 5 хувиар” гэснийг “борлуулалтын үнэлгээний 9 хувиар” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 22
Бүгд: 22
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20¹ дүгээр зүйлийн 20^{1.4} дэх хэсгийн “хувь” гэсний өмнө “үндсэн” гэж нэмж, мөн зүйлийн 20^{1.6}, 20^{1.7} дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20^{1.6} нь энэ хуулийн 20^{1.5}-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 6
Бүгд: 22
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20^{1.9} дэх хэсгийн “олборлосон” гэсний дараа “цацраг идэвхт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 28.2.12 дахь заалтын дугаарыг “28.2.11” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэсний дараа “28.2.11” дэх заалтын дугаарыг “28.2.12” гэж, мөн зүйлийн гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.3 дахь хэсгийн “олборлолт” гэсний дараа “баяжуулалт” гэж, “аюулгүй” гэсний дараа “булшлах” гэж тус тус нэмж, мөн хэсгийн “гүйцэтгэх” гэснийг “гүйцэтгэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 3
Бүгд: 22
86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.4.1 дэх заалтын “батлан мөрдөх” гэснийг “баталгаажуулан мөрдөх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг олон улсын хөндлөнгийн шинжээчээр хянуулах” гэж өөрчилж, 34.4.2 дахь заалтын “нэн” гэснийг, 34.8 дахь хэсгийн “15.2.1” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 3
Бүгд: 22
86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, 34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэлд байршуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Б.Пүрэвдорж, Д.Энхтүвшин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11
Бүгд: 22
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, 34.5 дээр “төрийн дансанд” гэснийг “Монголбанкн дахь Ирээдүйн өв сангийн валютын тусгай дансанд байршуулна” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 22 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэгт “Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг цацраг идэвхт ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн өгүүлбэр,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 5
Бүгд: 22
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, 5.5 нь 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 5.4 дэх хэсгийг 1 дүгээр зүйлд шилжүүлж, 5.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг Монгол Улсад үр өгөөжтэй байх хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, С.Ганбаатар, Д.Энхтүвшин нар үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж ажлын хэсгээс гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

14.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 22

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Жаргалан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 22 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, 3 дугаар зүйлийн 3/30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 16
Бүгд: 22

18.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 12.2 дахь хэсгийн “байцаагчийн” гэснийг “байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх)-ийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11

Бүгд: 22
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: 16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 12.2 дахь хэсгийн “байцаагчийн” гэснийг “байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх)-ийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Б.Уянга нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “20 гэж” гэсний дараа “ , мөн хэсгийн “байгуулж болох бөгөөд түүнд” гэснийг “гэрээний биелэлтийг 5 жил тутам дүгнэх, шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд” гэж” нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, О.Батнайрамдал нар саналаа тайлбарлаж үг хэлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 21
Бүгд: 22
4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан, Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “10” гэснийг “10-20” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 21
Бүгд: 22
4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Хөрөнгө оруулалтын тухай өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 15
Бүгд: 22
31.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Г.Уянгахишиг, Ө.Шижир нарын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 16
Бүгд: 22
27.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Хууль” гэсний өмнө “Цөмийн энергийн тухай” гэж нэмэх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Энхбаяр, Х.Тэмүүжин, Ч.Анар нар үг хэлж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 10

Бүгд: 22

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Найруулгын санал

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 10

Бүгд: 22

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 45 үргэлжилж, 25 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 88.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д. Сүхбаатар” танхим
13 цаг 20 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Би та бүхэнд ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүд хүрэлцэн ирснээр 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1 асуудал байгаа. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, Засгийн газар 24 оны 10 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг хийхээр байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу?

Энхбаяр гишүүн, Анар гишүүд байна. Кнопоо дараарай цэсээ өгөөрэй. Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Анар гишүүн.

Ч.Анар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг маань үндсэндээ 7 хоногийн хугацаанд материалтайгаа бүрэн танилцаж амжаагүй тэгээд үндсэндээ ер нь өдөр хуралдсан гэж хэлж болно. Тэгэхээр энд асуудлуудыг бүрэн шийдвэрлэж чадаагүй гэж би үзэж байгаа. Гаднын хөрөнгө оруулалт, олон улсын эрх зүйн харилцааны талаарх ойлголтгүй хүмүүс маань зарим нэгэн тайлбаруудаа бүтэн ойлгоогүйгээс шийдвэр гаргасан байна.

Тэгэхээр би бол энэ өөрөө энэ чинь Цөмийн энергийн тухай хууль чинь аягүй том хууль. Тэгэхээр энэ ажлын хэсгийг бол илүү хугацаа авч, илүү материалтайгаа танилцаж, цаашаага илүү нухацтай хандахгүй бол энэ өөрөө том хууль учраас надад энийг ажлын хэсэг рүү буцаах горимын саналтай байна.

Г.Тэмүүлэн: Хэлэлцэх асуудлыг хойшлуулъя гэсэн саналыг гаргаж байгаа юм байна Амар гишүүн тээ?

Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Гишүүддээ өдрийн амгаланг айлтгая. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас яаралтай горимоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улмаар ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг маань сая хэлж байна өчигдөр 1 удаа хуралдсан гэсэн мэдээлэлтэй ингээд ажлын хэсгийн томьёолол бэлтгэгдэж орж ирсэн байна.

Тэгэхээр миний хувьд бас энэ ажлын хэсэгт өнгөрсөн Баасан гарагт 6 хуудас, 3 зарчмын асуудлаар бас санал хүргүүлсэн байгаа. Тэгээд энэ ажлын хэсгийн түвшинд хэр яригдаж яасан юм? Тэгээд уг нь ажлын, би нөгөө чуулган дээр ч гэсэн хэлэлцэх эсэхийг асуудлыг хэлэлцэхэд хэлж байсан. Зарчмын хувьд би дэмжээд байгаа хэлэлцэх эсэхийг.

Тэгэхдээ энийг нэлээн тийм нухацтай авч үзэхгүй бол болохгүй асуудлууд бас байгаад байгаа юм. Тухайлбал, миний өгсөн санал дотор энэ хуульд орж байгаа татварын чиглэлийн асуудлууд нь Оюу толгойн Лондонд явж байгаа татварын маргаанд айлын талд эергээр нөлөөлж өгөхөд дэм болж болзошгүй гэсэн ийм санал өгчхөөд байгаа юм. Тэгээд энэ дээр тооцоо судалгаа, хууль зүйн би тайлбар нэхээд авч чадаагүй. Энэ бол 20 их наяд орчим төгрөгийн асуудал.

Хоёрдугаарт, Монгол Улсын энэ тогтвортой хөрөнгө оруулалтын гэрээнүүд нь урьд өмнө нь байгуулсан болон ирээдүйд байгуулах Монгол Улсын стратегийн гэрээнд шууд нөлөөлдөг. Тэгэхээр ойрын үед бас жишээлбэл, БНХАУ-ын Чайна Энержи групптэй бид нар урт хугацааны бас томоохон гэрээ ярьж байгаа шүү дээ.

Тэгэхээр энд бас нэг улсад үзүүлж байгаа татварын хөнгөлөлт чөлөөлөлт нь нөгөө улсад тэр дотроо иж бүрэн стратегийн түнштэй улсад өөр өөрөөр ялагдаад байхгүй нэг зарчмаар ханддаг олон улсын зарчим байгаад байгаа юм.

Тийм учраас энэ асуудлыг нөгөө нэг Батын Хурц чинь ярих юм уу яах юм гээд энд томроод байсан биз дээ. Тэр шиг энэ зарим юм нь илээр бас ярьж болохгүй байгаад байгаа байхгүй юу. Нөгөө Байнгын хорооны хурал ил яваад байгаа учраас. Тэгэхээр ажлын хэсгийн түвшинд л нэлээн нухацтай энэ тооцоо, судалгаануудыг авч үзэж яримаар байгаа юм. Тийм ч учраас би бичгээр санал өгсөн юм. Тэгээд би тэр саналажлын хэсэг дээр яригдаад тайлбар юм.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүнд 1 минут нэмье.

Б.Энхбаяр: 1 өдрийн дотор ингээд хэлэлцэх эсэхийг нь шийдээд 7 хоногийн дотор босон суугаад бушуу туулай болчих вий гэсэн ийм болгоомжлол байгаад байна л даа. Тийм учраас энийг ажлын хэсгийн хэлэлцүүлэг дээр буцаагаад ажлын хэсэг дээр бас нэлээн сайн яриулж орж ирэхгүй бол одоо наад Төсвийн байнгын хороо чинь жишээлбэл, АМНАТ-ыг 9 хувь болгоно энэ тэр гээд бас энэний ард юу байгаад байгаа юм. Тооцоо, судалгаа нэхсэн. Бид нар санал өгөхөд яг бэлэн биш байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас ажлын хэсгийн буцаагаад, дахиж ажлын хэсгийг хуралдуулах боломж олгож өнөөдрийн хуралдааныг хойшлуулбал яасан юм бэ? Хэлэлцэх асуудлаас асуувал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Г.Тэмүүлэн: 2 гишүүн ажлын хэсгийн ажилтай холбогдуулж хэлэлцүүлгийг хойшлуулах саналыг бол бас гаргаж байна. Энэ дээр тодорхой ажлын хэсгийн дарга Пүрэвдорж гишүүн тодорхой тайлбар мэдээлэл өгөх үү? Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр ажлын хэсэг эхний мэдээллийг 3 дахь өдөр, өнгөрсөн 7 хоногийн 3 дахь өдөр сонссон. Энэ сонсоход ажлын хэсгийн гишүүн Анар өөрөө байгаад энэ дээр бас тодорхой, бид нар илүү материал байхгүй. Бид нарт ерөөсөө энэ хуулиас илүү материал байхгүй.

Тэгээд яах вэ, мэдээж яг энэ хуультай холбоотой, яг энэ цөмийн энергитэй холбоотой бас тодорхой материалууд, хэвлэмэл материалуудыг бид нарт өгсөн. Тэрнийхээ хүрээнд бид нар бас энэ асуудлаа хэлэлцсэн байгаа. Тэгээд танаас, Анар гишүүнээс 4 дэх өдөр, 5 дахь өдөр 2 өдөр дараалан ажлын хэсгийн дэд ажлын хэсгээс тодорхой саналуудыг өгөөч гэж хүссэн. Гэвч өгөөгүй. 1 дэх өдөр над руу албан бичиг ирүүлсэн байгаа. Тэр албан бичиг дээрээ материалаар хангаж өгөөч гэдэг ийм зүйлийг хэлсэн.

Тэгэхээр өчигдөр ажлын хэсэг хуралдаад Анар гишүүний гаргасан болон бусад гишүүдийн гаргасан бүх саналуудаар бүгдэнг нь саналыг нь хураагаад, шийдээд явсан байгаа гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт, нь Баттөмөр гишүүн тодорхой яг энэ татварыг нь тогтворжуулах асуудлаар албан бичиг ирүүлсэн. Тэгээд албан бичиг дээр уучлаарай Энхбаяр гишүүн. Энхбаяр гишүүн яг энэ тодорхой албан бичиг ирүүлсэн. Тэгэхдээ энэ дээр тодорхой санал байхгүй байгаа. Ингэж ингэх ёстой, тэгэх ёстой, ийм байгаа, тийм байгаа гэж байгаа болохоос тодорхой санал байхгүй байгаа.

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар, чуулганы тухай хуулиар энэ ажлын хэсэг хуралдаад тодорхой саналуудаа шийдээд, санал хураалтаа хийгээд явсан байгаа. Тэгэхээр одоо дахиад энийг хойшлуулж болохгүй гэж би үзэж байгаа.

Яагаад гэвэл 2 гишүүний гаргах санал шууд өнөөдөр Байнгын хороон дээр санал хураалгаад шийдэх боломжтой. Дээрээс нь Эдийн засгийн байнгын хороон дээр, хуралд санал гаргаад шийдэх боломжтой байсан, ажлын хэсэг дээр санал хураагаад шийдэх боломжтой байсан. Мөн түүнчлэн Төсвийн байнгын хороон дээр асуудлаа тавиад шийдэх боломжтой байсан.

Тийм учраас дээрээс нь Анар гишүүний, бас Батнайрамдал гишүүн болон Уянга гишүүнтэй гаргасан саналуудыг, тодорхой саналууд гаргасан. Тэрний зарим нь дэмжигдсэн, зарим нь ажлын хэсэг дээр унасан байгаа. Тийм учраас энэ ажлын хэсгийг дахин хуралдуулах шаардлагагүй.

Өөрөөр хэлбэл, та хоёр хоёулаа энэ Байнгын хороон дээр бас тодорхой саналуудаа гаргаад энийгээ шийдвэрлүүлэх боломжтой гэж үзэж байна. Тийм учраас энэ ажлын хэсэгт буцаах саналыг дэмжихгүй байгаач гэж. Өөрөөр хэлбэл, энэ хоёр гишүүний энэ санал өөрсдөө энэ Байнгын хороон дээр гаргаад хураалгах боломжтой гэж хуулиараа байгаа. Тийм учраас гишүүдийг бас энэ буцаах саналыг битгий дэмжээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн болон Энхбаяр гишүүд горимын санал гаргасан. Хэлэлцүүлгийг хойшлуулах саналыг бол гаргасан байгаад байгаа. Энэ асуудлаар санал хураалтыг явуулъя. Анар гишүүн болон Энхбаяр гишүүдийн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хойшлуулах саналыг дэмжье гэдгээр санал хураалт бол явуулах нь байна. Номтойбаяр гишүүн, ажлын хэсгийн гишүүн горимын санал байгаа. Номтойбаяр гишүүний микрофон өгье. Номтойбаяр гишүүний микрофон.

Н.Номтойбаяр: Нэг хөгийн л юм ярих гээд байна даа би. Би өөрөө ажлын хэсгийн гишүүн. Тэгэхдээ энийг Засгийн газраас нэн яаралтай горимоор оруулж ирсэн. Үүгээрээ ч бас асуудал дагуулаад байна л даа. Өчигдөр ажлын хэсэг хуралдсан, ахиц амжилт гарсан. Тэгээд дэд ажлын хэсэг бас боломжийн л аятайхан ажиллаад байх. Харамсалтай нь ажлын хэсгийн бүрдүүлж байгаа Их Хурлын гишүүд хангалттай бас бүрдэж чадсангүй. Янз бүрийн эрхгүй байх шалтгаан байсан л байх.

Тэгээд энд хэд хэдэн зүйл ажиглагдаад байна Засгийн газраас өргөн барьсан хуулийн өөрчлөлтийн хэмжээнд л хэлэлцэх зохицуулалттай. Гэтэл энэнээсээ нэгт халиад байна. Дээрээс нь хууль зүйн хувьд ийм хоёрдмол утга агуулгатай тэгээд ойлголтын зөрүү гарах, хэтдээ энэ хууль дээр үндэслээд байгуулагдах хэлэлцээр нэлээн хэрүүл маргаан дагуулах иймэрхүү зүйлүүд байна.

Дээрээс нь яг үнэндээ Их Хурлын гишүүд бидний хувьд аливаа гаргаж байгаа нэг санал дээр итгэл үнэмшилтэйгээр байр суурьтай байх ийм мэдлэг, боловсрол нь ч бас алга байна. Хангалттай цаг хугацаа нь ч бас алга байна. Гэхдээ хойшлуулъя гээд цаг наргүй явчих нь буруу. Цаг бол байгаа. Энэ чинь маргааш чинь чуулганаар эхний асуудал байгаа биз дээ тээ?

Тэгэхээр гаргалгааны хувьд цаг заагаад, эсвэл Тэмүүжин гишүүнд чинь завсарлага авах эрх байгаа тээ, байгаа шүү дээ энд бүлгийн дэд дарга. Тэгээд өнөөдөр үргэлжлүүлээд нэг суувал яадаг юм. Тэгээд үдээс хойшдоо ч юм уу нэг хуралдаад. Яг ажлын хэсгийн гишүүний хувьд надад бол тийм итгэл бүрдчихсэн зүйл яг байхгүй байгаад байна. Үнэнээ л хэлье.

Тэгэхээр ажлын хэсгийн даргадаа бас хүндэтгэлтэй хандаж байна. Нэлээн хичээл чармайлт бас гаргаад байгаа. Нэг дахиад суусан нь зөв байх. Тэгэхдээ хугацаатай. Маргааш чинь чуулган гээд даргын зөвлөлийн хурлаас чинь шийдчихсэн шүү дээ. Нэлээн л юмнууд болно доо. Одоо чинь 1 өнгөрч байна гэдэг чинь цаг уул нь байгаа л юм байна.

Г.Тэмүүлэн: Гишүүдийн гаргасан саналаар ямар ч байсан санал хураалтыг явуулъя. Хоёр гишүүн дээр Анар гишүүн, Энхбаяр гишүүн санал гаргасан хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн санал байна. Та юу юу?

Санал хураая. Анар гишүүн болон Энхбаяр гишүүдийн гаргасан горимын саналаар хэлэлцүүлгийг хойшлуулах саналыг дэмжье гэдэг томьёоллоор бол санал хураах нь байна. Гишүүд хариуцлагатай хандаарай. Санал хураалт дэмжье.

Горимын санал дэмжигдсэнгүй. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ингээд ажлын хэсгийг танхимд оруулаарай. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Төсвийн байнгын хорооны гишүүн танилцуулахаар байгаа. Батжаргал гишүүн хүрэлцэн ирсэн байна уу? Мөн Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай танилцуулахаар байгаа. Алтаншагай гишүүн ирсэн үү?

Энэ хооронд ажлын хэсгийг танилцуулж байя. Ажлын хэсгийн гишүүд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан сайд. Туваан сайд байгаа юу? Учрал сайд байна. Бат-Эрдэнийн Хулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Дорждэрэмийн Цолмон, Нармандахын Жамьянхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Зэнээмядарийн Батбаяр Усны газрын дарга, Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга, Доржбалын Далайжаргал Мон-Атомын гүйцэтгэх захирал, Амарсайханы Алтанхундага Мон-Атом компанийн Геологи, уурхайн албаны ахлах менежер, Дашдаваагийн Сугарсүрэн тус компанийн Захиргааны удирдлагын албаны дарга, Норовбаярын Тэгшбаяр тус компанийн мэргэжлийн шинжээч, Галсангийн Жамсрандорж тус компанийн Геологи-Эрдэс судлалын ухааны доктор, Яндагийн Ганболд тус компанийн мэргэжлийн шинжээч, Лхасүрэнгийн Жаргалсайхан мөн тус компанийн бас мэргэжлийн шинжээч гэсэн байна. Дашдоржийн Баярхүү тус компанийн мэргэжлийн шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Хоёр Байнгын хорооны санал, дүгнэлтүүдийг танилцуулах зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор танилцуулах гишүүд хүрэлцэн ирсэн үү? Орж ирээгүй байна уу? Тэгье, гишүүдэд санал, дүгнэлтүүдийг тараачихсан байгаа хоёр Байнгын хорооны санал, дүгнэлтүүд.

Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг бас байгуулагдаж ажилласан. Ингээд Байнгын хороо болон нэгдсэн чуулганы хуралдаанд хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах аж үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Ингээд ажлын хэсгийн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын дэд дарга, ажлын хэсгийн ахлагч Пүрэвдорж гишүүн танилцуулна. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 1-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 233 дугаар захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Г.Тэмүүлэн, Ч.Анар, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Ж.Баясгалан, Н.Номтойбаяр, Б.Уянга, Г.Уянгахишиг болон холбогдох бусад албан тушаалтнууд орж ажиллалаа.

Ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 6, 12-ны өдрийн хуралдаанаар, 6 болон 12-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэж зарчмын зөрүүтэй саналын томьёолол 8, төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх саналын томьёоллыг хэлэлцэн дэмжиж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тухайлбал, төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг Монгол Улсад үр өгөөжтэй байх хувилбарыг харгалзан Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох,

Хоёрт нь цацрагийн хамгаалалтын хөтөлбөрт түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг улсын байцаагчаар хянуулж баталгаажуулан мөрдөх, баталгаа шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг олон улсын хөндлөнгийн шинжээчээр хянуулах зэрэг болно.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт н бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж даргад баярлалаа. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-т зааснаар энэ Байнгын хороо хуулийн төслийг бол зүйл тус бүрээр хэлэлцэнэ гэж заасан байгаа. Энэ дагуу хуулийн төслийг бол зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Ингээд тухайн зүйлтэй холбогдуулаад бол хууль

санаачлагчаас гишүүд бол бас асуулт асууж болно гэсэн ийм дэгийн бол заалттай байгаад байгаа.

Ингээд зүйл бүрээр нь бол ингээд хэлэлцээд явъя.

Нэгдүгээрх нь Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Гишүүд нэрсээ өгөөрэй 1 дүгээр зүйл 1 дүгээр зүйлтэй холбогдуулж зөвхөн. Саналын томьёоллууд гишүүдэд тараагдсан байгаа байх.

Шижир гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуулт, ирсэн дарааллаар юм байна шүү дээ. Ганбаатар гишүүнээр таслаад, Шижир гишүүн асуулт асуух юм байна.

Ө.Шижир: Ер нь 7 сарын 2-нд тангараг өргөснөөс хойш ийм иймэрхүү хуулийн төсөл дандаа яаралтайгаар л орж ирдэг болчихлоо л доо. Тэгээд энэ горимоо бас эргэж харж байх байхгүй бол ингээд л бүх асуудал яаралтайгаар ороод ирдэг л ийм л хэлбэр рүү орчихлоо. Тэгэхээр энэ дээр бас анхаарах хэрэгтэй.

Ер нь бол төр өөрөө нэгэнт ашигла гээд зөвшөөрөл өгсөн бол тэр зөвшөөрлөө хамгаалдаг байх ёстой. Дан ялангуяа энэ уурхай яам, энэ төрийн байгууллагууд. Тэгэхгүй энэ зөвшөөрлөө хамгаалаагүйгээс болоод одоо бид нар уул уурхайгаас хамааралтай амьдардаг улс болчихсон мөртөө уул уурхайгаа хамгийн их эсэргүүцдэг. Тэгээд тэр нөхцөл байдлуудаа дандаа жагсаал цуглаан, үймээн самуун, зохион байгуулалттай байдлаар асуудлуудыг шийддэг бас ийм болчихоод байна.

Тэгэхээр энэ төсөл явахдаа ямар ямар саад бэрхшээлийг туулах вэ хэлж мэдэхгүй байна. Бас нэлээн л их саад бэрхшээл рүү орох байх. Надад нэг асуулт байгаа нь жишээ нь энэ цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч, ашиглалт малтмалын нөөц ашигласны төлбөр дээр 0-130 ам.доллароор ангилж, 0-9 хувь хүртэл нэмж тооцно гээд ийм заалт орчихсон байгаад ийм агуулгаар. Тэгтэл дэлхийн түүхэнд уран чинь өөрөө 300 доллар хүрч байсан, 150 доллар хүрч байсан, одоо 200 доллар хүрч байсан түүх байдаг юм байна. 2006 онд чинь 300 доллар хүрч байсан юм байна, 2011 онд чинь 180 доллар хүрч байсан юм байна. Тэгэхээр энэ дээр энэ 0-130 ам доллароор ингээд хайрцаглачихаар 130 доллароос дээш өсвөл яах юм гэдэг дээр хариулт авмаар байна.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Туваан сайд уу? Хаанаас ажлын хэсгээс Туваан сайд. АМНАТ-тай холбоотой, түүхий эдийн үнэтэй холбоотой, 130 ам.доллароос дээшээ гарвал яах вэ гэдэг асуудал байсан. Туваан сайдын микрофоныг өгье.

Ц.Туваан: Шижир гишүүний асуултад хариулъя.

Энэ яаралтай горимоор Засгийн газраас оруулж ирж байгаа үнэн. Тэгээд Монгол Улсад хийгдэх гэж байгаа хоёр дахь гаднын, гуравдагч орны хөрөнгө оруулалттай гэрээ. Энэ гэрээ маань бас харьцангуй амжилттай явж байгаа. Эхэлсэн цагаасаа хойш бас нэлээдгүй хугацаа туулаад явж байгаа. Тэгээд бид бүхэн бас энэ тал дээрээ нэлээн гэрээний үйл ажиллагаагаа бас урагшлуулахын

тулд зарим эрх зүйн асуудлуудыг шийдэх ийм зайлшгүй шаардлага байгаа. Тийм учраас бас яаралтай горимоор орж ирж байгаа гэдгийг хэлье.

Бид нар хуульд байгаа ялангуяа 19 оны Үндсэн хууль дээр орсон маш чухал бидний хамгийн дагаж мөрдөх эцэг хууль бол Үндсэн хууль. Энэ Үндсэн хуулийн 6.2 дээр энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг батал, энэ хуульдаа тэр сандаа уул уурхайн баялгаас ашигт малтмал ашиглаад олсон орлогыг хуримтлуул, үүгээрээ дамжуулаад ард иргэд рүүгээ, ялангуяа энэ эрүүл мэнд, боловсрол, нийгмийн асуудал руу нь чиглэсэн асуудлуудаа шийдгэсэн ийм концепцтой хууль батлагдсан. Энэ дотор байгаа нэг хамгийн чухал бид нарын өнөөдөр барьж байгаа концепц бол стратегийн ордыг ашиглавал энэ үр өгөөжийн дийлэнх буюу 50 дээр нэмэх, 50-аас дээш хувь нь энэ Монголд ард түмэнд чиглэсэн байдлаар шийдэгдэх ёстой гэдэг энэ концепцыг бид нар барьж явж байгаа.

Тийм учраас өнөөдөр хуульд байгаа төрийн өмчөөр хайгуул хийгдсэн ордын 51 хүртэл, хувийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн ордын 34 хүртэл хувийг нь бол төрд эзэмшихээр ийм хувь байгаа. Тэгэхээр одоо бид нарын хувьд энэ өмнө нь Оюу толгойн гэрээг байгуулсан, шуудхан хэлэхэд анхны гаднын хөрөнгө оруулалттай гэрээ. Энэ дээр бас янз бүрийн шүүмжлэлүүд байдаг. Манай ажлын хэсэг бол нэг талдаа энэ Оюу толгойн гэрээгээ тавиад, нөгөө талдаа энэ Орана-тай байгуулах энэ гэрээгээ тавиад ажиллаж байгаа. Тэгэхээр бид бүхэн бас алдаа оноо гаргахгүйн төлөө ингээд ажиллаж байгаа.

Энэ хууль оруулж ирж байгаа үзэл баримтлалын гол санаа нь энэ 34 хүртэлх хувийг давуу эрхийн хувьцаагаар солих, тэгээд энэ АМНАТ-өөр солих гэдэг энэ л концепц явж байгаа. Ингэж байж түрүүний тэр 6.2-т заасан заалт хангагдана.

АМНАТ-ын хувьд 3 төрлийн АМНАТ байгаа. Энэ дээр бол бүх ашигт малтмал дээр суурь АМНАТ 5 хувь, тусгай АМНАТ бол ерөнхийдөө энэ 5 хувь байхаар Хөрөнгө оруулалтын гэрээндээ ч гэсэн 2 тал ерөнхийдөө иймэрхүү байдлаар ярьж яваа.

Өсөн нэмэгдэх АМНАТ бол саяын таны хэлсэн үнэтэй холбоотой асуудлаар явж байгаа. Үнэ өндөр байх тусам өсөн нэмэгдэх АМНАТ 9 хувь руугаа дөхөх ийм кон.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Ер нь ингээд бид нар уурхайгаас хамааралтай улс болчихсон. Нийт экспортын чинь 87 хувийг зөвхөн алт, зэс, нүүрс гаргаж байна шүү дээ. Тэгэхээр бид нар ганцхан энэ 3 бүтээгдэхүүнээр хөгжихгүй үе. Тэгэхээр нэмж энэ ураныг ашиглах олборлох нь зөв. Тийм учраас Монголд гацсан байгаа бүх төслүүд хөдлөх ёстой. Яг 4 замын түгжрэл шиг бие биеэ чагтлаад түгждэг цаашаа хоосон байдаг ийм л нөхцөл байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ бүгд явах ёстой.

Гэхдээ миний яг тодорхой болж асуусан юм бол 130 доллароос дээш гарч ирсэн тохиолдол дэлхийн түүхэнд маш олон байна. Хамгийн дээд тал нь 300 доллар хүрч байсан тохиолдол байн.а 150-180 долларын дундажтай байсан нь бас он жилүүд байна. Тэгэхээр 300 доллароос, 130 доллароос дээш гарчихаар 9 хувь байгаад ингээд 130 доллар блоклож байгаа нь ямар учиртай юм бэ л гэж асууж байгаа юм Туваан сайд аа.

Г.Тэмүүлэн: Туваан сайд хариулъя. Ажлын хэсэг үү? Хэн хариулах вэ? Гараа өргөөрэй. Наранцогт дарга 7 номер.

С.Наранцогт: Шижир гишүүний асуултад хариулъя.

Тэр 300 доллар хүрч байгаа нь нөгөө килограммын үнэ. Бидний энэ хуульд орж байгаа АМНАТ-ын хүснэгт фунтээр тооцож байгаа. Тэгэхээр 2007 онд 300 орчим доллар байсан энэ нь бол фунтээр тооцох юм бол 140 доллар хүрч байгаа. Бид нар бол олон улсын цөмийн энергийн институтээс гаргасан үнийн төсөөллийн судалгаан дээр бас үндэслэж ингэж гаргаж байгаа юм. Тэгэхээр үнэ бол мэдээж энэ бүтээгдэхүүний нийлүүлэлт бол эрэлтээсээ хомсдолтой явахаар байгаа. Энэнээс үндэслээд тасралтгүй үнэ өснө гэсэн төсөөлөлтэй. 2030, 2035 онд 130 доллар хүрээд тэгээд цаашаа ийм тогтмол өсөх ийм прогнозтой байгаа юм. Тэгээд 130 доллароос дээш 19 хувийн АМНАТ төлөөд явна гэсэн ийм ийм тооцооллоор ингэж гарч ирж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль маш чухал хууль. Энэ бол манай улсын эдийн засагт, мөн валютын орлогод, мөн ажлын байр бий болгоход маш чухал ийм төсөл болж байгаа учраас зарчмын хувьд идэвхтэй дэмжиж байгаа.

Тэгээд энэ хуулийн яг нэг яг маш чухал заалт байгаа. Маш чухал зарчим тулгуур зарчим гэж хэлж болохуйц. Энэ бол 1 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг дэх тэр гадаад улсын цацраг идэвхт хаягдал, ашигласан цөмийн түлшийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрт булшлахыг хориглоно гэсэн энэ заалт. Энэ маш чухал.

Яагаад гэвэл 1997 оны олон улсын атомын энергийн тэр гэрээн дээр энэ улс орнууд ингээд яг энэ заалтыг баримталж, ийм өөрийнхөө улс оронд ийм цөмийн хаягдлыг булшлахгүй гэдэг боловчиг 2 улс хоорондоо тохирсон тохиолдолд энэ гэрээний энэ заалтыг хэрэглэхгүй байж болно гэсэн ийм заалттай байдаг.

Тэгэхээр энэ заалт энэ хуульд орсноороо маш чухал бөгөөд энэ их цөм заалт гэж би ойлгоод байгаа. Ийм учраас ажлын хэсгээс асуухад энэ заалтыг тойрсон янз бүрийн өөрчлөлт байхгүй биз дээ? Яг энэ чигээрээ орно биз дээ? Энэ ямар нэгэн маргалдаж байгаа зүйл байхгүй биз дээ гэсэн ийм асуулт байна. Энэ их чухал учраас асууж байна.

Г.Тэмүүлэн: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. 4 номер ажлын хэсэг. Албан тушаал, нэрээ танилцуулаарай.

Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Техник, технологийн хэлтсийн дарга Намчинсүрэн.

Г.Намчинсүрэн: Ер нь Үндсэн хуулийг баталсан Үндсэн хуулийг дагаж гарахдаа холбогдох хууль тогтоомжид бол өөрчлөлт оруулахыг бол даалгасан байдаг. Энэ дээр бол яг энэ саяын энэ хуульд томъёолоод оруулчихсан байгаагаар гадаад улсын цөмийн хаягдал болон юуг Монгол Улсаар нэвтрүүлэхгүй

булшлахыг бол хориглоно гэж Цөмийн энергийн хуульд тусгаж өгөхийг бол даалгасан байдаг.

Мөн түрүүн бид бол бас араас нь, өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар манай яамнаас бол 3 конвенцод, олон улсын 3 конвенцод элсэх асуудлыг бас сая Засгийн газрын хуралдаанаар дэмжүүлсэн байгаа. Ирэх 7 хоногоос ч юм уу бас дараагийн олон улсын конвенцод нэгдэн орох асуудлуудыг бас Улсын Их Хуралд танилцуулаад өргөн бариад явна.

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ нэгдүгээр юутай холбогдуулаад, энэ АМНАТ-тай холбогдуулаад асуулт асууя гэж бодож байгаа юм. Энэ би харж байна л даа. Энэ дэлхийн зах зээлийн үнээсээ хамаараад АМНАТ-аа янз бүрээр тавьж өгсөн байна. 9 хүртэл хувиар тавьж өгсөн байна. Ер нь АМНАТ-аа бид нар ингээд харьцангуй нэмж өгөөд ер нь хувьцаа авна гэж явж байхынхаа оронд АМНАТ дээрээ илүү ач холбогдол өгч байх нь бизнес талаасаа маш зөв хандлага байж байгаа юм.

Яагаад гэвэл хувьцаа гэдэг бол дагуулаад хөрөнгө оруулалт хийх шаардлага гардаг, өөрөө санхүүгийн ачаалал дээр бууж байдаг учраас энэ бол шууд манай баялаг учраас манай баялгийг ашиглаж л байгаа бол ашиг олсон, эс олсноос үл хамаараад бид нар авч байх ёстой. Нөгөө эзний хувьд хүртэж байгаа манай хувь хэмжээ гэсэн үг. Тэгэхээр энэ дээрээ нэлээн өндөр 9 хүртэл тавьж өгч байгаа нь би зөв гэж бодож байна. Зүгээр тооцооны хувьд нэг юм асуумаар байна. Одоо энэ чинь ингээд ийм хууль орж ирээд та нарын ярьж байгаа гэрээ биш цаашдаа өшөө зөндөө төслүүд орж ирж магадгүй, зөндөө гэрээнүүд орж ирж магадгүй.

Тэгэхээр энд нөгөө хугарлын цэгийг яаж тооцсон бэ? Өөрөөр хэлбэл, энэ чинь ингээд хууль болчих юм чинь жигд үйлчлээд явчихна шүү дээ. Тэгээд prohibitive тариф гэж байдаг өөрөөр хэлбэл, харахад хориогүй юм шиг. Тэгээд та нар бизнес хийж болно, ийм хэмжээний юу бид нар АМНАТ-аа авна гээд хэлчихсэн байдаг. Тэгсэн тэрнээс дээш гараад явангуут цаашаа бизнес хийх нь хориогүй мөртөө, бизнес хийх нь өөрөө утгагүй болоод, хөрөнгө оруулалт хийх нь өөрөө утгагүй болоод эхэлдэг. Тэр нь тэгэхээр хориогүй мөртөө тэр тавьж байгаа хэмжээгээ дээрээ бодит байдал дээрээ хорьсон үйлчлэлтэй болж таардаг. Тэгэхээр тэр prohibitive trash hold буюу тэр яг хэзээ энэ бизнесийг дэмжих биш харин хорих тал руугаа шилжсэн ийм түвшин байх вэ гэдгийг нь та нар тооцож үзсэн үү? Яагаад гэвэл энийг ингэж тооцож үзэж энэ дээр оруулж ирэх нь маш чухал байгаа юм.

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүний асуултад 8 номер. Албан тушаал, нэрээ хэлээрэй.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Цогтбаатар гишүүний асуултад хариулья.

Нийт 3 төрлийн АМНАТ байгаа. Суурь, өсөн нэмэгдэх гээд. Энэ суурь өсөн нэмэгдэх хоёр нь ингээд хуульчлагдаад таны хэлж байгаагаар цаашдаа жигд үйлчлээд явна.

Тусгаар рояалтигийн хувьд тухайн ордын онцлогоос хамаараад Улсын Их Хурал тухай бүрд нь ингээд тогтоож явна гэж байгаа юм. Тэгэхээр яах вэ, тусгаар рояалтийн хувь хэмжээг. Зөвхөн суурь өсөн нэмэгдэхийг зөвхөн энэ хоёрыг нь бодоод үзэхэд дэлхийд бүр онцгой гойд өндөр биш, ерөнхийдөө өндөрдөө орно. Тухай тухайн үедээ тэр ордын нөхцөл байдал, тээвэр, эдийн засаг, технологи, горимоос нь хамаараад тусгаар рояалтийг хэлэлцээрийн явцад өгөөжийн түвшинд нь харгалзаж байгаад тогтоох боломжтой.

Хугарлын цэгийн хувьд бид яг энэ компанитай хийж байгаа хэлэлцээрийн хүрээнд ер нь 52 доллар, 1 фунт нь 52 доллар байхад энэ компани, энэ төсөл өөрөө үр ашиггүй болно гэдэг ийм хугарлын цэгтэй байсан. Ийм ч үүднээсээ бид нар өсөн нэмэгдэх роялтийн тооцогдож эхлэх нь 50 доллароос, 50-аас доош өсөн нэмэгдэх байхгүй гэсэн ийм байдлаар оруулж ирсэн. Урьдчилан тохирсон байгаа хувь тусгаар рояалтигийн хувь хэмжээн дээр мөн 50-аас доош 5 хувь нь буурахаар ингэж оруулсан байгаа.

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүн болсон уу тээ? Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асууя. Энэ дээр гадаад улсын цацраг идэвхт хаягдал ашигласан цөмийн түлшийг Монгол Улсад булшлахыг хориглоно л гэж байна. Гадаад улсынхыг хориглодог юм байж. Энэ сонгуулийн өмнө энэ бужигнаад л явчихад л би материалуудыг нь авч байсан юм.

Тэгэхэд яг Монголдоо энэ шар нутаг үйлдвэрлээд хог хаягдал нь бага цацрагт идэвхт бол 1 жилдээ 250 тонн, ахуйн цацраг идэвхт хог хаягдал бол 600 тонн, аюултай хог хаягдал 750 тонн, би энэ доторх нь нарийвчилсан задаргааг нь яриад яах вэ, эднийг булшлах ёстой, шатаах ёстой, аюултай хог хаягдлыг үйлдвэрт хийх, үйлдвэрт барих ёстой, Үгүй, энэ Монголчууд чинь ийм үнэ цэнгүй хог хаягдалдаа дээрэлхүүлж болохгүй ард түмэн шүү дээ. Энэ дээр Цөмийн энергийн комисс, Байгаль орчны яам яг энэ эрх зүйн орчин бүрдүүлж байгаа үед энэ асуудал дээр ямар зүйл, заалт оруулж ирж байгаа вэ? Та нар энэ дээр заавал аюултай хог хаягдал үйлдвэр барих ёстой. Хэдэн Монголчууд ажиллана. Хамгийн гол нь эрүүл ахуй.

Хоёрдугаар асуулт, хүхрийн хүчил гэж та нар их гоё л юм яриад байх юм. Долоож болно, ууж болно гээд л PR түрүүгээрээ явдаг юм байгаа биз. 215 тонн жилдээ хүхрийн хүчил хэрэглэнэ шүү дээ. 15 вагоныг өдөрт ашиглана шүү дээ найзууд аа. 15 вагон хүхрийн хүчил наад үйлдвэр чинь ашиглана шүү дээ. Үгүй ээ одоо юу бодож байна? Зардлын байна шүү дээ, энэ зардлын том том тоо л яриад байна 50 сая доллар жилдээ зарцуулна гэж байгаа.

Тэгээд манайх ГОК дээр элементийн хүхэр үйлдвэрлэнэ гээд л яриад л яваад байдаг. Энэ хүхрийн хүчлийн үйлдвэрийг Монголд барих талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хариуцаж байгаа хүмүүс нь эх орноо бодсон тийм шийдэл гарсан уу? Үгүй, чимээгүй л хараад суугаад байх юм. Өнөөдөр Байгаль орчны яамнаас энэ дээр сэтгэл өвдөж байгаа юм байна уу, дүгнэлт гаргасан уу? 15 вагон хүхрийн хүчлийг хөрс рүү шахна шүү дээ. Та нар 200-гийн бочкитой юм л цацна гэж бодоод байх шиг байна. Инээд хүргэж, ёстой тэр тайлбарууд аймаар тайлбар.

Тэгэхээр хүхрийн хүчлийн ядаж үйлдвэрээ барьж, Нарантуулын зах шиг ингээд л Хятадаас байна уу, Оросоос байна уу ингээд л дандаа авдаг биш энэ үйлдвэр Монголд баригдах уу? Энэ хоруудыг хоргүйжүүлэх талаар монголчууд энэ аюулгүй байдалтай байх тал дээр Байгаль орчны яам ямар дүгнэлт гаргасан бэ? Хэдэн эрдэмтэн, хэн хэн гэдэг нэртэй эрдэмтэд гарын үсэг ямар ч аюулгүй гээд зурсан гарын үсгүүдийг нь хэлж өгөөч. Хэн хэн? Одоо бол ер нь хар толгойгоороо л хариуцна шүү дээ. Оюу толгой дээр алдсан л гэж байгаа. Хариуцах хүн байхгүй.

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүн хоёр асуулт асуулаа. Аж үйлдвэрийн яам, Байгаль орчны яа, Туваан сайд үйлдвэртэй холбоотой асуудал дээр хариулах уу? Туваан сайдын микрофоныг өгье.

Ц.Туваан: Мэдээж энэ цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах асуудал ярьж байгаа. Тэгэхээр энд мэдээж бас яг өөрөө энэ ашигт малтмал нь хоргүй ч гэдэг юм уу тийм асуудал яригдахгүй. Тэгэхээр энэ дээр манай Цөмийн энергийн комиссоос энэ Ганбаатар гишүүний аюултай хог хаягдалтай холбоотой, ялангуяа энийг яаж хоргүйжүүлэх юм, өчигдөр бид нар ажлын хэсэг дээр яасан ямар ямар шат дамжлагуудыг дамжиж эцсийн шатанд нь булшлах вэ гэдэг асуудал дээр нэмэлт хариулт өгчхөөрэй. Байгаль орчны яам мөн адилхан.

Хүхрийн хүчилтэй холбоотой асуудал. Энэ дээр энэ технологи нь газрын хөрсөн доор уусган баяжуулах технологи байгаа. Тэгэхээр ерөнхийдөө энэ манай энэ Зөөвч Овоо-ны ордын нөхцөл байдал бол хоёр талаараа шаварлаг хөрсөөр бүрхэгдсэн ийм орчин хязгаарлагдмал ийм битүү орчин байгаа. Энгийн хар үгээр хэлэх юм бол бид нар байранд амьдардаг улсууд паар угаах гэж юм байдаг шүү дээ, паар руугаа содтой уусмал шахаад тэр паарныхаа зэвийг арилгах, манай жолооч нар мэдэж байгаа энэ мотор цэвэрлэх гээд мотор руугаа бодис хийж байгаад мотороо асааж байж байгаад буцаагаад тэр цэвэрлэгдсэн бодисоо ингээд буцаагаад авдаг. Иймэрхүү байдлаар ашиглаж болох буюу газрын доод талын тэр хязгаарлагдмал нөхцөлд нь хүхрийн хүчлийн шингэрүүлсэн сул уусмалыг шахаж энэ уранаа барьж авах ийм л технологи. Энэ дэлхий дээр өнөөдөр явж байгаа бүх үйлдвэрүүдийн ураны ашиглалтын 60 гаруй хувь нь энэ технологиор явагдаж байгаа ийм л асуудал.

Энд хэрэглэгдэх хүхрийн хүчлийн асуудал. Мэдээж хүхрийн хүчил мэдээж химийн маш хүчтэй ийм хүчил. Жишээлбэл Ганбаатар гишүүн маань энэ бас мэдэж байгаа Орхон аймгаас сонгогдсон, сонгогдож байсан учраас энэ зэсийн баяжмалыг хайлуулж зэс хайлуулах үйлдвэрийн асуудал яригдахад энэ хүхрийн хүчлийн асуудал гарч ирдэг. Энэ дээр хоёр л зам байгаа. Нэг нь элементийн хүчил, хүчил үйлдвэрлэж тэр их өндөр үнэтэй ч биш борлуулах, нөгөө талд нь хүхрийн хүчил үйлдвэрлэж ашиглах гэдэг байдлаар. Энэ зэс хайлуулах үйлдвэрийн асуудал бол ингээд яригдаад явж байгаа. Энд эндээс гарсан хүхрийн ислийг бид бүхэн хүхрийн хүчил болгож нуруулдан баяжуулах гээд Эрдэнэт дээр бид нар импортоор хүхрийн хүчил аваад л ашиглаж байгаа. Оюу толгойн отвал дээр бас нуруулдан баяжуулах аргаар хүхрийн хүчлээр энэ зэсийн катодын зэс үйлдвэрлэх ажил явагдана.

Дээрээс нь энэ уран олборлолт дээр энэ газрын доорх энэ ураны ашиглалт дээр энэ хүхрийн хүчлийг ашиглана. Дээрээс нь хэрвээ бид нарт ойрхон фосфор байх юм бол манай хөдөө аж ахуй.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Туваан сайд нэмээд хариултаа гүйцээчихье. Туваан сайд.

Ц.Туваан: Тэгээд бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Бид нар бас уул уурхай өндөр хувьтай, уул уурхайгаас хамааралтай боловч мэдээж хөдөө аж ахуйн салбар чухал. Тэгээд сүүлийн үед хөдөө аж ахуйн салбар дээр маань өндөр ургац авч чадахгүй байгаа асуудал энэ бордоотой холбоотой асуудал байгаа. Бид нар хөрсөө бордож чадахгүй байгаа. Тэгээд бид нарт хэрэгцээтэй энэ фосфатын бордоог энэ хүхрийн хүчлийн фосфоритын орд ашиглаж, хүхрийн хүчлийг хамтад нь ашиглаж энэ фосфоритын бордоо үйлдвэрлэх гэдэг ийм л арга замууд байгаа. Тэгэхээр бид нар хүхрийн хүчлээ хүхрийн хүчлийн үйлдвэрийг энэ зэс хайлуулах үйлдвэрээ дагалдуулж бий болгож эдгээр салбаруудад нуралт уусах, хөдөө аж ахуй гэсэн энэ салбарууд руугаа ашиглана гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Нэмэлт хариултыг 1 дүгээр микрофон.

Э.Нямдаваа: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Нямдаваа.

Бид хуулийн төсөл дээрээ төсөл хэрэгжүүлэгч нь энэ цацраг идэвхт хаягдлын менежментийг бүрэн гүйцэтгэнэ гэж оруулж ирсэн байгаа. Бүрэн гүйцэтгэнэ гэдэг дотор маань цацраг идэвхт хаягдлыг цуглуулах, ангилах, ялгах, бэлтгэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах, булшлах гэсэн бүх үйл ажиллагааг хамардаг байгаа. Тэгэхээр бид төсөл хэрэгжүүлэгчийг бол цацрагт хаягдлаа түр хадгалж байгаад орхиод явах биш бүр эцсийн байдлаар, хаягдлын менежментийн эцсийн цэг нь булшлах байдаг. Яг энэ цэг хүртэл нь гүйцэтгэх ёстой гэсэн ийм шаардлагыг тавьж байгаа.

Мөн Цөмийн энергийн комиссоос 2015 оноос хойш хугацаанд 20 орчим энэ аюулгүй ажиллагааны дүрэм, журмуудыг баталсан байдаг. Үүнд энэ хүдрийн олборлолт боловсруулалтаас үүсэх хаягдлын менежментийн дүрмийг бас батлан гаргасан байдаг. Мөн цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын менежментийн дүрэм батлан гаргасан байгаа. Цацрагт материалыг аюулгүй тээвэрлэх дүрмийг бас батлан гаргасан байгаа. Цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааны үндсэн дүрмийг мөн батлан гаргасан гэх мэтчилнээр энэ урантай холбоотой үйл ажиллагаа дээр цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны энэ эрх зүйн орчныг бас нэлээд олон улсын атомын агентлагийн дүрэм, журмыг үндэслээд сайжруулсан байгаа.

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг шиг л юм болж байна даа. Үгүй мөн гоё хариулах юм. Дүрэм гаргаад л, дүрэм өөрөө тэгээд л цэвэршүүлээд л явчих юм байна л даа. Үгүй мөн азтай улсууд юм бид нар ч гэсэн. Би асууж байгаа юм гэвэл хог хаягдлыг, аюултай хог хаягдлын үйлдвэр хэзээ барих вэ, барихгүй юу? Эсвэл хог хаягдлаа Хятад руу юм уу, Франц руугаа явуулна гэж байгаа бол тэр тухайгаа тодорхой яриач.

Хоёрдугаар зүйл гэвэл 50 сая долларын хүхрийн хүчлийг жил болгон 50 сая долларын борлуулалтыг гаднаас авахгүйгээр Монголын энэ зэс, олон зэс хайлах үйлдвэр барина гээд төлөвлөж байгаа. Монголоос барих боломж байна уу? Энхийг хөрөнгө оруулагчаараа хийлгэх үү л гэж асууж байгаа юм. Маш энгийн тодорхой зүйл асууж. Хариулсангүй. Сая би бодсон энэ бусад бүх асуулт, энэ асуудал

болгон дээр хариулахыг, асуух юм бодсон чинь бүгдийг нь туушиндах юм шиг байна шүү дээ.

Хоёрдугаар миний асуулт 5.2, 5.3 дээр надад боломж олдсон дээрээ 5.2, 5.3 дээр түрүүн Цогтбаатар гишүүн асууж байна. Үгүй энэ чинь хууль дээрээ 34 хувийг ямар ч, 34 хувийн хувьцаагаа ямар ч үнэ төлбөргүйгээр, ямар ч хариуцлага үүрэхгүйгээр Монгол орон авна гэж энэ Цөмийн энергийн хууль дээр ороод ирчихсэн байгаа. Тэрнээсээ бид татгалзах гээд байгаа шүү дээ. Тэр чинь мөнгөөр тооцох юм бол 25-30 хувийн ашигтай ажилладаг гэж бодоход 100 доллар тутмын 70 долларын ашигтай ажиллахад энэ чинь ойролцоогоор 51 хувь гэх юм бол 35.7 долларыг бид авна гэсэн үг 100 доллар тутмаас. 34 хувь 23.8 доллар авна гэсэн үг. Энийгээ биднүүс 8, 9 доллароор солих гээд байгаа байхгүй юу. Хэнтэй ч хуваалцахгүйгээр газрын доорх тэр ураны баялгаа 34 хувиа бид үнэлж, үнэ төлбөргүйгээр авна гэж. Энэ Оюу толгой дээр өр авна гэсэн. Би эсэргүүцэж байсан үнэн. Оюу толгой дээр 34 хувь гэдэг бол тэр хувьцааг авснаараа тэр Рио Тинтоогоос худалдаж авна гэж орж ирсэн өр.

Г.Тэмүүлэн: Туваан сайд Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ц.Туваан: Ганбаатар гишүүн бас сая зөв хэллээ. Энэ зэс хайлуулах үйлдвэрүүдийн, үйлдвэр ашиглалтад орсноор гарах бүтээгдэхүүнүүд дотор энэ хүхрийн исэл байгаа. Энийгээ бид бүхэн хүхрийн хүчил болгож түрүүний хэлсэн нуруулдан уусгах болон энэ ураны төсөлдөө ашиглана. Тэгэхээр гаднаас үхрийн хүчил импортоор авдаг асуудал зогсоно гэж хариулъя.

34 хувь бол үнэгүй хувь. 34 хүртэл хувь мөн. Тэгээд бид бүхэн сая хэлчихлээ Оюу толгой энэ тэр дээр бас 34 гэж байгаад бид нар бидний монголчуудын хүртэх үр өгөөж гэдэг асуудал хаана хойшилсныг бас мэдэж байгаа. 2019 оны Үндсэн хуулийн концепц бол Баялгийн сангийн тухай хууль батлаад түүндээ уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг авч ард иргэд рүүгээ зарцуулах гэдэг концепц байгаа.

Тэгэхдээ энэ дотор бас стратегийн ордын хувьд дийлэнх буюу 50 дээр нэмэх 1 хувийн ашигтай байх зохицуулалтыг оруулж өгсөн зүйлийг Засгийн газар барихаас өөр арга байхгүй. Энэний аргаа хайгаад явж байгаа асуудал. Өөрөөр хэлбэл, тэр 34 хувийгаа тусгай АМНАТ-аар орлуулах асуудал энэ хуулийн гол үзэл баримтлал шүү гэдгийг бас энд хэлье.

Дээрээс нь 34 хувийг бид нар үнэгүй л гэж байна. Яг 34 хувиа эзэмшээд явах юм бол цаашдаа бид нар энэ хөрөнгө оруулалтын гэрээ хийгдээд энэ үйлдвэрээ бариад явахад Монголын талаас гарах мөнгө байгаа. Эхний ээлжид бид бүхэн манай ажлын хэсгийнхнээр ярьснаар 125 сая доллароос эхлээд Оюу толгойрхуу тийм хөрөнгө оруулалтыг гаргаад явах нөхцөл байгаа юм. Энд сольж байгаа энэ давуу эрхийн 10 хувь дээр ямар нэгэн хөрөнгө гаргах, мөнгө гаргах ийм үүрэг хүлээхгүйгээр байгаа юм гэдгийг бас гишүүнд хэлье.

Г.Тэмүүлэн: Байгаль орчны яам 2 дахь асуулт дээр нь хариулъя. Хүхрийн хүчил, хог хаягдлын үйлдвэр. 9 номер.

Б.Мөнхтогтох: Сайн байна уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Мөнхтогтох.

Тэгэхээр тухайн төслийг хэрэгжүүлснээр 3 төрлийн хог хаягдалтай холбоотой асуудал яригдаж байгаа.

Нэгдүгээрт нь энгийн хог хаягдал, хоёрдугаарт, нь аюултай хог хаягдал, гуравдугаарт нь цацраг идэвхт хог хаягдалтай холбоотой асуудал. Тэгэхээр гишүүний асуусан асуултад хариулахад энгийн хог хаягдал, аюултай хог хаягдалтай холбоотой асуудал дээр Монгол Улсад эрх зүйн зохицуулалт нь байгаа.

Дээрээс нь тухайн чиглэлээр хог хаягдал дээр вэст менежмент/waste management/ буюу хог хаягдлын менежмент хийдэг эрх бүхий байгууллагууд нь байгаа. Тэгэхээр аюултай хог хаягдлуудыг төвлөрүүлээд тэр дээр хог хаягдлууд дээр нь waste management хийдэг үйлдвэрүүд байгаа. Одоогийн байдлаар 2024 оны 11 сарын байдлаар байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөөс тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх авсан 24 байгууллага, аж ахуйн нэгж байна.

Байгаа шүү дээ Монголд. Монголд хог хаягдал, аюултай хог хаягдлын чиглэлээр дахин боловсруулалт хийдэг үйлдвэрүүд байгаа шүү дээ гишүүнээ. Цацрагийнх байхгүй гэхээр сая цацрагийн асуудал дээр Нямдаваа даргын хэлдэг хариултыг тийм.

Яг цацраг идэвхт хог хаягдал, цацрагийн үүсгүүртэй холбоотой асуудал дээр төвлөрүүлэн хадгалдаг тусгай байгууламж бол Монгол Улсын хэмжээнд байгаа. Алдар толгой гээд тэр байгууламж дээр эдгээр хог хаягдлыг төвлөрүүлж хадгалаад хамгаалалтад авдаг ийм байгууламж байгаа. Тусгай хамгаалалтад байдаг. Энэ дээр дутагдалтай байгаа асуудал нь болохоор яг хаягдал дээр нь waste management хийдэг зохицуулалт нь дутуу. Ийм учраас бид нар хөрөнгө оруулалтын гэрээний явцад төсөл хэрэгжүүлэгч тал дээр гэрээнийхээ явцад тухайн төслийн үйл ажиллагаанаас гарсан цацраг идэвхт хог хаягдал дээр хог хаягдлын асуудлыг бүрэн хариуцна гэсэн зохицуулалтыг Францын талтайгаа зөвшилцсөн байгаа.

Г.Тэмүүлэн: Дэгээр байхгүй байх. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Ямар ч байсан энэ хуулийн төслийг хэлэлцээд явахыг дэмжиж байгаа. Тэгээд монголчууд ч ерөнхийдөө нөгөө бидэнд хэлсэн үг байж л байна л даа “алтан дээр суусан гуйлгачин” гэгчээр тэгээд ер нь явж явж шинжлэх ухаанд итгэх үү, эсвэл тийм хоосон зөн билигтээ, эсвэл хэт их төсөөлөлдөө итгэх үү гэдэг зүйлийг л өнөөдөр бид хэд ярьж байна зарим зүйл дээр.

Тэгэхээр нэгэнт энэ дэлхий бас энэ тодорхой химийн элементүүдийг, ашигт малтмалын нөөцүүдийг ашиглаж энийгээ бид нар бас эдийн засгийн эргэлтэд оруулж энийг бас нийгэм, эдийн засгийнхаа нөхцөл байдлыг сайжруулах ялангуяа цаашдаа энэ мэдээж эрчим хүчний хамгийн том эх үүсвэрүүдийн түүхий эд шүү дээ. Тэгэхээр хоёр зүйлийг өчигдрөөс хойш Байнгын хороонууд дээр хольж ярьж байна лээ.

Нэгдүгээрт бид хэд бол шар нутгийг зөвхөн олборлож, экспортод гаргадаг байгаа. Тэр баяжуулснаас үүсэх тэр хог хаягдлын асуудал угаасаа Монгол Улс авахгүй гээд конвенцоороо ч хийчихсэн, тийм ч боломж угаасаа байхгүй. Ер нь

зүгээр цааш цаашдаа энэ хууль батлагдвал бас Атомын цахилгаан станцыг барих асуудал яригдах байх. Дэлхий дээр 440 реактор ажиллаж байгаа юм байна лээ. Нийт дэлхийн эрчим хүчний хангамжийн 10-аас дээш хувь гэж явж байгаа. Цаашдаа ч өсөн нэмэгдэнэ гээд явж байна.

Тэгэхээр би бол энэ хөрөнгө оруулалтын асуудлуудыг шийдэхийн тулд энэ хууль, эрх зүйн орчин татварын орчин дээр л анхаарах ёстой юм. Өмнөх 15 онд баталсан хуулиар бол 5 хүртэл гээд энэ хэлэлцээрийг хийсэн ч дандаа хэл ам дагуулж Монгол Улсад хэлэлцээр хийхгүй байх нөхцөлийг Улсын Их Хурал бүрдүүлсэн байсан. Энэ хуулиуд ингээд овоо ингээд ороод ирж байна уу гэж байтал энэ дундаас бас зарим Улсын Их Хурлын гишүүд суурь АМНАТ-ыг нэмнэ гэж байгаа юм. Ард түмний төлөө гэж нэрийн доор их өндөр ашиг олно ч гэдэг юм уу, үр өгөөж Монголд үлдэнэ гэдэг энэ хоосон маскийг углуулаад, камер харж сууж байгаад ийм өндөр татвар тавьчихаад хөрөнгө оруулагчдыг дуудна гэх юм бол Монгол Улсаас энэ хөрөнгө оруулалт чинь зугтана.

Тэгэхээр бид хэд энийг бодолцоод би ажлын хэсгээс хариулаасай гэж бодож байгаа. Ерөнхийдөө дараа дараагийн саналууд хураагдана. Дэлхий нийтийн яг энэ ураны олборлолт дээр оногдуулж байгаа АМНАТ ер нь ямар байна? Жишээ нь, хамгийн өндөр Узбек байгаа шүү дээ 8 хувь, бусдууд нь 3-5 дотор байж байгаа. Гэтэл бид нар үүгээрээ бараг 14 хувийг авна гэххээд үнэ өсөөд 130 доллароос дээшээ гарвал бараг 19 хувийн АМНАТ авна гэххээд явж байхад энийг нэмэгдүүл ингээд Монгол Улсад ерөөсөө хөрөнгө оруулалт хэрэггүй гэсэн үг. Харахад гоё, гоё хууль баталж байна. Ард түмнээс илүү их, ард түмнийхээ төлөө мэт боловч яг эцсийн дүндээ өнөөдөр ураны төслүүдийг явахгүй гэж байгаа юм. Энэ Зөвч Овоо чинь хамгийн юу гэдэг юм, олборлолтын хувьд технологийн хувьд хамгийн хөнгөн, цаашдаа ил, далд уурхай явах юм бол энэ АМНАТ-ыг энэ чигээр нь бид нар дараа дараагийн саналууд дээр яригдах хэмжээнд батлах юм бол Монголд уран ашиглах гэдэг зүйл уран олборлох гэдэг төсөл нэг ч яригдахгүй юм. Энэ дээр аж.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүний асуултад Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Яг энэ агуулгын хувьд нь маш сайн ойлгож, бас дэмжиж байгаад нь бас гишүүнд баярлалаа. Тэгээд бид бүхэн ерөнхий нэг юм байгаа юм. Нэг утгаараа энэ засаг төр ялангуяа Улсын Их Хурал Засгийн газрыг дээрээ энэ ард түмний амьдралыг сайжруулахгүй байна, энэ янз бүрийн орлого, янз бүрийн юм байхгүй байна гэххээд нөгөө талаараа бас яг энэ талдаа хийсэн ажил, ажиллагаанууд дээр нь ингээд бас шүүмжлэлтэй яваад байх энэ төрлийн асуудлууд нь ингээд бас гацдаг ийм төрлийн юм бол бодитой байгаа. Тэгэхээр энэ талд бас дэмжиж үг хэлсэнд талархаж байна.

Яг өнөөдрийн байдлаар манай 80-90 долларын үнийн дүнтэй байгаа шар нунтаг буюу уран М 3, О 8-ын үнээр тооцоход 14 хувийн АМНАТ авахаар байгаа. Энэ бас өндөр тоо. Суурь 5, тусгай 5, 0-9-ийн үнэд харьцуулснаар авах юм бол 14.

Өнөөдөр дэлхий дээр 440 цөмийн реактор ажиллаж байгаа. Дахиад 400-гаад реактор ажилд орох болон төслийнхөө явцад ингээд явж байгаа. Тэгэхээр ураны шар нунтгийн эрэлт хэрэгцээ бол өсөж байгаа. Өөрөөр хэлбэл, шар нунтгийн нийлүүлэлт эрэлт хоёрын хооронд маш том зөрүү байгаа. Тэгэхээр үнэ өсөх нь тодорхой.

Тэгэхээр манай энэ үнэ өсөөд ирэхээр өөрөөр хэлбэл, 130, 1 фаунд нь 130 ам.доллар-оос дээш давахад л 19-тэй тулах юм. Тэгэхээр ийм АМНАТ-ын асуудал байгаа. Тэгээд бид нар энийг яагаад хийж байгаа гэхлээр түрүүний хэлсэн Үндсэн хуулиа л барьж байгаа юм. Шуудхан хэлэхэд. Үндсэн хуулийн тэр заалтыг бид нар өөрчлөх боломжгүй. Дагах ёстой. Тэр нь дийлэнх олонх нь улсад, Монгол Улсад ноогдохоор шийдвэрлэхийн тулд энэ АМНАТ-уудыг бид нар бас дээд түвшинд нь тулгаад явж байгаа.

Дээрээс нь хөрөнгө оруулагчид ч гэсэн гэрээн дээр сууж байхдаа хэлж байгаа юм. Ер нь та нар энэ бүх юмаа тооцоод үзэхэд 50-аас дээш гарчихсан энэ асуудал байгаа шүү гэдгийг хэлж байгаа. Бид ч хэд ч гэсэн Үндсэн хуулиа барина гэдэг тал дээрээ байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Олон улсын АМНАТ-ын түвшнүүдийг 2 дугаар микрофон дээр.

2 номер.

Г.Тэмүүлэн: Далайжаргал” Мон-Атом”-ын захирал байна.

Дэлхий дээр нийтдээ 13 улсад уран байгаа. Энэ 13 улстай ураны эхний 5 улс нь нийт ураны 80 хувийг нь эзэлдэг. Казакстан хамгийн их урантай Казакстан. АМНАТ 6, Канад 5, Нигер 5, Австрали 5, Узбек 8 гэж явж байгаа.

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Сайнзориг: Тэгэхээр хар даа ийм хэмжээнд байгаа байхгүй юу. Бид хамгийн өндөр нь жишээ нь Узбек 8 хувьтай. Өнөөдөр Узбекүүд энэ ураныгаа ашиглаад Казахстаны араас явна гээд Америк тэргүүтэй улс орнуудын зах зээл дээр бас энэ асуудлаа бид нарын энгийн яриагаар чулуу болгоно гээд явж байгаа байхгүй юу. Бид хэд энэ дээрээ өөрсдийгөө өрсөлдөх чадваргүй болгох хэмжээнд гишүүд нь санал гаргаад, энийг ард түмний төлөө хийж байгаа нэрийн доор энэ хуулийн төслүүд дээр санал гаргаж байгаа. Тэгэхээр гишүүд маань бас болгоомжтой байгаасай гэж хүсэж байгаа юм.

Дээрээс нь энэ АМНАТ-аас чинь гадна энэ магадгүй төсөл хэрэгжүүлэгч хэлэлцээр хийх юм бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлнө, бусад тэр татваруудыг төлнө. Энэ нөхцөл байдлуудыг бид нар зөв ойлгуулахгүй бол ерөнхийдөө бараг л бүх юмаа зүгээр өгч байгаа юм шиг юм яриад байгаа юм.

Хоёрдугаарт, энэ 9 хувийн суурь АМНАТ явах юм бол үндсэндээ Монгол Улс тусгай АМНАТ-ыг хэрэглэх боломжгүй болж хөрөнгө оруулалтын хэлэлцээр чинь зогсох уу, үгүй юү? Энийгээ хариулчхаач. Дээрээс нь эсвэл 34 хувьдаа хөрөнгө оруулалт гэдэг ийм том шахалт байна. Хөрөнгө оруулах бололцоо аль нэг компани, ТӨК бий юү? Эсвэл Засгийн газарт ийм хэмжээний хөрөнгийг гаргаад явах бололцоо байгаа юү? Энэ нөгөө Оюу толгойн асуудал давтагдана гэсэн үг. Менежментдээ олигтой оролцож чадахгүй, зардал өсөхийн хэрээр үр өгөөж нь буураад явна.

Тэгэхээрээ бид хэд энэ зөв мэдээллүүдийг бас олон нийтдээ өгөхгүй бол өнөөдөр энэ олон нийт яах вэ, бас би зарим зүйлүүд дээр байр сууриа илэрхийлэх эрхийг нь ойлгож байгаа боловч дандаа гаднын гар, хөл болж олон нийтийн энэ хатгаасуудаар явж байгаа шүү. Монгол Улс хөгжих юм уу, үгүй юү? Ийм л зүйл дээр байна.

Тэгээд өнөөдөр хөрөнгө оруулалтыг татах салбар зөвхөн уул уурхай байж байхад бид нар энэ уурхай эрх зүйн орчноо бас сайжруулах тухай биш, зүгээр л ийм хөнгөн хэлбэрийн хөрөнгө оруулалтын хуулийг хийчихвэл бараг бүх юм жигдэрчихнэ гээд л бие биеийгээ хөнгөн хуураад л байж байгаа байхгүй юу. Уул уурхайн яам жишээ нь энэ Ашигт малтмалын хуулийг иж бүрнээр нь хэзээ оруулж ирэх юм? Энэ чинь энэнтэй холбогдоно шүү дээ.

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг чинь гаднын хөрөнгө оруулагчид Монгол Улстай цаашдаа урт хугацаанд хамтаръя гэсэн энэ хөрөнгө оруулагчид ажиглаж байна. Энэ дээрээ бид нар тодорхой хамтарч ажиллаж байгаагийн хувьд хурдан байр сууриа илэрхийлж хурдтай ажилламаар байна. Хамгийн хурдтай ажиллах салбар бол энэ уурхайн салбар шүү. Тэгж байж бид нар дараа нь бусад зүйлээ өндийлгөнө. Тэр гадаад валютын нөөцөө алдчихгүй, ханшаа алдчихгүй байх юм чинь эндээс хамаарна. Тэгэхээр Туваан сайд хэзээ Ашигт малтмалын хуулиа орж ирэх юм? Тэр тусгай АМНАТ-ыг үгүй ээ, суурь АМНАТ-ыг 9 болговол ямар эрсдэлүүд үүсэж болох юм? Энийг зүгээр ер нь тодорхой хариулж болохоор бол бас хэлээч гэж байгаа юм. Тэгээд дээрээс нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад зөндөө татвар төлж байгаа үр өгөөж ер нь Үндсэн хуулийн концептод нийцэж байгаа юу? Энэ дээр бас яг тодорхой хариулаад өгөх нь. Нийцэхээр ажиллаж чадах уу яг энэ хууль батлагдвал? Хэлэлцээрийн мэдээ цаашаа үргэлжлэх байх.

Г.Тэмүүлэн: Туваан сайд.

Ц.Туваан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Суурь АМНАТ 9 хувь болсон тохиолдолд төсөл зогсоно. Хөрөнгө оруулалтын гэрээ цаашаа явах боломжгүй болно.

Ашигт малтмалын тухай хуулийг Улсын Их Хурлын даргын захирамжаар Наранбаатар гишүүнээр ахалсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Ойрын хугацаанд оруулж ирнэ. Яаман дээр бас боловсруулсан драфтууд байгаа.

Татварын хувьд тэр дийлэнх олонх гэдэг дээр бол та бүхэн бодоод үзэхэд давуу эрхийн 10 хувь, дээрээс нь энэ АМНАТ-ууд үнэ өссөн тохиолдол гээд 19 хувь, ингээд 29 хувь, дахиад дээрээс нь сая бас Пүрэвдорж гишүүн хэлнэ лээ энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татвар чинь 6 тэрбумаас дээш гараад ирэх юм бол 25 хувь болоод явдаг. Дээрээс нь бусад зөндөө татвар хураамжууд байгаа. Газар ашигласны, ус ашигласны, тэгээд өшөө орон нутгийн гэдэг юм уу, дээрээс нь хөрөнгө оруулалтын гэрээнд тухайн орон нутагт нь буюу сумд нь өгөх мөнгө энэ тэр гээд нэлээн олон асуудлууд байгаа. Тэгэхээр маш олон төрлийн хураамжууд дээр ямар нэгэн бусад хөнгөлөлтүүдгүйгээр хураагдаад явна гэдгийг бас хэлье.

Дээрээс нь мэдээж уул уурхайн салбар бол улсын төсвийн хөрөнгийн гуравны нэг, 30 хувь, ДНБ-ий 37 хувь, экспортын орлогын яг өнөөдрийн байдлаар 94 хувийг бүрдүүлж байгаа ийм салбар. Тэгэхээр бид нар энэ уул уурхайн энэ цаг үед маш хурдан ажиллаж энэ 28 он гэхэд ДНБ 1 хүнд ноогдох ДНБ-ээ 10 мянган америк доллар давуулах гэсэн энэ зорилгыг бас хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Манайд уул уурхайн олон төслүүд амжилттай явж чадахгүй гацаад байгаа юм. Тэгээд түүний нэг илрэл бол сая Ховд аймгийн Мянгад сумд бид нар харлаа. Тэгээд энэ юунаас болоод байгаа юм гэхээр тодорхой, төсвийн хуваарилалт нь шог байгаадаа л байгаа. АМНАТ-ын 30 хувийг нь орон нутагт нь үлдээнэ гээд л хууль сайхан байж байдаг юм. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг нь орон нутагт нь үлдээнэ гээд л байж байдаг юм. Хэрэгждэг юм нэг ч байхгүй.

Яагаад гэхээр төсвийн тухай хуулиар аймаг сумдын суурь орлогоос нь суурь зарлагыг нь хасаад ингээд зөрүүг нь шууд улсын төсөвт татаад авчихдаг. Улсын төсөвт эргээд хөрөнгө оруулалт хийхдээ ямар ч эрэмбэ тогтоодоггүй. Харин ч уул уурхайтай аймгууд хамгийн бага төсөв хуваарилагдаад уул уурхайг эсэргүүцсэн аймгууд дээр хамгийн их хөрөнгө оруулалт тавигддаг ийм сонин тогтоцтой явж байгаа учраас би энэ төслийг, үүний араас гарч ирэх шинэ уул уурхайн төслүүдийг явна гэхэд бол итгэл байхгүй байгаа юм.

Тэгэхээр энэ дээр энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, АМНАТ, энэний хуваарилалт чинь өөрчлөгдөх юм уу, үгүй юм уу? Тэр орд байгаа газрын баг, иргэд байна, нөлөөллийн бүсийн айлууд байна, сумын төсөв татвар байна, аймгийн төсөв татвар, орлого энэнд ер нь нөлөө байгаа юм уу? Өөрчлөгдөх юм байгаа юм уу? Байхгүй бол хуучинтайгаа ялгаагүй бол энэ цаашаа явахгүй. Энийгээ цааш нь явуулна гэж бодож байгаа бол тэр Төсвийн тухай хууль, бусад татварын хуулиудаа хамт дагуулж орж ирээд ингээд аймаг орон нутагт, тухайн газарт нь үлдэх үр өгөөжийг нь нэмэгдүүлэхгүйгээр манайд хөрөнгө оруулалтыг татна гэдэг ойлголт байхгүй. Тэр хавийн айлууд, тэд нарыг дэвэргэсэн эх орончид, ТББ-а гарч ирээд л үймээн самуун дэгдээгээд ингээд л зогсоочихно.

Тийм учраас үүнийг энэ хуулийг цаашаа энэ хөрөнгө оруулалтыг амжилттай хэрэгжүүлэхэд татварын ямар нэгэн өөрчлөлт, зохицуулалт тухайн орон нутагт нь байгаа юм уу, үгүй юм уу гэдэг тодорхой асуулт асууя.

Хоёрт нь энэ цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохгүй гээд эцсийн бүтээгдэхүүн л болгож л экспортлох юм байна гэж заачихсан байна. Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татвар энэ эцсийн бүтээгдэхүүнээс чинь авах юм уу, үгүй юм уу? Эндээс чинь манайд НӨАТ-аар юу орж ирэх юм гэсэн асуулт байна.

Гурав дахь асуулт нь энэ энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаагаар сольж болно гээд заачихсан. Тэгээд давуу эрхийн хувьцаагаар сольчихлоор чинь саналын эрхгүй болчихно шүү дээ. Тэгэхээр энэ ямар утга агуулгаар ийм заалт оруулж ирсэн юм гэсэн ийм 3 асуулт байна. Дараа нь тодруулъя.

Наранбаатар гишүүний 3 асуултад хариулъя. Учрал сайд эхний хариултыг.

Н.Учрал: Наранбаатар гишүүн их чухал асуудлыг хөндөж байгаа. Үндсэн хуулийн 6.2 дээр энэ газрын хэвлийн баялаг байгалийн баялгийн дийлэнхийг ард түмэн эзэмшинэ гэсэн энэ суурь зарчмыг хангуулах гэж л энэ хэлэлцээрийг хийе гэдэг энэ зарчмаа бариад тэр хоёр Ерөнхийлөгчийн төрийн айлчлалын үеэр протоколд тусгагдсан юм билээ. Тэнд бол яг энэ газрын хэвлийн баялгийн 50 дээр нэмэх нэгийг хэрхэн хангуулах вэ гэдэг зарчмаа л барья гэж шийдсэн.

Өнөөдөр Үндэсний баялгийн сангийн хуулиар тэр 34 хүртэлх, 50 хүртэлх хувийг үнэ төлбөргүйгээр эзэмшинэ гэдэг энэ заалт бол маш хэрэгтэй заалт хэдий ч яг Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээтэй адилхан ноогдол ашиг хэдэн жилээр хойшлохыг бид тааж мэдэхгүй. Тэгээд зардлаа өсгөж, ноогдол ашиг хуваарилдаггүй ийм арга зальтай болчихлоо шүү дээ. Тэгээд өнөөдөр 5 хувийн АМНАТ-аас Оюу толгойн гэрээ бол 800 сая доллароор төлөгдсөн юм билээ. Энэ бол бодитой Монгол Улсын төсөвт орсон нь.

Гэтэл бид нар хэрвээ 34 хүртэлх хувь ч юм уу, 50 хүртэлх хувийгаа төр эзэмшинэ гээд явах юм бол ноогдол ашиг авах хугацаа хэдийг хүртэл хойшлох юм мэдэхгүй. Тийм учраас тэр төрийн эзэмшлийн 34-ийг АМНАТ-аар оруулах нь зөв юм байна. АМНАТ-аар орлуулахдаа үргэлж үнэ нь өсөж байгаа энэ ураны эрэлт, нийлүүлэлтээ харж байгаад ингээд заагаад өгчих нь зөв юм байна гэж зорьсон. Энэ ч утгаараа суурь АМНАТ 5, тусгай АМНАТ 5, тэгээд өсөн нэмэгдэх АМНАТ, дахиад өнөөдрийн үнийн үнээр 81, 2 доллар гэж үзэх юм бол 14. Энэ бол дэлхийн жишигтэй харьцуулахад маш өндөр АМНАТ авч байгаа бид нар. Тэгэхээр энэ бол маш өндөр тоо.

Тэгэхээр энэ бол тухайн компани ашигтай, ашиггүй ажиллахаас үл хамаараад борлуулалтаас нь авна гэсэн үг. Үүн дээр нэмэгдээд юу нэмэгдэх юм? Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. Үнэхээр тэр 6 тэрбумаас давчих юм бол 25 хувийн орлогын албан татвар төлнө шүү дээ. 25 хувь. Дээрээс нь ус бохирдуулсны төлбөр, ашигласны төлбөр гээд. Дээрээс нь бид хэлэлцээрийн явцад юу яригдсан бэ гэхээр тэр Дорноговь аймгийн Улаанбадрах суман дээр 1 сая долларыг тэр нийгмийн дэд бүтцэд зарцуулна гэдгийг тохирьё гэж ийм зарчмаа тавьсан.

Тэгээд тэр орон нутаг хөгжих ёстой шүү дээ. Цаашдаа Улаанбадрах сум өөрөө тосгон болж хөгжих ёстой. Тэнд тэр 1 сая доллар нь очих ёстой. Дээрээс нь энэ АМНАТ өндөр байгаагийн зорилго бол өнөөдрийн Үндэсний баялгийн сангийн хуулиар 65 хувийн АМНАТ-ыг аваад, үлдсэнийг нь Орон нутгийн хөгжлийн сан, Тогтворжуулалтын сан хоёрт хувааж хийнэ. Тэгэхээр орон нутагтаа бол очих өгөөж нь бол хамаагүй өндөр байна л гэж ингэж үзээд байгаа юм л даа.

Тийм учраас өнөөдөр Суурь АМНАТ-ыг 5-ыг 9 болгоно гэж тийм тооцоо, судалгаагүйгээр өнөөдөр тэгж санал гаргаж ерөөсөө болохгүй. Ер нь бол энэ өндөр тогтоосон АМНАТ-аа л бид нар хэлэлцээрийн үед амилуулах утгаар нь.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Туваан сайд нэмж хариулт өгье.

Ц.Туваан: Наранбаатар гишүүний нэгдүгээр асуултад Наранбаатар гишүүн Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн даргаар ажиллаж байгаа. Тэгэхээр салбарын яамны хувьд бас нягт хамтарч ажиллана.

Ганцхан Монголд ч биш дэлхий нийтэд ерөнхийдөө энэ уул уурхайн чиглэлийн асуудлууд ялангуяа энэ орон нутагтайгаа хэрхэн харьцах вэ, орон нутгийн иргэдтэй яаж учраа ололцох вэ гэдэг асуудал бол нэлээн тулгамдсан асуудал болоод байгаа. Тэгэхээр энэ дээр маш их тооцоо, судалгаанууд явж байгаа. Тэгэхээр энэ тал дээр хамтарч ажиллана.

Дээрээс нь тантай санал нэг байна. Одоо бол уул уурхайг ашиглуулж байгаа тухайн орон нутагт нь тэр орлогын дийлэнх хувь өөрөөр хэлбэл, энэ АМНАТ-ын менежмент, аж ахуйн нэгжийн орлогын албан дотор хувиас хураасан хувийн дийлэнх нь ноогддог. Энэ зарчмыг бид нар барьж явахгүй бол уул уурхай ашиглах газар нутаг болгон дээр эрсдэл, эсэргүүцлүүд явна. Тэгэхээр тантай санал нэг байна. Тэгээд хууль дээрээ хамтарч ажиллана гэж гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Энэ саяынх уг нь их тодорхой л асуулт асуусан даа Наранбаатар гишүүн. Сангийн яам хариулах уу Тэлмүүн? Яагаад жишээ нь юу гэдэг юм, яг хамгийн их орлого төвлөрүүлдэг аймгууд дээр хамгийн бага төсөв дээр хуваарилдаг юм бэ? Татварын зөв бодлого болоод, орлогын тэгш хуваарилалт хэзээ хийгдэх ёстой юм бэ гэдэг асуудал яригдаад байна л даа. Эрдэнэт дээр, Өмнөговь дээр хамгийн их орлого төвлөрүүлсэн мөртөө бүх орлогыг нь хувааж аваад буцаагаад дахиж хуваарилж байгаа зүйл дээр бол хамгийн багаар хуваарилж байгаа асуудлууд байгаа.

8 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн, гишүүний асуултад хариулъя.

Энэ асуудал жил жил яригддаг. Нэг талдаа Монгол Улс нэгдмэл улс. Аль нэг аймгийн баялаг бол Монголын нийт ард түмний баялаг гэдэг агуулгаараа нэгдсэн төсвөөр дамжиж бусад аймгуудын тэнцвэртэй хөгжил рүү зарцуулагдах энэ зарчим нэг талдаа үйлчилж байгаа. Энэ ч агуулгаараа 2010 оны батлагдсан төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, нэгдсэн санд хуримтлагдаад буцаагаад итгэлцүүрээр хуваарилагддаг энэ зарчим руу шилжсэн.

АМНАТ-ын хувьд Үндсэн хуульд заасан одоо, ирээдүй болон улсын болон орон нутгийн энэ төсвийн энэ хуваарилалтыг тэнцүү хангаж байгаа. АМНАТ-ын орлогын 65 хувь нь Үндэсний баялгийн сан, Ирээдүйн өв сан руу ордог. 10 хувь нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, үлдсэн нь улсын төсөвт.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд ордог. Энэ орлогыг бид сүүлийн жилүүдэд дандаа орон нутгийн тэр уул уурхай яг олборлодог аймагт нь түлхүү хуваарилах энэ зарчмыг илүү оруулж байгаа. Тухайлаад хэлэх юм бол Төсвийн тухай хуульд 24 оны 6 сарын 5-ны өдөр өөрчлөлт оруулаад 59.7 гэдэг зүйлээр өөрчлөлт оруулаад тухайн Амнат-ийн эх үүсвэр бүрдсэн орлогын 10 хувийг тухайн эх үүсвэрийн 20 ба түүнээс дээш хувь бүрдүүлдэг аймаг, улсын зэрэглэлтэй хоттой тэнцүү хэмжээгээр, хэрвээ 20 хувийг бүрдүүлдэг байх юм бол 20 хүртэлх хувийг тухайн олборлосон аймаг руу нь хуваарилах гээд.

Тэгэхээр бид нар яг энэ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилагддаг АМНАТ-ын орлого, АМНАТ болон бусад орлогыг яг олборлосон аймаг руу нь илүү түлхүү хуваарилах энэ зарчим бол үйлчилж байгаа.

Хоёрдугаарт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын, урьд нь 100 хувь улсын төсөвт төвлөрүүлдэг байсан. Одоо ямар нэгэн стратегийн орд, уул уурхай гэхгүйгээр бүх орлогынх нь 40 хувийг тухайн аймаг, нийслэлд хуваарилж байгаа. Тэгэхээр уул уурхай томтой. Өмнөговь, Орхон, Дорноговь ч гэдэг юм уу эдгээр.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Яах вэ өнөөдрийн байгаа хууль, эрх зүйн орчныг л яриад байна л даа би. Хамгийн гол нь наад аргачлал чинь болохгүй байна. Жишээлбэл, Өмнөговийн 24 онд 1.7 их наядын татвар улсын төсөвт авчхаад, Орон нутгийн хөгжлийн сан дээр 60 тэрбум төгрөг тавьчихаж байгаа. Энэ эргээд шударга хуваарилалт мөн үү? Тэгэхээр чинь яаж орон нутаг дэмжих юм бэ энэ уул уурхайг чинь. Цогтцэций сумыг хар л даа, Гурвантэс сумыг хар л даа өнөөдөр сум нь сургууль ч үгүй, цэцэрлэг ч үгүй цагаан тоосондоо даруулаад л ингээд л ядмагхан, зүдмэгхэн л байж байна шүү дээ. Ус ч байхгүй, бэлчээр нутаг ч байхгүй.

Тэгээд эд нарыгаа шийдчихье гэхээр эргээд төрөөс хуваарилж байгаа 1.7 тэрбум, их наядыг авчхаад 60-хан тэрбум төгрөг 15 сумд хуваагаад өгчихөөр яаж цаашаагаа бусад аймаг, сумууд нь, багууд, иргэд нь энэ уул уурхайг чинь дэмжих юм бэ? Хамгийн гол нь баялаг чинь эргээд тэр олборлуулж байгаа газар нутгаа сүйтгүүлж байгаа ард иргэд, сум орон нутагт нь ээлтэй байгаад, хуваарилалт нь арай түлхүү л байх ёстой шүү дээ. Тэгэхгүй бол энэ хөрөнгө оруулалт чинь цаашаа явахгүй. Өнөөдөр уул уурхай хайгуул хийж байгаа сумдынх нь Цогтцэций, Гурвантэс 2 дээр очиж үзээд л тэгээд л больё л гэж хэлнэ. Өнөөдрийн хуулийн чинь толинд тусаж байгаа тусгал нь ийм л байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм байгаа нөхцөлд цаашаагаа энэ уул уурхайг хөгжүүлнэ, энэ хайгуулыг нэмэгдүүлнэ, нөөцөө нэмэгдүүлнэ, гадаадын хөрөнгө оруулалтыг татна энэ тэр гэдэг чинь үлгэр болно шүү. Тийм учраас би бас энэ Ашигт малтмалын хуулийн ажлын хэсгийг ахалчихсан явж байгаа. Нэг дэх өдрөөс эхлээд манай ажлын хэсэг хуралдана. Нэлээд бас энэ хөрөнгө оруулалтыг татах, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэл рүү бас анхаарч ажиллана гэсэн ийм л бодолтой байгаа. Ер нь хууль, эрх зүйн орчин нь ялангуяа Төсвийн хуулиа өөрчлөхгүй бол цаашаа уул уурхай маань явахгүй шүү л гэдгийг хэлье. Тэгээд түрүүний асуусан нөгөө энгийн хувьцаа, НӨАТ 2 дээр хариулт хэлээдхээч.

Г.Тэмүүлэн: Учрал сайд.

Н.Учрал: Түрүүн хэлсэн энэ төрийн эзэмшлийн 34-ийг АМНАТ-аар орлуулах, дээрээс нь тодорхой хувийг бол төр өөрөө эзэмшсэнээрээ тэр ноогдол ашиг нь тэр хуримтлалын сан руу орох, тэгээд эрүүл мэнд, боловсрол, орон сууцанд зарцуулах боломжийг нээхгүй бол огт оролцоогүй бол байж бас болохгүй байгаа юм.

Тийм учраас тэр 10 хувийг төр эзэмшье гэдэг ийм хэлцлийг хийх хүрээндээ энэ энгийн хувьцааг давуу ерөнхий хувьцаа болгохгүй бол энгийн хувьцаа гээд хэрвээ 10 хувийг тооцчих юм бол санхүүгийн хариуцлага хүлээх асуудалд орчхоод байгаа юм. Яг өмнө нь хийгдсэн хөрөнгө оруулалтын гэрээнүүдийн үр дагавар өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна шүү дээ. Бид нар санхүүгийн хариуцлага хүлээчихсэн, тэгээд өртэй, тэгээд нэмэлт тэр өөрсдийнхөө хүлээсэн хувь дээрээ хөрөнгө оруулалт хий гэдэг.

Гэтэл бид нар хэрвээ 10 хувийгаа энгийн хувьцаагаа давуу эрхийн хувьцаа болгочих юм бол нэгд санхүүгийн хариуцлага хүлээхгүй. Хоёрт, ноогдол ашгийг тэргүүн ээлжид хуваарилахад бол манай талд хуваарилагдах ийм зарчим хангагдах учраас бид нар энийг давуу эрхийн хувьцаа болгох асуудлыг хуульд нээж. Ер нь Цөмийн энергийн хуулиар энэ ураны асуудлыг зохицуулах нь өөрөө ач холбогдолтой гэж үзсэн. Тэгэхээр би Наранбаатар

гишүүнтэй 100 хувь санал нэг байгаа. Орон нутагт дэмжлэг үзүүлэхгүйгээр энэ уул уурхайн салбар цаашдаа урагшлахгүй. Тийм ч учраас энэ Ашигт малтмалын хуулийг эргэж харах ёстой.

Харин энэ удаа бол хэдийгээр уран стратегийн бүтээгдэхүүн гэж байгаа хэдий ч нөгөө цацраг идэвхт бодис гэдэг утгаараа бол Цөмийн энергийн хуулиар нь зохицуулаад явъя гэж бид нар шийдээд оруулж ирсэн. Цаашдаа Ашигт малтмалын хуулиар энэ асуудлыг хөндөх ёстой. Яах вэ, энэ Цөмийн энергийн хуулиар зохицуулагдаж байгаа энэ уран дээр бол нөгөө АМНАТ их өндөр тооцож байгаа учраас тэр Орон нутгийн хөгжлийн санг 10 хувийг нь хийх дээр бол орлого нь бол бусад төслөөсөө илүү үр өгөөжтэй байх нь бол бас дамжиггүй. Тийм учраас бол мэдээж энэ АМНАТ өндөр байна. Тэр тусмаа орон нутагт очих өгөөж нь өндөр байна л гэж хэлж болно.

Г.Тэмүүлэн: НӨАТ-тай холбоотой асуудал дээр Сангийн яам 8 номер. Тэгээд саяын тэр орон нутгийн хуваарилалттай холбоотой асуудлууд дээр, Төсвийн тухай хуулиуд дээр.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн Наранбаатар гишүүний асуултад нэмж хариулъя.

НӨАТ-ын тухай хуулийн хуулийн дагуу экспортод гаргаж байгаа уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн 0 хувь ноогддог. 0 хувь гэдэг маань тухайн үйлдвэрлэлийн орцод шингэсэн бүх НӨАТ-аа буцааж авах ийм эрх үүсдэг. Энэ харилцаа анх тэгээд, энэ жагсаалтыг Засгийн газар баталж ирсэн. Анх 2010 оны 11 сарын 10-ны өдрийн Засгийн газрын 286 дугаар тогтоол анх энэ НӨАТ-ын зорилгоороо уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн баталсан цаг үеэсээ эхлээд энэ шар нунтаг бол эцсийн бүтээгдэхүүн гэдгийн жагсаалт ороод өнөөдрийг хүртэл явсан байгаа.

Тэгэхээр энэ яах вэ, Засгийн газрын бүрэн эрхийн эрх хэмжээний асуудал байгаа. Энэ шар нунтаг нь өөрөө эцсийн бүтээгдэхүүнд орох эсэхийг хэлэлцээрийн явцад бас яригдана. Тэгээд шаардлагатай бол энэ тогтоолд өөрчлөлт оруулаад явна. Одоогийн эрх зүйн орчин бол ийм байгаа. Энийг бид одоогоор өөрчлөөгүй байгаа.

Г.Тэмүүлэн: Сая орон нутгийн хуваарилалттай холбоотой асуудлууд дээр Төсвийн тухай хуулиар нэмж хариулъя. Сая гол асуугаад байгаа асуулт нь та өөрөө ч хэлээд байна шүү дээ. Энэ Төсвийн тухай хуулиар чинь аймаг болгон дээр Өмнөговь аймаг дээр итгэлцүүр, бусад өөр аймгууд дээр өөр итгэлцүүр байдаг юм уу? Уг нь Төсвийнхөө хуулиар би бол нэг итгэлцүүр, нэг л зарчим, нэг бодлого, нэг яг л аргачлалаар л уг нь бодож байгаа гэж бодоод байгаа шүү дээ.

Гэтэл төсөв өргөн барихдаа ялгавартайгаар оруулж ирээд Өмнөговь нь ч гэдэг юм уу, Эрдэнэт нь ч гэдэг юм уу өөр өөр байдлаар орж ж байж байгаа байдал чинь эсрэгээрээ нөгөө нийгмийн бухимдлыг уул уурхайг эсэргүүцэх нь нийгмийн эсэргүүцлийг бий болгоод байна гэдэг асуудал яриад байна шүү дээ. Энэ дээр яг яах ёстой юм? Эсвэл ямар зарчим баримтлаад байгаа юм?

8 номер.

Б.Тэлмүүн: Нэмж хариулъя. Тэлмүүн, Сангийн яа.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хуваарилалт бол яг Төсвийн тухай хуульд заасан зарчим, томъёоллын дагуу явж байгаа. Энэ дээр бас түрүүн хэлсэн заалтын дагуу яг аймгуудад хуваарилагдахдаа тухайн олборлолт хийсэн аймагт түлхүү хуваарилагддаг энэ зарчим үйлчлээд явж байгаа. Уул уурхай орлоготой холбоотойгоор бас би түрүүн нэмж хэлэхэд аж ахуйн нэгжийн орлогын 40 хувь тухайн аймаг, орон нутаг руу хуваарилагддаг. Энэ бол сүүлд шинээр орж байгаа заалт. Тэгэхээр энд Өмнөговь, Дорноговь, Орхон гэдэг юм уу том уул уурхай аймгуудын тэр том том уул уурхайн компаниудын төлсөн аж ахуйн нэгжийн орлогын 40 хувь нь шууд орж байгаа

Дээрээс нь уул уурхайн хайгуулын лицензийн төлбөр 100 хувь тухайн аймгийн, аймаг руу очдог. Ашиглалтын лицензийн төлбөрийн 50 хувь очдог. Бусад байгаль орчинтой холбоотой, байгаль орчныг бохирдуулахтай холбоотой төлбөрүүд бол дийлэнх нь тухайн аймагтаа очдог. Хөрөнгийн татварууд, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар болон хувь хүний орлогын албан татвар гээд маш олон төрлийн татварууд бол тухайн аймгийнхаа орлогыг бүрдүүлдэг. Тэгэхээр тухайн аймаг уул уурхайг дэмжээд бол уул уурхайн томоохон бүтээн байгуулалт, үйл ажиллагааг явуулсан тохиолдол зөвхөн АМНАТ-аас гадна маш олон төрлийн татварууд, татварын орлогууд тухайн орон нутагт хуваарилагддаг ийм одоогийн хууль, эрх зүйн зохицуулалт байгаа.

Үндсэн хуулиар байгалийн баялаг бол нийтийн өмч гэсэн ийм заалт байдаг. Тэгэхээр дахиад хэлэхэд зөвхөн тэр аймгийн өмч гээд бүх орлогоо авах ч гэдэг юм уу, түлхүү авах гэдэг энэ хандлага өөрөө 2 талтай байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бас хуулийн ажлын хэсгийн хүрээнд бас нарийвчилж ярих боломжтой гэж бодож байна. Баярлалаа.

Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Яах вэ, ер нь Монголын ард түмэн Монголын аж ахуйн нэгжүүд юунд дургүй байна вэ гэхээр ерөөсөө л ухсан нүхэн дээр л хэдэн ядуу хүн үлдээд байгаа юм л даа. Сүүлийн 20, 30 жил бид нар ядуурлаас салж чадсангүй 30 хувьтай хэвээрээ л байгаа. Төр маань улам л данхайгаад.

Яагаад яаралтай горимоор хэлэлцээд байгаа юм бэ? Тэрийг би тодруулъя гэж бодоод байсан юм. Тэрийг тодруулж хэлж өгөөрэй.

Цөмийн эрчим хүчний тухай хууль гэж байгаа юм. Цөмийн цөмийн энергийн тухай хуульд ингээд нэмэлт, өөрчлөлт оруулна гээд бид нар яриад байна. Бид нар жоохон юмнуудыг хутгаад байгаа юм биш үү. Энэ цацраг идэвхт ашигт малтмал шүү дээ энэ чинь ерөөсөө. Цөмийн энергийн тухай хуульд оруулснаараа бид нар их цөмийн энергитэй өнөө, маргаашгүй болчих гээд байгаа юм ерөөсөө байхгүй. Бид нар заримдаа бас тэр эрчим хүчний реформ хийнэ гээд л, үнэ нэмчихсэнээрээ тэрүүгээр реформ хийчихлээ гэж ойлгож болохгүй гэх мэтчилний ийм асуудлууд байгаа. Ингээд хольж хутгаад байна.

Нөгөө талаар ингээд бүтээгдэхүүн гарна. Энэ бүтээгдэхүүнээ яаж хуваарилж байгаа вэ? Монгол Улс өөрөө тэрийгээ мэдээд зарах эрхтэй юү? Гаднын хөрөнгө оруулагчид хоёрхон зүйлийг сонирхоод байх шиг байна сүүлийн үед бол. Нэг нь болохоор уран байна, нөгөөдөх нь газрын ховор элемент байна. Монголын ард түмний зарим хэсэг нь уран, газрын ховор элемент хүртлээ ялгахгүй байна шүү

дээ. Ингэж хооронд нь хутгаад байна. Тэрийгээ ч та нар тайлбарлахгүй байна. Тэр хүмүүсийн буруу биш. Тэгээд энэ тал дээр их улс орон маш чадварлаг тоглож байна. Энэ байгаа бүтээгдэхүүн дээрээ. Бид нарт байгаа юм газрын ховор элементийг жишээлбэл, манай урд хөрш яаж ашиглаж, яаж хэрэглэж, яаж бодлого болгож явуулж чадаж байна? Бид нар тийм л байх хэрэгтэй. Уран, уран дээр гэхэд Казакстан яаж ажиллаж чадаж байна.

Тэгээд энэ юмыг ул нь яаралгүй, сайн хэлэлцээд, ард түмэндээ ойлголт өгөөд. Уул нь энэ дээр яриад байгаа юмнууд дандаа л татварын л асуудал байна шүү дээ. Тэгээд дотоодын аж ахуйн нэгж энэ ард түмнийхээ оролцоог яаж оролцуулах юм тэгээд? Ард түмэнд чинь юу ч наалдахгүй, баахан дарга нар баяжчихаад, тэгээд жоохон юмаар халамж тараачхаад ингээд байхаар чинь энэ хүмүүсийн чинь итгэл унаад байна шүү дээ. Тэгээд явж явж байгаад хэдэн хоосон нүхэн дээр суусан хэдэн ядуу хүмүүс үлдэх гээд байна. Хамгийн наад зах нь юу яачихмаар байна? Франц манайхыг хамгийн түрүүнд тусгаар тогтносон улс болохыг дэмжсэн. Бүр эрт үеэсээ эхлээд бид нар тэр Ил хаан захиа бичээд, хүлээж аваад ингээд явж байсан ийм түүхтэй орон. Одоо ганц сэтгэл гаргаад Монголын ард түмэн ойлгох ийм боломжийг нь хангаад харилцан визгүй болгочихмоор байгаа юм. Энэ

Г.Тэмүүлэн: Асуултад Туваан сайд хариулах уу? Туваан сайд. Учрал сайд юм уу?

Н.Учрал: Яаралтай горимоор Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Ер нь бол хуучин ямар жишиг яваад байсан юм бэ гэхээр нөгөө гэрээгээ хавсралтаар оруулж ирээд, хууль дагуулж өөрчилдөг. Тэгэхээр энэ жишгээс ер нь холдъё л гэж зорьсон юм. Хууль, эрх зүйн орчноо тодорхой болгочоод өөрсдийнхөө эрх зүйн орчинд тохирсон хэлэлцээрийг хийж чадвал энэ өөрөө зөв жишиг болно. Тэрнээс биш яг нөгөө хэлэлцээ хийж байгаад гэрээгээ, хөрөнгө оруулалтын гэрээгээ хамт оруулж ирээд дагаад хууль өөрчилчихвөл тэр гэрээнд нийцүүлсэн хууль гаргаж болохгүй л дээ.

Тийм учраас нэгэнт тэр протокол дээр тэр тусгай АМНАТ-ын босгыг чинь авч хаяж байгаад, өсөн нэмэгдэх АМНАТ гэж ойлголтыг бий болгож байгаад, ингээд нөгөө талаас бид нарт ийм боломжийн бас саналууд тавиад байхад бид нар энэ босго чинь 5-аас дээш гарч болдоггүй юм хуулиараа хатуу юм гэж хэлээд байх нь зохимжгүй. Нэг ёсондоо цаашаа хэлэлцээ үргэлжлэх гэхээр хууль, эрх зүйн орчин тодорхой болох шаардлага зайлшгүй үүсээд байсан.

Ер нь Ерөнхийлөгчийн айлчлал чинь хэзээ билээ? 10 сард болсон тэрнээс чинь хойш ингээд бараг бүтэн жил болчихоод байна шүү дээ. Тэгээд олон ч ажлын хэсэг байгуулагдсан. Тэгээд бидний үед ч биш, энэ өнгөрсөн Засгийн газрын үед бас л энэ ажлын хэсэг байгуулагдаад л нэлээн урагшилж байсан.

Хоёрт, ирэх жилээс дэлхий нийтэд 120 мянга, 20 мянган тонн ураны эрэлт байна. Гэтэл дэлхийн бүхий л улс орнууд 80 мянгыг л нийлүүлж чадах юм байна. Тэгэхээр ураны үнэ зах зээл дээр өсөх нь бол дамжиггүй болж байгаа юм. Эрэлт, нийлүүлэлтийг харахаар. 2028 онд бол бас энэ ураны дэлхийд том бүүм болох гэж байна шүү дээ. Тэгээд бид тэр тоглолтоос бол хоцорч бас болохгүй юм. Ингээд жилд 2500 тонн нийлүүлдэг болчихвол бид бол дэлхийд эхний 4, 5-д орох бололцоо бол бүрэн дүүрэн байгаа. Анх тэр 97 онд тэгээд би бас хэлээд байсан

тэр Цэнгүүн гишүүний төрж байсан өдөр, эхэлсэн тэр төлөөлөгчийн газар чинь 27 жилийн хугацаанд хэлэлцээд байдаг бид нар.

Гэтэл энэ 27 жилийн хугацаанд Казахстан гэдэг улс борлуулалтаараа дэлхийд тэргүүлээд эхэлчихлээ шүү дээ. Тэгэхээр бид нарт тийм хугацаа алдаад байх боломж байхгүй. Энэ ч утгаараа бол бас яаралтай горимоор хуулиа эхлээд явуулъя. Энэ бол ерөөсөө гэрээ биш. Хуулиа явуулъя, хуульдаа нийцсэн гэрээгээ, төслөө та бүхэнд танилцуулъя, тэгээд энийг Их Хурал л шийднэ шүү дээ. Тэр АМНАТ-ын хэдээр төрийн эзэмшлийн 34-ийг хэдээр орлуулах юм, АМНАТ-ыг юу гэж тооцох юм? Энэ бол Их Хурлын бүрэн эрх. Тэгэхээр Их Хурал өөрөө л шийднэ.

Тэгэхээр хуулиа боловсруулъя, дараа нь гэрээгээ оруулж ирээд Их Хурал шийдвэрээ гаргаач л гэж ингэж хүсэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Туваан сайдад нэмж хариулах уу, үгүй юу? Туваан сайд.

Ц.Туваан: Анхнаасаа энэ Цөмийн энергийн хууль дагалдуулаад Ашигт малтмалын тухай хуулийг оруулж ирье гэж ингээд явж байсан юм. Тэгэхээр Ашигт малтмалын тухай хууль маань бас нэлээдгүй асуудал дагуулна. Тэгэхдээ бид нар ингэж хууль дагуулж оруулж ирэх биш, удахгүй ажлын хэсэгтэйгээ ярьж байгаад энэ хуулийнхаа өөрчлөлтүүдийг нэгмөсөн оруулж ирж байгаад ингээд оруулж ирье ингээд Цөмийн энергийнхээ хуулиар оруулаад явчих боломжтой гэдэг энэ байдлаар оруулж ирсэн.

Тэгээд энэ тийм, Цөмийн энергийн хуульд бас яагаад оруулж байна гээд тэгэхээр энэ өөрөө шар нунтаг, эндээс цаашаагаа нөгөө цөмийн эрчим хүч үйлдвэрлэх асуудлууд ингээд явж байгаа учраас энэ хуульд бас ороод явах нь зөв гэдэг байдлаар Засгийн газраас оруулж ирсэн.

Сая Ганбат гишүүн бас яг л хэлж байна л даа. Энэ Казахстаны уранаа ашиглаад дэлхийн бас уран олборлолт, нийлүүлэлтээрээ 1 номерын улс болоод явчхаж байна. Дээрээс нь Казахстанд Францтай хамтарсан ураны цөмийн реактор яваад өгч байна. Тэгэхээр тэнд ингээд асуудлуудаа шийдээд яваад байгаа байхгүй юу. Монгол Улс өнөөдөр гэхэд энэ асуудлыг цөмийн энерги, атомын цахилгаан станц гэж айж юм ингэж явсаар байгаад энэ асуудлуудаасаа үлдээд бид нар өнөөдөр эрчим хүчний хамгийн их дутагдалтай, хамгийн хямд бөгөөд хүлэмжийн хий хамгийн бага ялгаруулдаг энэ цөмийн эх үүсвэрээс ингээд татгалзаад яваад байгаа энэ тэр асуудлууд нь бас л хоцрогдол, энэ ард түмэнд энэ утаатайгаа байх, эрчим хүч дутагдалтай байх гэсэн энэ асуудал дээр бас л хамаарна л гэж ингэж үзэж байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр цөмийн, атомын цахилгаан станцын суурь судалгааг эхлүүлэх энэ зүйлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр оруулж өгсөн байгаа гэдгийг нэмж хэлье.

Г.Тэмүүлэн: Саяын эцсийн бүтээгдэхүүнтэй холбоотой Монгол улс зах зээлд зарах эрх нь байгаа юм уу гэсэн асуулт бас асуулт асуусан байсан. “Мон Атом” хариулах уу энэ дээр? Хэн хариулах вэ? Ганбат гишүүн сая асуусан бүтээгдэхүүнээ Монгол Улс зарах эрхтэй байх уу, байхгүй юу гэдэг асуудал. Мон Атом уу? 3 номер. 3 номер.

Д.Сугарсүрэн: “Мон Атом” Сугарсүрэн байна Захиргаа удирдлагын албаны дарга.

Өөрийн бүтээгдэхүүнээ захиран зарцуулах эрх байгаа.

Г.Тэмүүлэн: 3 номер дахиад нэмээд дэлгэрэнгүй тайлбар өгчих.

Д.Сугарсүрэн: Өөрийн эзэмшиж байгаа хувьцааныхаа харьцаагаар өөрийн бүтээгдэхүүнээ захиран зарцуулах эрхтэй байгаа. Нөгөө Ерөнхийлөгч нарын хооронд яасан харилцан ойлголцсон протоколоор 10 хувийн бүтээгдэхүүнээ захиран зарцуулах эрхтэй байхаар урьдчилсан тохиролцоод байж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн тодруулчих тэгээд нэмээд хариулаарай Далайжаргал захирал.

Ганбат гишүүн.

Д.Ганбат: Яах вэ ерөнхийдөө ийм л хариулт өгөөд байгаа юм. Та нар өөрсдөө л мэдэхгүй байна шүү дээ яг. Бүтээгдэхүүнийхээ зах зээл дээр тэр шар нунтгийнхаа хэдэн хувийг зарах эрхтэй юм, хэдэн хувийг нь зарж болох юм? Тэр гэрээндээ сайн нарийн тусгах хэрэгтэй. 10 хувь гэж хариулаад л, 34 хувь гэж хариулаад л. Ингээд л тодорхойгүй юм яриад байх юм. Тэгээд ийм л мэдлэгтэй ажлын хэсэг энд сууж байхаар энэ чинь үр дүнтэй хэлэлцүүлэг болж чадахгүй байна.

Хоёрдугаарт, энэ яаралтай горимоор орж ирэхээр ийм чухал асуудлуудыг ингээд нөгөө монголын ард түмэн чинь газрын хэвлийн баялаг ард түмний өмч гэгчихсэн байгаа шүү дээ. Тэр мэдэх эрх нь хангагдахгүй байна. Тэгээд яг энэ яаралтай горимоор хэлэлцэх үндэслэл бүхий тийм тайлбаруудыг өгч чадахгүй байна л даа. Яах вэ, тэр бид нар цөмийн энергитэй болтлоо их олон зайтай байгаа хугацаа байгаа шүү дээ. Бараг 10, 20 жилийн дараа л юу юм гэхээс биш. Техник, технологи өөрчлөгдөөд сайжрах л байх л даа. Тэгээд хамгийн түрүүнд бас боломжоороо ард түмэндээ хэрэгтэй, ард түмэнд ойлголт өгөхийн тулд тэр Франц Монгол хоёрын харьцаа маш сайхан шүү дээ. Тэгээд харилцан визгүй болгочихвол манайх чинь Европ руу нээгдэх гээд байна шүү дээ. Ийм юмаа наад талд, наад зах нь хийчихмээр байгаа байхгүй юу. Жоохон сэтгэл гаргах хэрэгтэй.

Тэгээд гүйцээгээд хариулчхаарай. Бас тэр визгүй зорчих барьчих боломж байгаа юу? Тийм ажил хийж байна уу, тэрийг бодож барьдаг хүн байна уу? Янз бүрийн сангууд байсан. Ирээдүйн өв сан гээд л, мөн Нийгмийн даатгалын сан гээд л энэ бүх юмыг тоноод дуусгачихсан шүү дээ бид нар чинь, ЖДҮ-ийн сан гээд л. Одоо Баялгийн сан чинь аягүй л бол ядуурлын сан болоод дуусчих вий. Тийшээ баахан юм хийж байгаад айн. Маш их анхааралтай, хариуцлагатай ажиллана шүү нөхдүүд минь.

Г.Тэмүүлэн: Туваан сайд асуултад хариулъя.

Ц.Туваан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Яаралтай горимоор орж ирсэн. Тэгээд цаг хугацаа хожихгүй, цаг хугацаа бас биднийг хүлээхгүй байгаа. Дээрээс нь энэ хууль батлагдаад ингээд энэ цөмийн энергийн энэ Орана-тай холбоотой асуудал дуусаж байгаа юм биш. Энэ тун удахгүй дахиад энэ хөрөнгө оруулалтын гэрээ Улсын Их Хурлаар орж ирнэ. Тэгэхээр энэ гэрээ хэлэлцэгдэх үед бол ард нийтээрээ бүгдээрээ, бага ард түмнээрээ хэлэлцүүлж байгаа энэ процессыг ингээд хараад бас ингээд явах учраас мэдээллийн хувьд нэлээн хангагдах байх гэж бодож байгаа.

Шар нутгийг олон улсын биржийн 1 сарын дундаж үнээр үнэлнэ. Одоо өнөөдрийн байдлаар 80 хэдэн доллар гээд байгаа. Тэгээд энэ тухайн үед байгаа борлуулсан үнээс нь нөгөө саяын тавьсан хувиудаа шууд тавиад тавиад, аваад ингээд явчихна. Тэгэхээр түрүүний тэр дийлэнх олонх гэдэг буюу 50-аас дээш хувь энэ борлуулагдсан үнээс нь шууд бодогдоод ингээд ороод ирэх ийм давуу талтай байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд танхимд орж ирээрэй. 1 хүний дараа санал хураалт явагдахаар байна. Дамдинням гишүүн асуулт.

Г.Дамдинням: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе ажлын хэсэгт бас. Тэгээд яах вэ, бид нар уурхайн төслүүдийг яриад л байдаг юм. Тэгээд уул уурхай тойрсон асуудал гэж яриад байдаг боловч яг цаг дээрээ тулахаар уул уурхай тойрсон асуудлууд яг уул уурхайн асуудал байдаггүй л байхгүй юу. Тэндээс орж ирж байгаа орлогыг нь, мөнгийг нь яаж зарцуулж байгаа тухай л асуудал болоод хувирч байдаг юм. Уул уурхайн салбар яах вэ хөөрхий мөнгөө олж ирээ гээд л ингээд л явж байгаа салбар шүү дээ.

Орана-гийн энэ төслийн гэрээг хийхийн тулд бид нар энэ хуулиа өөрчлөхөөс өөр аргагүй болж байгаа нөхцөл байдалтай байгаа учраас шуурхай орж ирж байгааг ойлгож байна. Энэ хаалтын гэрээ, төслийн хаалтын менежмент, хаалтын зардлыг нь цуглуулах тэр мөнгөөр авах гээд байна уу, бүтээгдэхүүнээр авах гээд байна уу? Энийг ер нь та нар энэ манай энэ Уул уурхайн хуульд, Ашигт малтмалын хуульд энэ сайн тусаагүй байдаг байхгүй юу. Тэгэхээр энийг ер нь та нар яаж хараад байгаа вэ төслийн хэмжээнд? 34 жил болно гэж байна. 34 жилийн дараа хэр хэмжээний мөнгө үлдэх юм энэ санд нь? Бүтээгдэхүүнээр авч үлдэх гээд байна уу, эсвэл мөнгөөр авч үлдэх гээд байна уу? Мөнгөөр авч үлдвэл мөнгө нь Монголдоо байх юм уу, эсвэл гадаадын дансандаа аваачиж хадгалах гээд байна уу тээ? Энийг хариулаад өгөөч.

Дараа нь энэ төсөл хөрөнгө оруулалтаа хэзээ нөхөхөөр тооцоологдоод байгаа юм? Яагаад энийг асууж байгаа вэ гэхээр гэрээний энэ хууль дээр чинь бид нар юм оруулж ирэх байх л даа. Гэрээгээ дүгнэхээр дунд нь бас явцын дүгнэлт хийдэг хугацаанууд хийхгүй бол Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ чинь 30 жилд 1 дүгнэнэ гээд хийгээд түгжээд хаячихсан.

Тэгээд нэгэнт хийчихсэн гэрээ учраас бид нар өөрчлөлт оруулж чаддаггүй ингээд гацчихдаг байхгүй юу. Тэгэхээр ядаж хөрөнгө оруулалтаа нөхсөнийх нь дараа үеэр нь ч юм уу гэрээгээ энэ хугацааг нь хэдүүлээ харчих ёстой байх. Хэдэн жилд дунд нь дүгнэх юм? 5 байх юм уу, 10 байх юм уу, 20 байх юм уу тээ? Тэгээд энэ хуулийн өөрчлөлтийн хүрээнд энэ орж ирж байгаа юу? Тэгэхгүй бол бид нар ч яах вэ, тэгээд л 4 жилийн хугацаа тэгээд л нэг хэсэг нь байгаа л, байхгүй гээд л явна биз. Энэ чинь бас 34 жил үргэлжлээд явахад дараа дараачийн нөхцөл байдал үүсэхэд, гэрээнд өөрчлөлт оруулах нөхцөл, боломж нь гарч байх ёстой байхгүй юу. Тэгээд тэр үүд хаалгаа нээлттэй байх боломжийг та нар хийж байгаа юу гэдэг асуудал.

Дараагийн асуудал. Ураны төслүүд дээр яах вэ дээ тэгээд л гүний усны асуудал яригддаг юм. Гүний усыг хамгаалж чадаж байгаа юу, үгүй юү гэдэг л асуудал яригддаг юм. Тэгэхээр энэ манай эрх зүйн зохицуулалтын хувьд энэ гэрээн дээр усныхаа аюулгүй байдал дээр, энэ төслийн энэ аюулгүй байдлынх нь

хувьд болж байна гэж үзээд байгаа юу манай энэ усныхан? Дараа нь гэрээнээс энэ заавал 10 хувь авах гээд байх хэрэг байгаа юм уу даа. Зардлыг нь өөрсдөөр нь 100 хувь гаргуулаад, ачааллыг нь үүрүүлээд тэгээд роялтигаа бүр өсгөөд авчихвал яад.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя Туваан сайд.

Ц.Туваан: Энэ төсөл ашиглаад дууссаны дараа энэ нөхөн сэргээлтийн асуудал байгаа. Энэ дээр нэлээн онцгой анхаарч байгаа. Тэгээд энэ, энэний баталгаа болгож санхүүгийн асуудал яригдана мэдээж. Энэ мөнгийг бол ямар нэгэн хэлбэрээр биш шууд мөнгөн хэлбэрээр төрийн дансанд авахаар энэ төсөл дээр орж ирсэн байгаа гэдгийг хэлье. Тэгээд энэ дээр мэдээж түрүүн хэлсэн Их Хурлын өчигдөр ажлын хэсэг Эдийн засгийн байнгын хороо энэ тэр дээр бас зарим зарим саналууд гарч байсан. Тэгээд энэ бас баталгаа л болгож гаргаж байгаа ийм асуудал байгаа. Тэгэхээр энийг Байнгын хороон дээр шийдэх боломжтой байгаа өөр асуудал. “Мон Атом”.

Г.Тэмүүлэн: Гэрээний хэрэгжилтийг дүгнэх эсэх. “Мон-Атом” Далайжаргал захирал 2 номер. Дараа нь гүний ус^

Д.Далайжаргал: Далайжаргал байна. Дамдинням гишүүний асуултад хариулъя. Энэ төсөл ашгаа 13 жилийн дараа нөхнө. Таны асууж байгаа тэр гэрээний дүгнэлтийг мөн 13 жилийн дараа гэрээгээ дүгнэнэ. Нийтдээ 320 сая доллар бол нийт 33 жилийн дотор бол байгаль орчны нөхөн сэргээлтийн мөнгө гэж нийт орлогоосоо жил 3.7 хувийг тооцоод нийтдээ 34 жилийн дараа 320 сая доллар нөхдөг юм. Тэр байгаль орчны усны, уусны асуудал бол энд энийг буруу ойлголт яваад их хэмжээний ус байна гэдэг ойлголт буруу ойлголт шүү. Газрын дунд 140-170 метр дотор уран чинь шаварлаг нойтон элсэн дээр байгаа. 10 хувь нь ус, 20 хувь нь элс, шавар гэсэн ийм бүтэцтэй байгаа. Тэрэнд 99 хувь нь ус, 1 хувь нь хүхрийн хүчил гэсэн ийм проценттой усыг шахаад. Тэгэхээр проценттой ус, 1 хувийн хүхрийн хүчилтэй усанд нь элсэн дээр наалдсан уран нь шингээд усанд нь шингэж байгаа. Тэгэнгүүт нь усыг нь, урантай усыг нь татаж аваад, уснаас нь ураныг нь салгаж авдаг ийм л процесс.

Г.Тэмүүлэн: Туваан сайд.

Ц.Туваан: Энэ 10 хувийн энгийн 34 хувийн хувьцааг давуу эрхийн 10 хувьтай хуваарилж шилжүүлэх асуудал байгаа. Тэгэхээр энэ 10 хувийн хувьцаан дээр бид нар ямар нэгэн санхүүгийн эх үүсвэр, санхүү хуваалцах ийм үүрэг хүлээхгүй. Дээрээс нь давуу эрхийн хувьцаа учраас энэ хамгийн түрүүнд шууд энэ 10 хувийн орлого шууд орж ирэх байдлаар байгаа. Тэгэхээр 10 хувь байсан нь зөв гэдэг байр суурь хэлье.

Г.Тэмүүлэн: Дамдинням гишүүн нэмж тодруулъя.

Г.Дамдинням: Яах вэ, тэгээд 34 жилийн дараа төрийн санд 320 гаруй сая доллар цуглаад л тэгээд л тэрүүгээр хэдүүлээ хаалтын менежментээ хийх нь байна шүү дээ. Тэгээд төрийн сан тэр цуглах мөнгө ч дээ тэгээд тэтгэврийн сангаа дуусгачхаад байгаа улс шүү дээ. Уг нь бол олон улсын жишиг нь бол гадаадын дансанд л хадгалдаг юм. Гадаадын дансанд л хадгалдаг юм. Нэг бол бүтээгдэхүүнээр авдаг юм. Сайн яриарай Туваан сайдаа. Эргээд хэдүүлээ баахан хаалтын менежмент хийх зардалгүй, нөгөөдхийг нь аваад тэтгэвэр бүх юмандаа

тавиад дуусгачихсан, тэгээд хаалтын менежмент нь жинхэнээсээ үндэсний аюулгүй байдлын асуудал болно шүү дээ энэ цацрагийн менежмент бол.

Тэгэхээр энийгээ бас хэдүүлээ бодно шүү. Энэ бол жинхэнээсээ аюул болно шүү. Тэгэхээр хаалтыг хийх төлөвлөгөө маань тодорхой зардал нь тодорхой бүтээгдэхүүнээрээ байх юм уу, юугаараа байх юм гэдгээ тодорхой хийж байж энэ төслийг эхлүүлэх хэрэгтэй. Уул уурхайн төслийг эхэлье гэж байгаа бол яаж хаахаа түрүүлж ярих ёстой байхгүй юу. Тэгж байж л уул уурхайн төсөл явна. Үгүй бол явахгүй.

Тэгэхээр энэ гэрээний явцад та нар энэ мөнгөө хаана хадгалахаа бас яриарай. Олдохоо байчихна шүү. Дараа нь тэгээд улсын төсвөөс нөгөө хаалтын менежментийг нь хийдэг мөнгө хийх юм бол ёстой бүтэхгүй юм руугаа явна шүү дээ хэдүүлээ. Энийгээ анхаарна биз.

Тэр 10 хувийн тухайд бол заавал эрсдэл тэгж бодвол тэгээд Францын талаас заавал та нар зовлонгоо хуваалц гэж шахаж байгаа байлгүй дээ. Би бол тэгж л бодож байна. Түүнээс уг нь бол хувь эзэмшээд байх ямар ч хэрэггүй юм байгаа юм шүү дээ. Одоогийн байгаа хууль, эрх зүйн орчны, одоо энэ өөрчлөлтөөр заавал 10 хувийг авахгүй байх хувилбар ер нь яригдаж болох уу? Тийм уг нь бол. Энэ дээр тодорхой хариулаад өгчихвөл зүгээр байна.

Энэ гэрээний дүгнэлтийг 13 жилд 1 удаа дүгнэх гээд байгаа юм уу? Хэд хэдэн жил дүгнэх юм? Тэрийг нь тодорхой хэлээд өгөөч. Хэд хэд дээр та нар ямархуу маягаар оруулж ирж байгаа юм?

Г.Тэмүүлэн: Туваан сайд асуултад хариулъя.

Ц.Туваан: Дамдинням гишүүнтэй санал нэг байна. Яагаад гэхлээр бас Дамдинням гишүүн өөрөө уул уурхайн чиглэлийн мэргэжилтэй бөгөөд уул уурхайн дэлхийн тэргүүлэх улсад бас мэргэжил эзэмшсэн мэргэжлийн боловсон хүчин болохоор бас маш зөв асуудал тавьж байна. Тэр нь юу гэхлээр энэ түрүүний миний хэлдэг нь нөгөө Их Хурал байнгын хороо шийднэ гэдэг нь бид нар бас анхаарч үзье. Тэгээд төрийн сан биш өөр олон улсад ч юм уу эс үгүй бол өөр, ямар нэгэн байдлаар өөрчлөөд явах дээр боломж байгаа гэдгийг бас хэлье.

Дараагийн асуулт дээр манай хэн тэр 10 хувь байхгүй байх дээр Цолмон хариулчих уу хэн. 7, 7 номерыг өгчих.

7 номер.

С.Наранцогт: 10 хувийн эзэмших асуудал дээр яг таны хэлж байгаа Дамдинням гишүүний хэлж байгаа хөрөнгө оруулалтын талаас энэ дээрээ бас хатуу байр суурьтай байгаа. Энэ бол том хэмжээний төсөл, стратегийн төсөл учраас Засгийн газар өөрөө энд хувь эзэмшигч байх нь зүйтэй. Ингэж байж ашиг сонирхлын хувьд ч тэр, төслийн тогтвортой байдал гэж их ярьж байгаа энэ эрсдэл, та нар Засгийн газар өөрөө энд огт хамаагүй, хувьцаа эзэмшигчийн байр сууринаас биш байх юм бол бас төслийн тогтвортой үйл ажиллагаанд эрсдэлтэй байна гэж үзэж байгаа. Тэгээд 10 хувийг бид нар бас дээр нь АМНАТ-аар нэмж солих бас боломжгүй байдал үүсээд байгаа юм. Энэ бол ингээд дэлхий дээр байхгүй хамгийн өндөр АМНАТ та нарт тогтоосон. Тийм учраас 10 хувийг бид нар авсан ч тэр, аваагүй ч тэр АМНАТ-ыг төдийлөн сайн нэмж чадахгүй ийм нөхцөл

байдалтай. Тэгэхээр бид давуу эрхийн 10 хувь гээд авчихаар бас бид нарын хувьд давуу байдал бас хүсэж байгаа л гэж ойлгох ёстой.

Г.Тэмүүлэн: Далайжаргал захирал 2 номер. Гэрээний дүгнэлт.

Д.Далайжаргал: “Мон Атом” Далайжаргал. 5, 5-н жилээр оруулж байгаа юм. Гэхдээ энэ чинь гэрээ байгуулаагүй байгаа шүү дээ. Төсөл хэлбэрээр явж байгаа. Тэгээд яаж ярьж явна. Төсөл дээр 5, 5 жилээр.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн асуулт асууя. Гишүүд танхимд орж ирээрэй санал хураалт явагдана.

Э.Болормаа: Би 4 асуулт асууя ажлын хэсгээс. Юуны өмнө энэ удаагийн хуулийн төсөл дээр орж ирж байгаа зүйл нь ихэнх нь санхүүгийн талдаа л зүйлс орж ирж байна л даа. Тэгээд бид нар хэд хэдэн удаа хэлж байна. Оюу толгой дээр алдсан гэдэг байдлаар сая Ганбаатар гишүүн бас хэллээ. Тэгэхээр энэ дээр яг бүр албан ёсоор ажлын хэсэг дээр Оюу толгойн ТУЗ дээр байгаа манай санхүүгийн мэргэжилтнүүд ч юм уу, Эрдэнэс Оюу толгой дээр энэ дээр яг бас дүгнэлт авъя гэж бодож байна.

Яагаад гэвэл бид нар энийг олон нийтэд ойлгуулахын тулд бид нар өөрсдөө ч гэсэн ойлгоход яг юугаараа алдсан юм, ямар боломжит хувилбарууд байсан юм, эргээд бодоход эдийн засгийн тооцооллоороо ямар алдагдсан боломж юуг бид нар нөхөх гээд байгаа юм бэ гэдэг санхүүгийн талаас нь энэ асуултыг бас асуумаар байна. Тэгээд ажлын хэсэгт Оюу толгойн хүмүүс байгаа юу? Бид нар өнөөдөр жишээлж хамгийн том харьцуулж болох төсөл учир.

Хоёр дахь нь энэ Орана-тай холбоотой зүгээр мэдээгээр хайгаад л үзэж байна л даа. Орана-гийн дэлхийн үйл ажиллагаан дээр хамгийн сүүлд 24 оны 6 сард Нигер улсаас Орана хөөгдсөн байна л даа. Лиценз нь цуцлагдсан байна. Энэ яг ямар шалтгаантай юм? Дэлхийд явуулж байгаа үйл ажиллагаанууд нь ямар байгаа юм? Миний ойлгож байгаагаар бараг адилхан Францаар ярьдаг улсууд байгаа байх. Тэнд юу нь ойлголцож болохгүй, яагаад үйл ажиллагаа нь явагдаж болохгүй байгаа юм бэ? Тэр дээр та бүхэн судалсан уу гэдгийг асууя.

Гурав дахь нь энэ “Мон Атом”-той холбоотойгоор асууя. Сая усны асуудал дээр нэлээн энэ буруу ойлголт шүү дээ ухааны ингээд байдлаар хаячхаж байна л даа. Энэ олон нийтэд явагдах хэлэлцүүлэг ч түрүүн Наранбаатар гишүүн хэлж байна. Ховд аймагт болж байгаа, өмнө нь үүнтэй холбоотой байсан зүйлс бүгд зүй ёсны ер нь тавигдах шаардлагууд энэ байгаль орчны, хүний эрүүл мэндтэй холбоотой эрсдэлүүд энийг ийм хөнгөн байдлаар хаямааргүй байна. Зүгээр энэ чинь үл ойлголцол шүү дээ. Энэ оруулж ирж байгаа хууль дандаа мөнгөн талаас нь яриад байгаа байхгүй юу.

Гэтэл яг сая Дамдинням гишүүний хэлдэг тэр эцэст нь хаахаас авхуулаад тэр эрсдэлүүдийг яагаад ярихгүй ийм хөнгөн ярьж байгаа юм бэ? Яг энэ “Мон Атом”-ыг удирдаж байгаа хүмүүс та нар би зүгээр шууд асууя. Ямар мэргэжилтэй, ямар чадвартай, туршлагатай хүмүүс юм бэ? Яг энэнийхээ талаар мэргэшилтэй хүмүүс юм уу? Энийг мэддэг болоод би зүгээр л дэлхийн судалгаануудыг улсаас ураныг гэхэд шууд байгаль орчны эрсдэлүүдийг нь ярьж байна. Эрүүл мэндийн эрсдэлүүд. Дэлхийн бөөн жишээнүүдийг бас дурдаж байна шүү дээ. Энэ чинь тийм хөнгөн хуумгай хаяад байх зүйл биш биш гэж хараад байна. Одоо энэ тилингийн

асуудлууд нь хэдэн мянган жилийн л бодит эрсдэл шүү дээ. Энэ эрсдэлээ яаж хаах тийм итгэл төрүүлэхүйц яг бодитой судалгаагаар энэ дээр хариулаач гэж хүсэж байна.

Энэнтэй холбоотойгоор дөрөв дэх асуулт юу вэ гэхээр олон нийтийн хэлэлцүүлгийг яаж хийж байгаа вэ? Энэ Хэрэг эрхлэхийн сайд гарчихсан байна уу, үгүй юү Учрал сайд? Энэнтэй холбоотой олон нийтийн хэлэлцүүлэг та бүхэн ямар.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: 2 номер, дараа нь Туваан сайд. Далайжаргал захирал.

Д.Далайжаргал: Болормаа гишүүний асуултад хариулъя. Франц улс, Нигер, Канад, Габон гэсэн 3 улсад уран олборлож байсан. Өнгөрсөн жил Пригожн гээд төрийн эргэлт хийгээд, Нигерт төрийн эргэлт хийж, цэргийн эрх нь гарсан учраас Француудыг гаргаж явуулсан. Одоо Франц, Нигер Францын Засгийн газартай өнгөрсөн хугацаанд олборлосон шар нутгаа гаргах асуудлаар хэлэлцээр хийж байгаа. Тэр юуны байгаль орчны хувьд үнэхээр санаа зовж байгаа бол бид нар зүгээр хөнгөн байдлаар хийгээгүй. Өнгөрсөн хугацаанд 8 удаа судалгаа, шинжилгээ хийсэн. Тэнд бас нөгөө гадаадын 2 том багийг оруулж ирсэн. Тэр дотор олон улсын эрчим хүчний агентлаг маягтай, Канадын байгаль орчны том үнэлгээ хийдэг компани гээд нийлээд 8 удаа судалгаа хийсэн 2017 оноос хойш. Бүгд нэг дүгнэлт гарсан байгаа. Тэгээд Тэгшбаяр доктор энэ талаар бас асуулт өгөх үү? Тийм. Би бол Олон улсын харилцаа, дипломат мэргэжилтэй хүн.

Г.Тэмүүлэн: Нэмээд хариулчих. Далайжаргал захирал 2 номер.

Д.Далайжаргал: Сугарсүрэн манай Эрх зүйч мэргэжилтэй, манай Алтанхундага Уул уурхайн эдийн засагч, инженер мэргэжилтэй хүн байгаа, манай экспертүүд байгаа энэ. Экспертүүд манай Тэгшбаяр доктор байна, манай Жамсрандорж манай зөвлөх байна. 70 оноос хойш геологич хийж байгаа ураны бүх ордуудыг нээсэн геологич байна, манай Ганболд, академич Ганболд гээд малын эмч Мал хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан хүн байгаа.

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ? 5 номер.

Н.Тэгшбаяр: Болормаа гишүүний асуултад хариулъя. Энд санаа зовж байгаа.

Г.Тэмүүлэн: Албан тушаал, нэрээ.

Н.Тэгшбаяр: Ер нь энэ бид нар ингээд зохиочихсон энэ технологи биш. Дэлхий дээр ойролцоогоор нийт олборлож байгаа ураны 56-60 орчим хувийг нь газар доор уусган баяжуулах аргаар олборлож байгаа. Энэ олборлоогүй байсан ч гэсэн тэр дэлхий үүсэхэд тэнд нөгөө уран байгаа бол тэнд цацрагийн эрсдэл байгаад тэнд химийн хоруу чанартай тийм орчин байгаа учраас энийг ингээд олборлоход ямар нэгэн юу гэдэг юм, тэнд байгаа ураныг гаргаад олборлоод явахад бол хүлээн зөвшөөрөгдсөн технологиор дэлхийд олборлодог аргаар олборлох учраас энд бол санаа зовох зүйл байхгүй.

Харин цөмийн болон цацрагийн хяналт гээд Олон улсын атомын энергийн агентлагийн гаргасан дүрэм, журам, одоо Монгол Улсад бол цацраг идэвхт ашигт малтмалыг эрэх, хайх, олборлох тээвэрлэх, цацрагийн аюлгүйн норм гээд байгаа.

Бүгдийг нь баримтлаад ажиллахад бол энэ төсөл бол яг уул уурхай талаасаа ямар нэгэн асуудалгүй ажиллаад байх боломжтой.

Г.Тэмүүлэн: Туваан сайд.

Ц.Туваан: Болормаа гишүүний асуултад хариулъя. Энэ асуудал дээр том ажлын хэсэг ажиллаж байгаа. Учрал сайдаар ахлуулсан. Дээрээс нь тодорхой яг техникийн дэд ажлын хэсгүүд ажиллаж байгаа. Тэгээд энэ дэд ажлын хэсгүүдэд Эрдэнэс Оюу толгой компанийн удирдлагуудаас орж ажиллаж байгаа.

Дээрээс нь би түрүүн хэлсэн энэ Монгол Улсын хоёр дахь гаднын гуравдагч орны, хөршийн хөрөнгө оруулалтын гэрээ. Ийм учраас бид бүхэн бас энэ дээр нэг талдаа ажлын хэсэг гэрээн дээрээ Оюу толгойн гэрээг тавьж сууж байгаад нөгөө талдаа шууд харьцуулж үзээд ингээд л явж байгаа. Бид бүхэн бас шууд утгаараа энэ микрофонд хэлж байгаа учраас алдсан гэх нь юу юм. Тэгэхдээ тэнд тэр гэрээгээ дүгнэж энэнээс илүү яаж сайн байж болох вэ гэдэг тал дээр нь ажлын хэсэг маань ажиллаж байгаа. Гэрээ 60 гаруй хувьтай ингээд явж байгаа.

4 дүгээр асуулт дээр энэ олон нийтийн хэлэлцүүлэг гээд. Энэ дээр мэдээж яаралтай горимоор энэ хууль орж ирж байгаа. Бид бүхэн бас гэрээгээ ингээд олон жил удаад ингээд явж байгаа учраас бас хугацааг нь түргэвчлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 14 мега төсөлд орчихсон асуудлууд энэ тэр гээд ингээд цаг хугацаа биднийг хүлээхгүй байгаа учраас яаралтай явж байгаа.

Гэрээ өөрөө дахиад Улсын Их Хурал дээр орж ирнэ. Улсын Их Хурал дээр энэ гэрээ бол батлагдана. Тэгэхээр тэр үе дээр бид бүхэн таны хэлсэн саналаар бас энэ олон нийтэд мэдээлэл өгөх, хэлэлцүүлэг хийх асуудлуудыг бас зохион байгуулъя гэсэн ийм зүйлийг хэлье.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Эхний энэ асуулт Нигер дээр бас л мөн их хариуцлагагүй л юм хэлж байна. Энийг одоо ингээд л судлаад л үзэх юм бол тэр төсөл нь 15 онд эхлэх ёстой байсан хойшлоод 24 он болсон байна. Энийг Засгийн газар нь бид нар бусад улсын Засгийн газрыг ямар гэж дүгнэхээс илүүтэйгээр энэ хойшилсноос болж Засгийн газар нь лицензийг нь буцаасан гэж байгаа шүү. Тэгэхээр та бүхэн энэ асуудлуудаар бас нэлээн дэлгэрэнгүй судалмаар байгаа юм. Бусад улсуудын ч жишээнүүдийг нь.

Тэгшбаяр докторын саяын хэлсэн бид нар ингээд норм стандартууд бүгд байгаа гээд байгаа юм. Би одоо яг Халзан бүргэдэйн Ховд аймгийн Мянгад сумын энэ асуудал дээр одоо энэ ажлын хэсэгт байгаа Нямдаваа хамт явсан тээ? Бид нар цацрагт идэвх бодисыг нь хэмжээд явсан юм. Бүүр яг иргэдийн шаардлагаар хэмжээд явсан юм. Тэгэхэд байх ёстой хэмжээнээсээ таны хэлээд байгаа наад норм норматив стандартаас өндөр мөртөө ажилчдаа болон иргэдийг хамгаалах үйл ажиллагаа хийгээгүй байсан. Бодит байдал ийм байсан.

Тэгэхээр би ерөөсөө тийм итгэл төрөхгүй байгаа байхгүй юу. Ингээд л сайхан ам таглаад л тэр норм стандарт нь байгаа сайхан асуудлууд нь шийдэгдсэн гээд байгаа мөртөө миний нүдээр харсан аймаг, орон нутагт энийгээ хийж чадахгүй байгаа юмаа яаж та нар хийж чадна гэдэг ийм итгэл үнэмшил төрүүлж байна вэ? Өмнө нь Тэгшбаяр доктор орж ирээд л бараг л надад ажил

заагаад л гараад явсан. Бараг хөдөө байгаа хүмүүс бүдүүлэг, энийг ойлгохгүй байгаа. Энийг дэмж ухааны юм бараг хэлээд л явах нь холгүй байсан.

Тэгэхээр би ийм байдлаар сая Туваан сайдын хэлдэг энэ төсөл хойшлогдсон учир яаралтай горимоор оруулж ирлээ гээд байна. Яагаад хойшлогдсон бэ гэдэг гүн шалтгаан чинь олон нийтийн хэлэлцүүлэг дутмаг байсан учир байхгүй юу. Олон шалтгаанууд байгаа байх. Тэгэхээр энийгээ алгасаад иймэрхүү хандлагатай ийм “Мон Атом”-ынхон иймэрхүү хандлагатай ийм хэмжээний төслийг цаашаа авч явна гэдэг бол үнэхээр итгэл төрөхгүй байна. Энэ байгаа байдал, хандлага, биеийн хэлэмж үнэхээр явахгүй байна шүү. Тэгэхээр энийг ард.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Туваан сайд.

Ц.Туваан: Тэгээд ер нь бас мэдээж болгоомж илүүдэхгүй. Дээрээс нь бид бүхний хувьд байгаль орчин, ард иргэдийн эрүүл мэндийн асуудал бол нэг номер. Тэгэхээр энэ асуудлыг бид нар бас энэ хариуцлагатай уул уурхай гэдэг хүрээндээ онцгой анхаарч явна гэдгийг бас хэлье.

Мэдээж энэ цацрагийн цацраг идэвхжилтийн асуудал бол мэдээж байгаль орчинд бол байдаг. Энгийн тиймээ зөвшөөрөгдөх норм хэмжээнүүд л гэдэг асуудлууд байдаг. Тэгээд бас энэ байгаль дээр түгээмэл байдаг энэ боржин чулуу, хад цохионуудад бүгдэд нь тодорхой хэмжээний цацраг идэвхт ийм бодис бол байдаг. Тэр Халзан бүргэдэйн асуудал дээр бас энэ бүүр уран руу сүүлдээ бас зарим нь, заримдаа ингээд халиад явчхаж байгаа юм шиг харагдаж байна лээ. Тэн дээр уран тори, уран торинь энэ хосолсон цацраг идэвхийн асуудлыг би бас сонирхож сая энэ Австрали янз бүрийн юманд хурал, зөвлөгөөнүүд явж байхдаа санаа зовж бас асуусан юм.

Тэгээд ер нь 10 гаран газрын овор элементийн ордууд дундаасаа хамгийн бага Уран тойргийн агууламжтай 4 ордын нэгэнд ордог юм байна лээ. Тэгэхээр бас бид бүхэн ард иргэддээ мэдээж мэдээлэл ингээд бас таны хэлж байгаа ил байгаад мэдээллээ сайн өгөх нь зөв гэдэгтэй санал нэг байна. Зөв мэдээллийг бас бид нар өгөөд явахгүй бол яг энэ хүрээндээ бүх асуудлууд ингээд гацвал бид нар эргээд нөгөө ард иргэдээ сайхан амьдруулах, орлого талаа яаж олох вэ гэдэг асуудал бас эрүүл мэнд, байгаль орчны асуудлын араас гарч ирэх юм байна лээ. Тэгэхээр тал талаасаа л мэдээллээ сайн өгөөд явах нь зөв байх.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн болсон уу? Одоо 1 дүгээр зүйлээр гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо үндсэндээ зүйл тус бүрээр нь бол бид нар бас гишүүдийн гаргасан, бичгээр гарсан саналуудаар бол санал хураалт явна.

Цөмийн энергийн тухай хууль маань бол 5 зүйлтэй байгаа. Тэгэхээр зүйл болгон дээр та бүхэн маань бас холбогдох асуудлуудаар дахиж нэмж асуултаа асуугаад, тайлбараа аваад явж бол болно гэдгийг хэлэх байна.

Эхнээс нь би та бүхэнд бас энэ дэгээ эхлээд танилцуулаадахъя. Санал хураалт явуулахаас өмнө. Дэгийн тухай хуулийн 39.20 дээр зааснаар бол төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын

томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг бол танилцуулж санал хураалгах гэж байгаа юм.

Тэгээд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцогдоод эдгээр саналаар бол санал хураалт явуулахгүй гэсэн юм байгаа. Тэгээд энэ хуулийн 39.9 дээр заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна гэсэн ийм томъёоллууд бол байгаад байгаа юм.

Ингээд би бүх саналуудыг бол та бүхэнд танилцуулаад, нэг бүрчлэн бол бүгдээрээ санал хураалтаа явуулъя.

Эхнийх нь асуудал. Эхнийх 1 дүгээр зүйлийн 1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг дээр бол санал байхгүй.

2 дахь буюу 2/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт дээр бол 3 санал ирсэн юм уу? 3 санал байгаа. Үүнд Уянгахишиг гишүүний санал бол ажлын хэсгийн саналтай уялдаж, холбогдож гарч ирсэн байгаа.

Энэ саналыг эхлээд танилцуулъя. Дараа нь нөгөө бусад саналуудыг танилцуулаад, Уянгахишиг гишүүний саналаар бол санал хураалт бол явагдана.

Уянгахишиг гишүүний саналыг танилцуулъя.

8.1.4.Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах эсэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар шийдвэрлэх гэж байгаа юм уу? Өөрийн гэдэг нь юу гэсэн үг юм? Их Хурлын бүрэн эрх гэсэн агуулга явж байгаа юм байна тээ? Энийг тодорхой яахгүй. Ийм санал хураагдах юм байна шүү. Бусад би ирсэн саналуудыг танилцуулаадахъя.

Энэ хэнийх вэ? Б.Бат-Эрдэнэ гишүүн бичгээр бас санал ирүүлсэн юм байна. Саналын томъёолол нь 8.1.4.Энэ хуулийн 5.4-д заасны дагуу хувь, хэмжээг тогтоох болон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх гэсэн ийм томъёолол байгаа юм байна.

Бадамсүрэн гишүүн Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжээгүй санал байгаа юм байна.

8.1.4 дэх заалтын шийдвэрлэх гэсний дараа Засгийн газраас цацраг идэвхт ашигт малтмал эрх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шинээр олгох, бусдад шилжүүлэх асуудлаар зөвшөөрөл авахаар өргөн мэдүүлснийг хэлэлцэж хариуг өгөх гэсэн ийм томъёолол байгаа юм байна.

Ийм 3 санал томъёолол ирсэн. Эхний санал буюу тайлбар өгч болно Уянгахишиг гишүүн. Ингээд энийг сая уншаад танилцуулсан. Та бас санал гаргасан гишүүн та тайлбараа бас өгчих. Уянгахишиг гишүүний саналаар санал хураалт явагдана. Уянгахишиг гишүүн саналаа тайлбарлана. Уянгахишиг гишүүний саналыг микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Энэ нөгөө нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл дээр болохоор яг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах гээд

нөгөө олон хувилбарын маань зөвхөн нэг хэсгийг, нэгийг нь л оруулчихсан байгаад байгаа юм.

Тэгэхээр одоо жишээлбэл хувьцааны өөр төрлөөр оруулах, эсвэл нөгөө бүтээгдэхүүн хуваах ч гэдэг юм уу тэд нарыгаа оруулахаар хэн шийдэх вэ гэдэг нь байхгүй болчихоод байгаа учраас нөгөө хувилбаруудыг гэдэг агуулгаар нь оруулж ирж байгаа юм. Тэрнээс бусад нөгөө, энэ эсвэл өөрийн санаачилгаар гэдэг нь анхнаасаа байсан санаа юм. Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсвэл өөрийн санаачилгаар гэдэг нь өөрөө угаасаа анхнаасаа байсан үг, үсэг нь явж байгаа юм шүү. Тэгээд ер нь нөгөө хувилбарууд гэдгээ л санаагаа оруулж нэмж байгаа юм гэсэн үг дарга.

Б.Пүрэвдорж: Тэр нөгөө энэ яг энэ гишүүний гаргаж байгаа санал дээр бас нөгөө Цолмон дарга байна шүү дээ. Одоо яг энэ дээр... байгаа ажлын хэсэг Цолмон дарга бас бид нар дахиад ярилцсан юм. Тэгээд яг энэ хувилбар чинь зөв үү, юу вэ гэдгийг бас тодотгох л.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга Пүрэвдорж гишүүн бас яах вэ, санал горимын санал гарч байна. Яг саяын энэ гаргасан санал дээр Цолмон дарга Засгийн газрын ажлын хэсэг бас тодорхой тайлбар нэмэлт мэдээлэл өгөх үү тээ? 5 Номер. 6 номер.

Д.Цолмон: Засгийн газрын Хэрэг эрхлэх Цолмон.

Өчигдөр ажлын хэсгийн хурал дээр бол Уянгахишиг гишүүний гаргасан саналын томъёоллыг ажлын хэсгээр хэлэлцээд дэмжсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Ингээд санал хураалтыг явуулъя. Та бүхэнд танилцуулсан байгаа.

Саналын томъёолол. 8.1.4.Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах эсэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар шийдвэрлэх гэсэн ийм томъёолол байгаа юм байна.

Ингээд Уянгахишиг гишүүний саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Төхөөрөмжүүдээ шалгаарай, өөр өөрсдийнхөө төхөөрөмж дээр суусан байх тээ? Санал, хураалт.

Уянгахишиг гишүүний санал 77.3 хувиар дэмжигдлээ.

Уянгахишиг гишүүний санал дэмжигдсэн учраас саяын 8.1.4-тэй холбоотой бусад саналууд хураалгах шаардлагагүй болж байна.

Одоо дараачийнх нь 3 дахь буюу 3/9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт дээр гаргасан санал байна. Бас Уянгахишиг гишүүн гаргасан юм байна тээ? Энхнийх нь бол Уянгахишиг гишүүнийх байна.

9.1.9.Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэдэг ийм заалт орж ирж байгаа юм байна. Энэ саналаар санал хураагдана.

2 дахь нь бас Бадамсүрэн гишүүн гаргасан санал байгаа нь Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжигдээгүй санал.

9.1.10 юм уу дугаар нь арай өөр байна тээ? Энэ Бадамсүрэн гишүүнийх бол тог, Уянгахишиг гишүүнийх л ганцхан байгаа. Наадах чинь 9.1.10 байна. Тийм байна.

9.1.9 дээр өөр санал байхгүй учраас Уянгахишиг гишүүний саналаар санал хураалтыг явуулъя. Адилхан, агуулга нь адилхан. Нэмж тайлбарлах шаардлагагүй. Санал хураалт. Дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна.

Уянгахишиг гишүүний санал 77.3 хувиар дэмжигдлээ.

Энэ Эдийн засгийн байнгын хороо, 3 дахь санал манайх гишүүд анхааралтай байгаарай. Хэдүүлээ 10, 15 санал байгаа байх яг хураалгах.

Энэ 4 дэх нь бол одоо бид бүхэнд нөгөө тараагдсан Засгийн газраас өргөн баригдсан санал дээр 4/9 дүгээр зүйлийн 9.1.10 дахь заалт дээр дэмжээгүй санал юм байна. Бадамсүрэн гишүүний саналыг Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй. Үүгээр санал хураана.

9.1.10 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх” гэсэн байна.

Тэгэхээр энэ Бадамсүрэн гишүүний санал дэмжигдээгүй санал байгаа Эдийн засгийн байнгын хороон дээр.

Дэмжээгүй саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явагдана. Ажлын хэсэг.

Яах вэ энэ дээр би Засгийн газар яах вэ, товчхон тайлбар өгчхөөрэй 4 номер.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Намчинсүрэн.

Цацраг идэвхт ашигт малтмалыг бол хуульд заасныхаа дагуу бол бусдад шилжүүлэхийг хориглосон байдаг. Дээрээс нь хайх, ашиглах харилцааг бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 77 дугаар зарлигт заасны дагуу Засгийн газарт танилцуулж байж олонх асуудлыг нь шийдвэрлэж яваа.

Г.Тэмүүлэн: Гишүүд ойлгосон байх тээ? Санал хураалтыг явуулъя дэмжээгүйг дэмжье гэдэг санал томъёоллоор явах нь байна шүү. Дэмжээгүйг дэмжье гэдэг томъёоллоор. Санал хураалт.

81.8 хувиар дэмжигдлээ.

Дараагийнх нь 5 дугаар заалт дээр байгаа. Нөгөө АМНАТ-тай холбоотой асуудал байна. Төсвийн байнгын хороон дээр дэмжсэн санал юм байна шүү.

20^{1.3} дээр Төсвийн байнгын хорооноос оруулж ирсэн дэмжсэн санал нь ийм санал байгаа юм байна. Уншиж танилцуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5/20¹ дүгээр зүйлийн 20^{1.3} дахь хэсэгт “борлуулалтын үнэлгээний 5 хувиар” гэснийг “борлуулалтын үнэлгээний 9 хувиар” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн гэж байна. Санал хураалт дэмжсэнийг дэмжье гэдэг санал хураалтаар явагдана. Тийм, энэ дээр та хэд маань нэг юм ойлгоорой. Би яг ажлын хэсгийн санал бол ажлын хэсгийн санал гээд явна. Яг нөгөө заалт тус бүрээр хэлэлцэж байгаа учраас гишүүдийн гаргасан болон Байнгын хороон дээр дэмжсэн, дэмжээгүй нь хэлээд ингээд явж байгаа шүү. Тэгээд Төсвийн байнгын хороо дэмжсэн саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураагдах нь байна. Энэ томъёоллоор санал хураалт явагдана.

Төсвийн байнгын хороо дэмжсэн саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал дэмжигдсэнгүй. 100 хувиар.

Дараагийнх нь энэ ажлын хэсгийн дэмжсэн саналууд байгаа. Би та бүхэнд танилцуулъя. Өргөн баригдсан хууль дээр 2^{1.4}-тэй холбоотойгоор.

1.1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20¹ дүгээр зүйлийн 20^{1.4} дэх хэсгийн, одоо нөгөө хүснэгт дээр гэсэн үг шүү, “хувь” гэсний өмнө “үндсэн” гэж нэмж, мөн зүйлийн 20^{1.6}, 20^{1.7} дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20^{1.6} нь энэ хуулийн 20^{1.5}-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн ийм томъёолол байна.

Ингээд энэ ажлын хэсгийн саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулах нь байна. Ажлын хэсгийн дарга тайлбар хийх шаардлагагүй тээ? Ойлгомжтой.

Ажлын хэсгийн саналыг, дэмжсэн саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт дэмжье.

Ажлын хэсгийн санал 72.7 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн 2 дахь санал ажлын хэсгээс нийтдээ 8 санал байгаа юм байна.

2 дахь санал нь, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20^{1.9} дэх хэсгийн “олборлосон” гэсний дараа “цацраг идэвхт” гэж нэмэх.

20^{1.9}-ийн ойлголоо. Ашигт малтмалын төрөл, тоо хэмжээ гэдгийнхээ урд нь бол цацраг идэвхт гээд ерөнхийдөө редакцын маягтай засвар юм байна.

Ажлын хэсгийн саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

81.8 хувь хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн 3 дахь санал.

Энэ 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 28.2.12 дахь заалтын дугаарыг “28.2.11” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэсний дараа “28.2.11” дэх заалтын дугаарыг “28.2.12” гэж, мөн зүйлийн гэж нэмэх.

Энэ илүү хууль зүйн техникийнх юм байна. Дугаар өөрчилж байгаа холбоотой. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

81.8 хувиар дэмжигдлээ.

4 дэх ажлын хэсгийн санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.3 дахь хэсгийн “олборлолт” гэсний дараа “баяжуулалт” гэж, “аюулгүй” гэсний дараа “булшлах” гэж тус тус нэмж, мөн хэсгийн “гүйцэтгэх” гэснийг “гүйцэтгэж” гэж өөрчлөх. Найруулгын маягтай бас санал байна. Аюулгүй гэдгийнх нь ард нь бол булшлах гэж оруулж, эхнээсээ боловсруулалт дээрээ бас техникийн алдаа гаргасан байсан Засгийн газар. Ингээд энийг нь засаж, залруулж байна. Санал хураалт явуулъя гишүүд анхааралтай байгаарай. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Санал хураалт.

86.4 хувиар дэмжигдлээ.

5. Улсын байцаагчтай холбоотой асуудал байгаа. Арга хэмжээн төлөвлөгөөтэй.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.4.1 дэх заалтын “батлан мөрдөх” гэснийг “баталгаажуулан мөрдөх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг олон улсын хөндлөнгийн шинжээчээр хянуулах” гэж өөрчилж, 34.4.2 дахь заалтын “нэн” гэснийг, 34.8 дахь хэсгийн “15.2.1” гэснийг тус тус хасах.

34.8 гэдэг нь бүүр хойд талын заалт юм байна шүү дээ. Хамаагүй тийм окэй.

Ажлын хэсгийн саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

86.4 хувиар дэмжигдлээ.

34.5-тай холбоотой саналууд байгаа. 3 санал ирсэн.

34.5 3 санал ирсэн. Анар гишүүний саналаар саналын томъёолол хураагдана.

34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэлд байршуулна гэсэн ийм томъёолол бол байгаа.

2 дахь санал нь Пүрэвдорж гишүүний санал. 34.5 дээр төрийн дансанд” гэснийг Монголбанкн дахь Ирээдүйн өв сангийн валютын тусгай дансанд байршуулна гэсэн санал 2 дахь санал нь Пүрэвдорж гишүүнийх байна.

3 дахь санал нь Б.Бат-Эрдэнэ гишүүнээс гаргасан санал байна. 5.4 дээр 3 дахь нь байна уу? 5.4 биш, 34.5 энэ хэнийх байна Энхтүвшин гишүүнийх гаргасан юм уу?

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй

34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийн баталгааг энэ хуулийн 34.6-д заасан шаардлагад нийцсэн олон улсын банкны баталгаагаар гаргана гэсэн ийм санал байгаа юм байна.

Гурвуулаа тайлбар өгөх юм байна. Анар гишүүн эхлээд тайлбарлана, дараа нь Пүрэвдорж гишүүн, тэгээд Энхтүвшин гишүүн.

Анар гишүүний микрофоныг өгье.

Ч.Анар: Энэ 34.5 дээр нөгөө чуулган дээр ч ярьж байсан энэ ийм энэ заалт маань өөрөө 2 талтай болчихоод байгаа юм.

Нэгдүгээрт, төрийн санд байршихаараа энэ дээр улс өгөөж авахгүй, дээрээс нь тодорхой хэмжээгээр 30 жил байна уу, 30 жилийн 4 жилийн дараа байна уу хөрөнгийн үнэ цэн, мөнгөний үнэ цэн байхгүй болох эрсдэлтэй. Одоо бас ийм зохицуулалтаар мөнгөнүүд төрийн санд байршдаг. Тухайн үедээ нөгөө энэ хаалтын дараах нөхөн сэргээлтэд энэ зардал маань хүрэхгүй болох хамгийн том эрсдэлтэй байгаа. Дээрээс нь сангийн өгөөж байхгүй.

Хоёрдугаарт, нөгөө талаасаа энэ заалт орж ирэх юм бол Засгийн газар өөрөө ганц Орано байна уу дараагийн компаниудтайгаа хэлэлцээр хийж чадахгүй байх эрсдэлд хүрэх эрсдэлтэй байгаа юм. Тэгэхээр энийг олон улсын жишиг болгоод анх удаагаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагад баталгаа гаргах тэр зарчмаар мөнгөн үнэ цэнийг нь Монгол Улс өөрөө өгөөжийг нь хүртээд, дээрээс нь баталгаатай байдлаар байршуулах шаардлага нь аль аль талаасаа үүсээд байгаа юм. Тэр заалтаар оруулж ирсэн байгаа. Тэгээд энэ дээр бас түрүүн Дамдинням гишүүн хэлж байна. Энэ Энхтүвшин гишүүнээр бас орж ирсэн байна. Ажлын хэсэг дээр би хүндэтгэх шалтгааны улмаас саналаа тайлбарлаж чадаагүй. Тэгэхээр энэ саналыг дэмжиж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Анар гишүүнд баярлалаа.

Пүрэвдорж гишүүн. Ирээдүйн өв санд Монголбанканд байршуулах.

Б.Пүрэвдорж: Төрийн санд байрших юм бол шууд төсөв рүү татаад аваад хэрэглэчихнэ. Тийм учраас энэ дээр эрсдэл үүсэх юм байгаа юм. Тэгээд өчигдөр би ажлын хэсэг дээр санал гаргаад бас Төрийн сангийн Монголбанканд дахь валютын дансанд хадгалах гэдэг дээр бас дахиад шууд Засгийн газар Төрийн сан руугаа хэрэглэх боломж нь бас нээлттэй юм байна лээ.

Тийм учраас энэ Ирээдүйн өв сангийн Монголбанканд дахь тусгай данс гэж бас байдаг. Тэгээд эндээ бас хадгалах юм бол жил болгон 13 сая доллар орж ирнэ. Энэ 13 сая доллар орж ирээд тэр Монголбанкны тусгай дансанд хадгалах юм бол жилд 4.5 хувиар хүү тооцогдоод энэ бас үржигдээд явах нь. Өөрөөр

хэлбэл, 600-гаад мянган доллар бас нэмэгдэх юм байна лээ. Тэгэхээр Анар гишүүний гаргаж байгаа тэр баталгаа гаргах дээр баталгаа талдаа гаргаж байгаа талдаа бол яавал хямд эх үүсвэрээр баталгаа гаргах вэ гэдэг асуудал байгаа болохоос манай Монгол Улсад тэр 13 сая доллар жил болгон орж ирлээ гэхэд тодорхой сангийн менежментийг хийгээд үр ашиг авах тийм боломж нь байхгүй.

Тийм учраас тэгэхээр та баталгаа гаргалаа гэхэд баталгаа, манай баталгааны бичиг л өгнө үү гэхээс бусдаар тэр дансанд байршсаны үндсэн дээр тэдэн долларын шимтгэл орж ирлээ гэдэг ийм юм байхгүй шүү дээ. Гэтэл энэ Монголбанк дээр байрших юм бол 4.5, жишээ нь өнөөдрийн байдлаар 4.5 хувиар валютад хүү төлж байгаа.

Тийм учраас энэ дээр манай Ирээдүйн өв сангийн, сангийн валютын тусгай дансаар тэрийг хөдөлгөлөө гэхэд заавал Их Хурлаар орж байж хөдлөх байхгүй юу даа. Менежментийг нь бол мэдээж Засгийн газар Орано, Монголбанк гурвуулаа харилцан гэрээнийхээ үндсэн дээр менежментийг нь удирдаад явна. Ирээдүйн өв сангийн тэндээс хөдөлгөлөө гэх тохиолдолд заавал Их Хурлаар орно. Их Хурлаар орж байж шийдэгддэг ийм юу зүйл байхгүй юу. Тийм учраас яг энэ уурхайн хаалтын энэ мөнгийг баталгаатай Монголбанк дээр хадгалах ийм боломж нь нээлттэй байгаа юм.

Ийм учраас, энэ дээрээс нь бид нар чинь бас энэ валютын нөөц энэ тэрээ бас тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх ийм шаардлага бас барьж байна. Энэ чинь эдийн засгийн хувьд маш их тийм үр ашигтай байхгүй юу Монголд байршуулах юм бол. Энэ дээр бас та бүхэн миний саналыг дэмжиж саналаа өгөөрэй гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ санал бас ерөнхийдөө ер нь яах вэ, бид нар бас зөвхөн нэг талаа биш, хоёр талаа бодох ёстой. Энэ хэдийгээр жишээлбэл зардал биш ээ, мэдэгдэхгүй юм шиг боловч бид нар нэг талд өгөөжөө авч чадахгүй бол нөгөө талдаа бас, нөгөө талыгаа бас илүү ийм зардал заавал жишээлбэл мөнгөн хөрөнгө хадгал гэж шаардлага тавихгүйгээр илүү зардал бага гарах банкны баталгаа байвал яасан юм бэ гэдэг ийм санал байгаа.

Нөгөө талаасаа бас хэрвээ энэ засаг, төрийн дансанд байвал яг энэ хаалт хийх үед нь энэ мөнгө нь байхгүйгээсээ болоод энэ төсөл маань өөрөө буцаад нэр хүндийн хувьд ч юм уу, жишээлбэл яг тухайн үед нь шаардлагатай санхүүжилтээ хийж чадахгүйгээсээ болоод нэр хүндэд нь асуудал гарна.

Тэгээд цаашдаа энэ бусад төслүүдэд бас ийм эрсдэл болох үүднээс энэ улсын, төрийн энэ дансанд ч юм уу ийм байдлаар байршуулах нь бас эрсдэлтэй, янз бүрийн өөр юманд хүрэх магадлалтай учраас энийг дундын шийдэл буюу олон улсын шаардлага хангасан банкны баталгаагаар байвал яасан юм бэ гэдэг ийм санал гаргасан юм.

Г.Тэмүүлэн: Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт явагдана. Анар гишүүний эхний саналын томъёоллоор явагдана. Анар гишүүний сана саналын томъёолол дэмжигдвэл нөгөө 2 санал хураалтаар санал хураахгүй. Дээрээс нь 34.6 болон 7 дээр Анар гишүүн бас 2 санал бол бичсэн байгаа. Энэ дээр 6, 7 дээр аудит хийлгэж, дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулна. Тухайн

тэр санхүүгийн байгууллагад байршуулах журмыг Засгийн газар батална ч гэдэг юм уу ийм ерөнхий зарчмын асуудлыг хийж өгсөн байна.

3 санал бол 3-уулаа төрийн дансанд байршуулахыг бол нэг талдаа эсэргүүцэж байгаа. Олон улсын хяналттай болон эсвэл Монголбанкны гэсэн ийм санал байгаа.

Эхний санал Анар гишүүний саналаар санал хураалтыг явуулъя. Анар гишүүний саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Анар гишүүний санал, Анар гишүүний санал дэмжигдсэнгүй. Гэхдээ дэмжигдээгүй санал бол чуулган дээр бас санал хураагдана. Саналаа тайлбарлах бас эрх бол байгаа.

2 дахь санал. Пүрэвдорж гишүүний санал та бүхэн бас бүгдээрээ мэдэж байгаа тайлбарыг нь сонссон. Пүрэвдорж гишүүний саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулах нь байна. Санал хураалт.

Ж.Энхбаяр гишүүн дэмжсэн юм уу?

22-оос 13 хувиар, 13 хүн дэмжиж дэмжигдлээ Пүрэвдорж гишүүнийх.

Ингэхээр Энхтүвшин гишүүний санал бол хураагдахгүй нь байна. Ингээд дараагийн санал хураалт руугаа оръё. Анар гишүүний санал дэмжигдээгүй учраас 34.6, 7 бол хураагдахгүй нь байна шүү тээ? Тийм.

1 дүгээр, манайхан анхаараарай. Одоохон наашаа хараарай 1 дүгээр зүйл дээр энэ Түвшин гишүүн гаргасан санал юм байна. Тэгэхдээ энийг хураалгах шаардлагагүй гэдгийг би бас хэлье. Энэ гол би уншаад танилцуулчихъя.

Саналын томъёолол нь Ашигт малтмалын тухай хуульд хэрэгжсэн юм байна. Тэгээд энэ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 47.2.4 дэх хэсэг, 47.5 дахь доорх хэсгийг нэмсүгэй.

47.2.4 нь цацраг идэвхт ашигт малтмалыг экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан тооцно гээд 47.5 хүснэгтийг хийгээд Түвшин гишүүн гаргасан байгаад байгаа юм.

Тэгэхээр Ашигт малтмалын тухай хууль хөндөгдөж орж ирээгүй учраас энэ саналыг бол хураалгах шаардлагагүй. Протоколд тусгаж байна.

Одоо 1 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

2 дугаар зүйл рүүгээ орно.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье. Асуулт асуух гишүүд 2 дугаар зүйлтэй холбогдуулж.

Алга байна. Байна уу хэн байна ? 2 байгаа юм байна шүү дээ. Тийм байна. Энэ дэлгэц дээр гарахгүй байгаад байсан. Сайнзориг гишүүнээр тасаллаа.

Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Миний 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуух гэж байгаа асуулт маш тодорхой. Юу гэвэл 5.2, 5.3-ыг хэвээр нь байлгана гэсэн боловч цаана нь 5.5-аар шал өөр болоод орж ирсэн. Миний өөрийн санал дээрээс хойш л яриад байгаа ганцхан санал бол энэ 2009 онд бий болсон, баталсан энэ Цөмийн энергийн тухай хууль үнэхээр эх оронч хууль, сайн хууль. Энийг бид муутгах гээд яриад сууж байгаа, эрх зүйн орчныг нь муутгах гээд. Орана нь энэ 10-аад жил ажилласан энийг хүлээн зөвшөөрчихсэн байгаа. Тэгээд орж ирсэн. Энэ дээр заасан зүйл юу вэ гэвэл үндсэндээ 51 хувь буюу 34 хувь төрийн өмчийн оролцоотой хайгуул хийсэн бол, оролцоогүй хайгуул хийсэн бол гээд 51, 34 хувийг Монголын төр үнэ төлбөргүй шууд эзэмшинэ гэсэн байгаа шүү дээ. Ямар ч хувьцаа, ямар ч санхүүгийн дарамт юу ч байхгүй. Энэ Оюу толгойн шал өөр асуудал.

Хоёрдугаарт, түрүүн ярьж байсан бүтээгдэхүүн захиран зарцуулах эрхээ бид үндсэндээ Француудад зүгээр өгч байгаа гэсэн үг. Хэзээ нэгэн цагт бид бага оврын реактортой болоод цахилгаан эрчим хүч уранаараа үйлдвэрлэх тийм боломж бүрдсэн тохиолдолд, байнга энийг ярьдаг шүү дээ ногоон эрчим хүч бий болгоно, хямд эрчим хүч бий болгоно гээд.

Тэгвэл бид буцаад Француудаас энэ шар нутгаа гуйж зах зээлийнх нь үнээр авахаар ч тийм байдалд орчхоод байна. Энэ дээр энэ санхүүгийн хувьд тийм ашигтай төсөл биш ээ. Оюу толгой бол хэдэн 100 тэрбум доллар. Энэ бол үсрээд л 12 тэрбум долларын тухай ярьж байгаа. Тэгээд энэ дээр та нар 34 хувиасаа битгий татгалзаач. Энэ чинь нөгөө цаана нь орж ирээд байгаа өсөн нэмэгдэх гээд 9 хувиас чинь хамаагүй илүү 2 дахин, 3 дахин илүү ашигтай байгаа зүйлээс яагаад татгалзаад байгаа юм бэ? Энгийн арифметик тооцоогоор 34 хувь гэдэг бол энэ өөрөө 25-30 хувийн ашигтай ажилладаг. Зардал нь 25-30 хувь. 70 хувийн ашигтай ажилладаг бизнес. Энэний 34 хувь гэдэг бол 23.8 доллар гэсэн үг. 100 доллар тутамдаа.

Тэгэхээр ахан дүүс ээ би үнэхээр ядарч байна энэ 34 хувийг яагаад татгалзаж, тэртээ тэргүй үнэ төлбөргүй Монголын ард түмэнд авчихсан байгаа юмыг орлуулна, өөртөө гай тариад хэзээ ч үнэ нь тодорхойгүй болох 0-9 хувь өсөх юман дээр битгий тавиач гэдгийг л бүүр зарчмын хувьд гуйгаад байгаа.

Хоёрдугаарт, би түрүүн хэлсэн. Түрүүн үг хэлэх боломж олдоогүй хог хаягдал дээр, аюултай хог хаягдлын үйлдвэр барина шүү протоколд тэмдэглүүлье. 50 сая долларын хүхрийн хүчлийг гаднаас авахаар энэ орж ирж байгаа энэ зүйл дээрээ хүхрийн үйлдвэрээ барина шүү. Ийм эх оронч биш байдалтай асуудалд хандаж болохгүй. Ингээд 5.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Санал гэж ойлгох уу, тайлбар авах уу? Асууж байгаа. Ажлын хэсгийн дарга хариулах уу Пүрэвдорж гишүүн? Хэн хариулах вэ? Учрал сайд хариулах юм уу? Хэн хариулах вэ? Учрал сайд.

Н.Учрал: Яах вэ, Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсаны дараа энэ цөмийн энергийн хуулийг оруулъя л гэж өнгөрсөн Засгийн газрын үед шийдээд энэ хойшлогдсон юм байна лээ л дээ. Тэгээд Баялгийн сангийн хууль батлагдсан. Яг

таны яриад байгаа энэ заалт 34, 50 хүртэлх хувийг нь үнэ төлбөргүйгээр эзэмшинэ гэж.

Гол нь Үндсэн хуулийн 6.2 хангагдах ёстой. Газрын хэвлийн баялгийн дийлэнх нь ард түмний мэдэлд байх ёстой зарчим хангагдах ёстой. Яах вэ, өнөөдөр тэр 34 хүртэлх хувиа үнэ төлбөргүйгээр аваад гэрээ хэлцэл хийх шиг амархан юм алга.

Гэхдээ яг өмнөх хөрөнгө оруулалтын гэрээг давтана. Наадах чинь ард түмэнд ноогдол ашиг нь хүртэхгүй. Анх Оюу толгой чинь хэдэн онд хүртэнэ гэж ярьж байсан юм? Өнөөдөр сая тэр 2.3 тэрбум доллар тэглэгдсэнээс хойш л өнөөдөр 27 онд ноогдол ашиг өгнө гэдэг яриа үүсэж байна шүү дээ. Тэрнээс биш ноогдол ашиг өгөх хугацаа нь дандаа л хойшлоод байгаа юм. Тэгээд ард түмэн ашиг хүртэж байгаа юм байхгүй. Тэгээд зөвхөн 5 хувийн АМНАТ-аас л 800 сая долларын ашиг хүртэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг өнөөдрийнхөөр 34 гээд явбал энэ Оранагийн хөрөнгө оруулалтын гэрээн дээр Монголын тэр 125 сая доллар анхны хөрөнгө оруулалтад үүрэг хүлээнэ. Цаашлаад 34 хувийг нь үнэ төлбөргүйгээр авсныхаа хариуд санхүүгийн хариуцлага хүлээнэ. Нэмэлт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай бол 34 хувь дээрээ бид нар үүргээ хүлээх учраас тэр дээрээ тийм импакт өгнө. Эцэстээ тэр Үндсэн хуулийн 6.2 Монголын ард түмэн тэр ноогдол ашгаа авах л ёстой шүү дээ. Тэр авах боломжтойг нь өнөөдрийн Ашигт малтмалын хуулиар төрийн эзэмшлийн хувийг АМНАТ-аар буюу Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно гэдэг заалт Цөмийн энергийн хууль дээр байхгүй байсан учраас Цөмийн энергийн хууль дээр нь хийхээр тэр төрийн эзэмшлийн хувийг нь АМНАТ-аар орлуулаад эцэстээ энэ төсөл дээр Монгол Улс 1 ч төгрөг хөрөнгө оруулалт өөрөөсөө гаргахгүйгээр ирээдүйд ямар нэгэн өр үүсгэхгүй хариуцлага хүлээхгүйгээр 1.6, энэ чинь юу билээ? Тэрбум доллар тээ? Тэрбум долларын төслийг хэрэгжүүлнэ л гэсэн үг байхгүй юу. Энэ дээр ямар нэгэн байдлаар бид хариуцлага хүлээх зүйл байхгүй.

Тийм учраас хуримтлалын санд тэр 10 хувийн ноогдол ашиг, тэр АМНАТ-аар авсны чинь тодорхой тэр 65 хувь нь хуваагдаад Ирээдүйн өв санд хуримтлалын санд, үлдсэн нь тэр Орон нутгийн санд, үлдсэн нь Тогтворжуулалтын санд гээд хуваарилагдаад орно гэдгийг нь маш ойлгомжтой болгож л оруулсан.

Дээрээс нь ураны үнэ дэлхийн зах зээл дээр өсөж байхад, өсөх тутам бид нар ноогдол ашгийг илүү хүртдэг зарчим руу явъя гэдэг утгаараа бол бусад орнуудтай харьцуулахад өнөөдрийн яг үнээр бол тэр 14 хувь, цаашлаад бол угаасаа үнэ нь өсөх учраас энэ 19 хүртэлх хувь гэхээр ийм өндөр АМНАТ тооцсон.

Тэгэхээр Ганбаатар гишүүний санаа зовж байгаа зүйл бол үнэхээр ард түмэн ноогдол ашгаа л хүртэх ёстой шүү дээ. Өнөөдрийн 34-өөр тохироод явъя гэвэл нөгөө тал тодорхой хамтраад явахдаа нээлттэй л гэж байгаа. Тэгвэл хууль өөрчлөх ч хэрэггүй. Тэгэхдээ ноогдол ашгийг хэзээ хүртэх вэ гэдгийг хэн ч тооцоолж чадахгүй шүү дээ яаж хойшлохыг. Тэгээд өнөөдөр ерөөсөө л зардлаа нэмдэг, менежментийн зардал гаргадаг. Тэгээд зардлаа нэмсээр байгаад л ноогдол ашиг гэдэг юм хуваарилагддаггүй, хуримтлагддаггүй, иргэдэд очдоггүй. Тэгээд л ингээд яваад л байна. Эцэстээ л Үндсэн хуулийн 6.2-роо хангуулах гэж л бид нар энийг хийсэн. Тэр үнэ төлбөргүйгээр авна гэдгээ 34-өө орлуулах нь Ашигт малтмалын хуулиар байсан бол Цөмийн энергийн хуулиараа л энийгээ зохицуулж

өгье л гэж байгаа юм. Тэр үнэ төлбөрөөр авна гэдэг нь 34-өө эзэмшинэ үү, АМНАТ-аараа орлуулна уу, тэдний ашигтай, орлоготой байхаас үл хамаараад борлуулалтынх нь орлогоосоо АМНАТ-ийг нь шууд аваад эхлэх юм бол тэдний дотоодын үйл ажиллагаа зардал, чирэгдэлд нь үл хамаараад ард түмэн ашгаа хүртэнэ л гэсэн үг л дээ.

Г.Тэмүүлэн: Энэ заалтууд дээр бас ажлын хэсгийн санал байгаа. Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Та нар тэгээд өөрсдийнхөөрөө олонхоороо шийдэх байх. Тэгэхдээ би ямар ч байсан түүхэнд бас энэ протоколд үлдээнэ. Та нар. Энэ дээр Монголын Засгийн газар, төр үнэ төлбөргүй шууд эзэмшинэ гэдэг үг байхад юуных нь 125 сая долларын үүрэг гараад явчлав? Хадны мангаа шиг яагаад аймаар аймаар юм яриад байна. Оюу толгойтой битгий хольж ярь. Оюу толгойг би мэднэ, муухан гадарлана. Оюу толгой дээр өр авсан. 34 хувь тухайн үедээ би эсрэг байсан. Тэр бол үнэн. Тэр бол Ашигт малтмалын тухай хууль дээр байгаа роялти, энэ Цөмийн энергийн тухай хууль дээр байгаа роялти 2 өөр зүйлээ, битгий хольж ярь гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, энэ дээр санхүүгийн эрх ашиг дивидент гэхээсээ илүү энэ цөмийн цацрагт идэвхтэй энэ бодисын талаар, ашигт малтмалын талаар хяналт их чухал. Монголын тал өнөөдөр энэ их ашигтай айхтар Оюу толгойн ашгаа хэдэн 100 мянга дахин бага. Энэний хажууд зүгээр хяналтаа тавих ёстой, байгаль орчны аюул 15 вагон хүхрийн хүчил газар ээжийн хэвлий рүү цутгана шүү дээ. Тэрийг би өнөөдөр ярихгүй байгаа юм. Хууль дээр орж ирээгүй учраас. Орж ирсэн зүйл нь өнөөдөр зүгээр байгаа юмыг нь байгаагаар нь байлгаач. Яагаад энэ дээр ингээд заавал Орана-д бүр илүү ашигтай хувилбар гаргаад байгаа юм бэ? Цаадуул чинь Нигериэс хөөгдчихсэн, Казакстанд байдаг 4 ордон нь одоо дуусаж байна, Канадад байдаг 2 орд нь дуусаж байна, одоо ямар ч хэлэлцээрт ямар ч болзол тавьсан хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа. Та нар энэ дээр зурлаа бандан тас. Дараа нь цусаар уйлаад ч нэмэргүй. Тэгээд өнөөдөр 34 хувь яаж ч бодсон бидэнд ашигтай. Тэгээд ийм энгийн арифметикийн юмыг ойлгохгүйг бодож байгаа бол надад хэлэх үг алга. Тэгэхдээ би Монголын ард түмэнд заавал танилцуулж, хэлж, анхааралд нь оруулах ёстой, үүрэгтэй. Асуулт алга.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга тайлбар өгөх үү? Сая 5.2, 5.3 Ганбаатар гишүүний анхаарал, санаа зовниж байгаа асуудал Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би Тэгэхээр бас энэ, ер нь энэ 19 хувийн АМНАТ аваад дээрээс нь 6 тэрбумаас дээш 25 хувийн орлогын татвар, дээрээс нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа гээд ингээд дийлэнх нь өөрөөр хэлбэл 54 хувь болчхож байна шүү дээ тийм ээ? Тэгэхээр 54 хувь буюу зөвхөн энэ гуравхан л үзүүлэлтээр 54 хувиа даваад явчхаж байгаа юм. Дээрээс нь маш их олон татварууд төлдөг. Тэгээд л НДШ энэ манай Монгол чинь асар их татвартай, татварын дарамтад байдаг гэж аж ахуйн нэгж аж ахуйн нэгжүүд ярьж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр чинь дахиад 19 хувийн АМНАТ ороод ирж байгаа. Тэгэхээр энэ бол би нэг талаараа, нэг талаараа Орана хэтэрхий их өндөр ингэж АМНАТ тавиад, тавиулж байна гэдэг чинь ер нь Монголын бүх ураны орд дээр өөрсдөө ажиллая л гэсэн ийм, өөр хүнийг оруулахгүй.

Яагаад гэвэл энэ энэ АМНАТ-ыг цөмийн энергийн хуульд орууллаа гэхэд өөр хөрөнгө оруулагч нар бараг орчихгүй байхгүй юу даа. Тэгэхээр ерөөсөө цаашдаа Орана Монголын 6, 7 орд байдаг юм. Тэр дээрээ ерөнхийдөө бас тийм яг энэ өндөр татвар төлснөөр АМНАТ болон бусад татвар төлснөөр бусад хөрөнгө оруулагчийг оруулахгүй байж байгаад ер нь бүгдэн дээр нь л сууна гэсэн алсын бодлоготой л байгаа байх гэж бодож байгаа. Бусдаар ийм өндөр, үнэхээр бусад хөрөнгө оруулагч нар орж ирэхгүй энэ хуулиар бол. Яг энэ өнөөдрийн Засгийн газрын оруулж ирсэн энэ өндөр татвараар оруулж ирэхгүй. Тэгэхээр энэ Оюу толгойн хэзээ авах нь мэдэгдэхгүй 34 хувийг хүлээж өнөөдрийг хүртэл явж байгаа энэ гэрээнээс хамаагүй илүү энэ Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Орана-гийн гэрээ орж ирнэ гэдэгт би эргэлзэхгүй байгаа.

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би яах вэ ажлын хэсгийн саналтайгаар холбоотойгоор асуух гэж байсан юм. Тэгэхдээ сая нэг зүйлийг яг Пүүжээ гишүүний юман дээр би хувийн байр сууриа хэлж байгаа шүү.

Ер нь яах вэ 34 хувийг аваад яг Пүүжээ гишүүн эрсдэлийг нь хэллээ. Энийг дагаад нэмэлт санхүүгийн эрсдэл ч бас үүсэхээс гадна бид энэ хэлэлцээрийг яг өнөөдрийн ярьж байгаа шиг хийж чадвал давуу эрхийн 10 хувийн хувьцаа авч байгаа. Энийг дагалдаад нэлээн олон эрхүүдийг бид нар авч байгаа байхгүй юу. Ерөнхийдөө Компанийн тухай хууль дээр байдаг алтан хувьцаа гээд төрийн өмчийн хувьцаа юм уу, тодорхой энэ компанийн хувьцааг авсан этгээдүүдэд тодорхой үйлдэл дээр нь хориг тавих ч гэдэг юм уу, эсвэл хязгаарлалт тавьдаг гэх зэрэг энэ бето эрхтэй ийм эрхүүдийг энэ давуу эрхийн 10 хувьцааны дагуу бас авч байгаа гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм. Үүгээрээ бид нар бас хяналтыг тавих боломж бол байгаа юм. Яах вэ, энийг Засгийн газар хэрхэн яаж үргэлжлүүлж орж ирэх нь ажлын хэсгийн үүрэг байгаа. Тийм учраас энэ дээрээ анхаарна биз гэдэг зүйлийг би энэ асуултынхаа өмнө хэлчихмээр байгаа юм.

Хоёрдугаарт, яах вэ нэг зүйл байгаа. Ер нь яах вэ энэ стратегийн ордын ашиглаж байгаа компанийн хувьцааг Монголын биржээр 10 хүртэл хувийг уг нь арилжаалах үүрэг байдаг юм. Одоо аль ч компани, эзэмшиж байгаа компаниуд энийг хийгээгүй байгаа. Ер нь уул уурхай бас орон нутагт хүлээн зөвшөөрүүлье гэвэл тодорхой энэ хувьцаануудыг орон нутгийн иргэдэд эхлээд тэргүүн ээлжид санал болгодог, дараа нь аймгийн иргэдэд нь, тэгээд нийт монголчууд ч гэдэг юм уу ийм дэс дарааллаар тодорхой цаг хугацааны үежилттэйгээр бас санал болгож бас энэ дээр хөрөнгө оруулалт хийх энэ боломжийг нь бас олгож яг баялгийг бас шууд байдлаар хүртэх энэ боломжийг олгомоор байгаа юм. Түүнээс биш баялгийг хүртээнэ гэхээрээ л зөвхөн бид нар Үндэсний баялгийн сангаар явна. Татварын байдлаар ч гэдэг юм уу, орж ирсэн орлогыг дахин хуваарилалтууд явна гэдэг байдлаар бас тайлбарлаад байхаар хэцүү байгаа юм.

Тэгэхээр ер нь уур. уурхай, харилцаа холбоо гээд КОВИД-ын үед ч дампуурдаггүй нэг салбар байна шүү дээ. Энэнээс жишээ нь хүртэх энэ ард иргэдэд энэ хувьцаа хөрөнгийн зах зээл дээр ажиллах боломжийг ер нь цаашдаа бас эрэлхийлж ажиллах ёстой юм.

Би ингээд ажлын хэсгийн энэ 6 дугаар санал энэ 2.5, 2 дугаар зүйлийг яагаад энэ хэсгийн өгүүлбэрийг хасаж байгаа юм бэ? Янз бүрийн байдлаар хассанаар давхцал болоод хасчав уу, эсвэл юу гэдэг юм ямар байдлаар хасаж

байгаа юм тэр үндэслэлээ тайлбарлачхаач л гэдэг зүйлийг зүгээр энгийн байдлаар асуух гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Давуу эрхийн хувьцаа, энгийн хувьцаа хоёрын ялгааг би бас танд хэлж өгье. Тэгэхээр одоо энэ хүснэгтийн дагуу хэрвээ ураны хүдрийн баяжмал 70-80 доллар байгаад 3 хувийн АМНАТ авлаа гэж тооцъё. Дээрээс нь дахиад АМНАТ 5 хувь, үндсэн АМНАТ 5 хувь, дээрээс нь тусгай АМНАТ 5 хувь ингээд 13 хувь боллоо. Дээрээс нь орлогын татвар 25 хувь гэхээр 38 боллоо. Дээрээс нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа 10-ыгаа нэмэх, орлогоо нэмэх дээр 48 боллоо тийм үү? Тэгэнгүүт энэ тохиолдолд жишээ нь энгийн хувьцаатай байх юм бол бүх зардал бүх тэр зардлаа хасаад, бүх орлогоо тооцсоны дараа тэрийг хүлээгээд л энгийн хувьцаа эзэмшигч сууж байна.

Гэтэл давуу эрхийн хувьцаа эзэмшигч ямар зүйлийг шаардах вэ гэх дээр хөөе энэ Үндсэн хуулийн 6.2-ын дагуу манайх 48 хувиа аваад байна. Тийм учраас та нар энэ 51 хувь болгохын тулд ийм ийм нэмэлт асуудлыг шийдвэрлэх ёстой, энэ зардлаасаа хасах ёстой гэдэг юм уу ийм давуу эрх гарч ирэх байхгүй юу даа.

Тийм учраас энэ давуу эрхийг Монгол Улс авч байгаа нь хамгийн чухал байгаа юм. Хамгийн гол нь бид нар буцаагаад яг тэр 50-аас дээш нэмэх 1 хувь дээрээ л бид нар энэ Монгол Улсад зайлшгүй энэ гэрээн дээрээ байх шаардлагын үүднээс л энэ давуу эрхийн хувьцааг авч байгаа шүү гэдгийг хэлье. Үлдсэн асуудал дээр нь тэр дээр Уянгахишиг гишүүн тайлбарлачих.

Г.Тэмүүлэн: Уянгахишиг гишүүн энэ дээр нэмэлт тайлбар өгөөд, Ганбаатар гишүүний саналтай нийцэж байгаа эсэх. Уянгахишиг гишүүн ажлын хэсэг дээр гарсан санал.

Г.Уянгахишиг: Түрүүн, тийм түрүүний 8, 9, 2 дээр гарч байсантай адилхан буцаагаад нөгөө зөвхөн АМНАТ-аар орлуулна гэдгийг оруулчихаар бусад хувилбаруудаа оруулахгүй болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас тэр нөгөө явцууруулсан хэсгийг хасаад шууд 5.5-руугаа сонголтуудыг нь оруулчихъя гэдэг саналаар тэр 2 дугаар өгүүлбэрийг хасчихаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн асуулт асууя. Ж.Энхбаяр биш Б.Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Баярлалаа. Би энэ ажлын хэсэгт өгсөн 6 хуудас саналын 2 дахь саналтай холбоотой зүйл, заалт хөндөгдөж байгаа учраас тодруулж асуух шаардлага үүслээ.

Засгийн газрын өргөн барьсан төсөлд бол 5.3 дугаар зүйлийн 5.4-д Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбар гэдэг нэр томъёо орж ирсэн байгаа юм. Эдийн засгийн үр ашигтай байх. Бидний гол Үндсэн хуулийн 6.2 гэдэг заалт маань бол стратегийн ордыг ашиглахад үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох гэдэг үндсэн хуулийн нэр томъёо байгаа. Үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох гэж. Одоо энэ Засгийн газраас орж ирсэн Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх гэдэг энэ заалтыг ажлын хэсэг Монгол Улсад үр өгөөжтэй байх болгож өөрчлөх санал хураалгах гэж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр би тодруулж асуух гэж байгаа нь Монгол Улсад үр өгөөжтэй байх гэдэг маань энэ Үндсэн хуулийн 6.2-т нийцэж байгаа юу? 6.2 маань энэ дийлэнх олонх үр өгөөж нь ард түмэнд ноогдох гэдэг. Монгол Улсад үр өгөөжтэй байх гэдэг бол сая Пүрэвдорж гишүүн 54 хувь нь Монголд ашигтай гэж өөрөө яриад байна. Би яг хэдэн хувь нь үр өгөөжтэй байх юм бэ гэдэг зүйлийг асуугаад хариулт авч чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Сая бол протоколд 54 хувь гэж хэллээ.

Тэгэхээр Монгол Улсад үр өгөөжтэй байх гэдэг чинь 1 хувь ч байж болно шүү дээ. Энэ үг, энэ хураалгах гэж байгаа томьёолол бол. 1 хувийн үгүй энэ чинь Монгол Улсад л үр өгөөжтэй байна шүү дээ. Хэдэн хувь юм? 1 хувь Монгол Улсад үр өгөөжтэй л байна.

Үндсэн хуулийн 6.2 бол үр өгөөжийн дийлэнх гэдэг нэр томьёо байгаа байхгүй юу. Энэ бол сая хүмүүсийн яриад байгаа зарим нь 50 дээр нэмэх1 гэж яриад байна. Тэгэхээр энэ томьёолол маань нэгдүгээрт болж байгаа юу?

Хоёрдугаарт, хувьцааны төрлийг өөрчлөх зэргийг харгалзан гэж ийм зэрэг гэх мэт гэдэг ийм нэршил ашиглаж болж байна уу, үгүй юү? Энийг сүүлд нь, дараа нь хэн тодорхойлох вэ? Засаг ингээд зэрэг энийг харгалзана гэсэн юм гээд тэнд нэг хүн хүн тайлбар хийгээд явах юм байна шүү дээ “зэрэг”. Тэгээд хууль зүйн техникийн хувьд ийм “зэрэг” гээд ийм юу нь мэдэгдэхгүй ийм нэршлээс бол татгалздаг юм шүү дээ ер нь. Тийм. Энэ дараа нь юу бодож энийг оруулсан юм бэ гэдэг асуудал.

Төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх гэж Компанийн хуульд оруулж байгаа давуу эрхийн хувьцаагаар оруулах асуудлыг энд бас оруулаад ирсэн байна. Энд Компанийн хууль дээрээ яримаар байдаг.

Г.Тэмүүлэн: Яах вэ нөгөө 2 дугаар бүлэгтэй холбоотой бөөнд нь эхлээд асуулт асуун. Тэгээд зүйл бус бүрээр дараа нь яана. Саяынх дээр хариулах уу? 3 биш ээ. 3 уу? За окэй Энхбаяр гишүүнийх 3-тай холбоотой байсан байна. Тийм байна. Окэй.

Саяынх дээр хариулт хийх үү? Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн дарга уу? Сая ажлын хэсгийн саналтай холбоотой асууж байх шиг байна. Пүрэвдорж гишүүн. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Энэ дээр болохоороо одоо бид нар 5.4, 5.5. 5.4 чинь болохоор 3 дугаар зүйл дээр яригдаж байгаа шүү дээ тээ. 5.2, 5.3-ынх чинь болохоороо яг тэр явцууруулсныг хассан хэсэг маань л яг 2 дээрээ санал нь явж байгаа гэсэн үг.

3-ын хувьд болохоор Энхбаяр гишүүний ярьж байгаатай ерөнхийдөө санал нэг байна. Тэр “зэрэг” гэдэг бол анхны нөгөө төсөл дээр ороод явчихсан. Тэгэхээр “зэрэг” гэдэг үг өөрөө угаасаа бас нөгөө энэний дараа өөр ямар нөхцөлүүд оруулах вэ гэдэг бас юм орж ирээд байгаа учраас тэн дээр бас ажлын хэсэг редакц хийх ч юм уу тэр боломж нь байх болов уу гэж харж байна.

Нөгөө талаасаа энэ нөгөө “үр өгөөжтэй байх” хувилбар гэдгийг яг нөгөө редакцаар Үндсэн хууль дээр байгаа нэр томьёогоор орлуулъя гэдгээр нөгөө “үр өгөөжтэй” гэдгээр сольж оруулж ирсэн нэршил нь, томьёолол нь.

Нөгөө талаасаа энэний санаа нь уг нь ийм юм байгаа юм. Хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн авах төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөхдөө Монгол Улсад үр өгөөжтэй байх хувилбарыг харгалзан гэдэг санаа байхгүй юу. Тэгэхээр энэ “” гэдэг маань өөрөө 34 хувийг бид нар үнэгүй авч байсан. Тэр үнэгүй авсныхаа төлөө жишээлбэл, ямар хэмжээний хөрөнгө оруулалтыг дараа нь нэмж оруулаад, дараа нь хэдий хэмжээний ноогдол ашгийг авах вэ гэдэг энэ тооцооллуудаа хийж байгаад энэнээсээ илүү үр өгөөжтэй байх тэр нөхцөлийг л оруулъя гэдэг санаагаар энэ нөгөө хувилбарыг сонгохдоо Монгол Улсад үр өгөөжтэй байх гэдэг чинь үр өгөөжтэй байх гэдэг маань байсан икс гэдэг нөхцөл байдлаас арай илүүтэй нөхцөл байдал руу орох тэр хувилбарыг оруулна гэдгээр л томьёолсон санаа яваад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн нэмж тодруулъя 2 дугаар зүйлтэй холбогдуулж.

Б.Энхбаяр: Тэгвэл яг үндсэн хуулийн нэр томьёогоор нь оруулсан юм гэж хэлж байна шүү дээ. Тэгвэл яг Үндсэн хуулийнх нь нэр томьёогоор л бичье. Үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох гэдэг л Үндсэн хуулийн заалт байгаа.

Яагаад энэ ялгаатай вэ гэхээр улс, Монгол Улсад үр өгөөжтэй байх гэдэг бол Үндсэн хуульд хуулийн нэр томьёо гэдэг чинь цаанаа утгатай шүү дээ. Улс гэдэгт нэгдүгээрт газар нутаг, хоёрдугаарт төр, гуравдугаарт ард түмэн гэсэн ийм 3 ойлголтыг нийлүүлж байгаад улс гэж хэлдэг.

Үндсэн хуулийн нэр томьёо бол ард түмэнд үр өгөөжтэй байх гэдгийг нь хэрэглэсэн байхгүй юу. Төрд, газар нутаг гэдэг энэ хоёр улс гэдэгт багтдаг ойлголтоос нь салгасан гэсэн үг. Тийм учраас яг Үндсэн хуулийнх нь нэр томьёогоор бичихгүй бол Монгол Улсад үр өгөөжтэй байна гэдэг бол Монголын төрд үр өгөөжтэй байна гээд дараа нь тайлбарлаж болох нь байна шүү дээ.

Хоёрдугаарт, 1 хувь ашигтай байсан ч Монгол Улсад үр өгөөжтэй байна гээд дараа нь энийг буруугаар тайлбарлаж явна. Тийм учраас яг Үндсэн хуулийнх нь нэр томьёогоор л тайлбарлаж явах ёстой. Үгүй үгүй яг Үндсэн хуулийн нэр томьёогоор. Харин Үндсэн хуулийн 6.2-ыг л барих ёстой байхгүй юу. Үндсэн хуулиас өөр нэр томьёо ашиглаж болохгүй байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Окэй, за ойлголоо. Саяын санал дээр бол 3 дугаар зүйл дээр санал гаргах нь байна.

Одоо 2 дээрээ саналаа хураалт явуулъя. Та бүхэнд саналуудыг танилцуулъя. Ингээд гишүүд 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа.

Саналын томьёоллуудыг та бүхэнд танилцуулъя. Ингээд санал хураалт явуулна.

Ажлын хэсгийн санал. Төслийн 2 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэгт “Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг цацраг идэвхт ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн өгүүлбэр,” гэснийг хасах гэсэн байна.

Энэ бол ажлын хэсгийн санал байгаад байгаа. Тэгээд энэ 5.2, 5.3 дээрээсээ хасаад, 5.4 дээрээ өөрчлөн найруулаад сая ерөнхий агуулгыг нь бол оруулж байгаа.

Ганбаатар гишүүн бол 5.2, 5.3 дээр хэвээр нь үлдээх гэсэн санал өгсөн байгаад байгаа. Тэгэхээр бол үндсэндээ ажлын хэсгийн саналтай таны санал нийцэж байна гэсэн үг. Тэгээд хамгийн сүүлд нь оруулсан саяын тэр нөгөө миний уншсан өгүүлбэрийг бол хасаж байна гэсэн үг. Орлуулж болно гэдэг агуулгыг тийм. Тэгээд ерөнхийдөө бол саяын нөгөө таны шууд авна гэсэн энэ логикийг бол хэвээр нь үлдээгээд, хэрэв орлуулах тохиолдол гэдэг нь бол 5.4 дээрээ, 5 дээрээ нэмж орж ирж байна гэсэн үг тээ? Нэмж орж найруулгаар орж ирж байна гэсэн үг болж байгаа юм. Тэгэхээр бол үндсэндээ энэ саналууд бол нэгтгэгдээд явж байна гэж ойлгож болно шүү.

Ингээд эхний ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. Саяын 5.2, 5.3 дахь төрийн эзэмшлийн хувь, хэмжээг цацраг идэвхт ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно гэсэн өгүүлбэрийг хасах.

Дэмжье, ажлын хэсгийн саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Ажлын хэсгийн санал 77.3 хувиар дэмжигдлээ.

Одоо 3 дугаар зүйлтэй холбоотой. 2 дугаар зүйл дээр санал хураалт явуулж дууслаа.

3 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Энхбаяр гишүүн ч түрүүн асуучихсан даа бараг тээ? Асуучихсан даа. 3 дугаар зүйлтэй холбоотой дахиад нэмж үү? Энхбаяр гишүүн асууя. Өөр асуух хүн байна уу? Алга байна. Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би Төслийн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэгт 30.1.1 тогтворжуулах татварын орчныг тогтоох гэдэг заалттай холбоотой асуулт байна. Ажлын хэсгийн ахлагч болон холбогдох сайд нараас асууж байгаа юм.

Энэ ажлын хэсэгт өгсөн санал дээрээ би яг гол нь энийг л хөндөөд хөндөөд байгаа юм. Яагаад гэхээр энэ татварын ерөнхий хуульд байгаа энэ татварын орчныг тогтвортой байлгах гэдэг заалтыг тогтворжуулах татварын орчныг тогтоох гэж өөрчлөөд байгаа юм. Тогтворжуулах татварын орчныг тогтоох гэдэгтэй болохоор тайлбарлахдаа татварын хувь, хэмжээ, элэгдэл, хорогдол тооцох хугацаа татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа гэсэн ийм 4 зүйлээр тайлбарлаж байгаа.

Энэ татварын тогтвортой орчныг тогтоох гэдэг хүчингүй болгох гээд байгаа энэ заалт бол 2013 онд Татварын ерөнхий хуульд орсон заалт. Өөрөөр хэлбэл

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээн дээр татвартай холбогдолтой, холбоотой асуудлаар алдаа гарсныг залруулах зорилгоор 4 жилийн дараа 13 онд оруулсан өөрчлөлт.

Тэгэхээр энийг байхгүй болгох гээд байгаа юм. Байхгүй болгочхоод магадгүй би энэ Сангийн яам бүүр тодорхой хариулаасай гэж бодож байна. Энэ 4 заалт одоо Сангийн сайдын татварын үнэлгээ тооцох аргачлал буюу Сангийн сайдын тушаалаар батлаад байгаа, тэрийгээ татвар тогтворжуулах татварын орчныг тогтоох гэдэг ийм юмаар оруулж ирж байгаа юм биш үү гэж би асуух гээд байна.

Өөрөөр хэлбэл, Сангийн сайд өөрчлөгдөх болгонд татвар өөрчлөгдөөд байгаа шүү дээ. Сангийн сайд татвар тогтоогоод байгаа байхгүй юу. Яагаад гэхээр аргачлалаар дамжуулж. Аргачлалаа өөрчлөгдөнгүүт татвар нь нэмэгдэж, хасагдаад байгаа байхгүй юу. Татвар тогтоох эрх бо Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх. Өнөөдөр Сангийн сайд аргачлалаар дамжуулж татвар тогтоогоод байгаа. Энэ Үндсэн хуулийн зөрчил. Тэгэхээр энэ зөрчлийг хуульчилж байгаа асуудал юм биш үү гэж би шууд хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ Оюу толгойтой өнөөдөр Лондоны арбитра т байгаа 20 их наяд төгрөгийн татварын маргаан дээр айлын талд давуу байдал энэ өөрчлөлт орвол орно гэдэг ийм саналыг би бичиж өгчхөөд байгаа юм. Тэгэхээр би энэ дээр албан ёсоор Монгол Улсын өмнө байгуулсан Оюу толгойтой холбоотой татварын маргаан дээр болон ирээдүйд байгуулах гэж байгаа Чайна Энержи, бусад том гэрээнүүд дээр ямар татварын.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам 8 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Гишүүний асуултад хариулъя.

Татварын тогтворжуулалттай холбоотой асуудал бол Монгол Улс өнгөрсөн хугацаанд тогтвортой байдлын гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ гэх мэтчилэн ингээд тогтворжуулалттай холбоотой олон гэрээ хийж байсан. Үүнтэй холбоотой сургамжуудад үндэслээд ер нь нэгмөр ингээд цэгцэлье гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр одоогийн байгаа эрх зүйн орчин дээр татварын орчин гэдэг нь хөрөнгө оруулалтын хуулиар 4.1.7 дээр, 3.1.7 дээр хуульд заасан татварын төрөл, тэдгээрийн хэмжээг тодорхойлох, ногдуулах, төлөх эрх зүйн зохицуулалтын бүрдлийг заана гээд. Тэгэхээр яг гишүүний хэлж байгаа энэ өөрөө эрх зүйн зохицуулалтын бүрдэл гэдэг нь тэр дагалдаж байгаа бүх дүрэм, журам, мөнгөн чөлөөлөлт бүгд орохоор юм шиг ойлголттой. Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн хууль дээр татварын орчны хөрөнгө оруулалтын гэрээгээр тогтворжуулна гээд биччихсэн. Тэгэхээр бид нар энийг засах ёстой гэж үзээд өнөөдрийн хуулийг бид нар оруулсан.

Яаж засах гэж байна гэхээр Оюу толгойн гэрээн дээр хамгийн том маргаан бол өөрөө энэ байгаа. Тухайн үеийн бүх тэр татварын бараг үг, үсэггүй тогтворжих гэдэг агуулгатай маргаж байгаа. Бидний оруулж байгаа, Татварын Ерөнхий хуульд оруулж байгаа 6.1.50 дахь заалтаар бол олон улсын туршлагад үндэслээд тогтворжуулах татварын орчин гэдэгт ерөөсөө энэ хөрөнгө оруулалтын гэрээн дээр өгөөжийн тооцоололд шууд нөлөө үзүүлдэг 3 төрлийн параметрийг л оруулъя. Татварын хувь хэмжээ, АМНАТ-ын хэдэн хувь байдаг юм, аж ахуйн

нэгжийн 25 гэдэг юм уу, элэгдэл, хорогдолд тооцох хугацаа гээд Аж ахуйн нэгжийн орлогын орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлд байгаа барилга. Байгууламж 40 жил, тоног төхөөрөмж 10 жил ч гэдэг юм уу.

Гуравдугаарт нь татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа буюу lost carryforward гэж ярьдаг хөрөнгө оруулалтаа ингээд нөхдөг. Энэ бол аж ахуйн нэгжийн орлогын татварын хуулийн 21 дүгээр зүйл дээр 4 жил байдаг. Зөвхөн энэ 4, энэ 3 параметрийг тогтворжуулна гээд.

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, гишүүний хэлж байгаа энэ заалтууд, одоо байгаа энэ хөрөнгө оруулалтын гэрээний 3.1.7 дээр татварын эрх зүйн орчны бүрдэл гэж байгаа нь өөрөө маргааны үндэс. Тэгэхээр бид нар цааш цаашдаа хөрөнгө оруулалтын гэрээ хийх болон Монгол Улсад хөрөнгө оруулах гэж байгаа энэ олон талууд дээр энэ ойлголтоо цэгцэлж яг юуг ойлгох вэ гэдгээ тогтвортой, тодорхой болгохгүй бол энэ өөрөө хөрөнгө оруулалтынхаа орчинд сөрөг нөлөө үзүүлээд байгаа. Тэгэхээр энэ 6.1.50 болон бусад заалтууд орсноор Оюу толгой болон ирээдүйд байгуулах гэрээний татварын тогтворжуулалт бол хумигдана. Энэ дээр ямар нэгэн давуу байдал өмнөхөөсөө илүү байдал үүсэхгүй гэдэг дээр ингээд албан ёсоор хэлж байна.

Тэгэхгүй бол, хоёр дахь асуудал энэ асуудлыг оруулж байгаа нь Татварын ерөнхий хуулиар татварын тогтворжилтыг зөвхөн хөрөнгө оруулалтын гэрээгээр хийнэ гээд Цөмийн энергийн хуульд байдаггүй. Тэгэхээр бид нар хөрөнгө оруулалтын хэлэлцээр хийх явцад Татварын ерөнхий хуулийн энэ тогтворжуулалттай холбоотой энэ 4 дүгээр зүйл дээр эрх олгогдоогүй гэдэг хуулийн зөрчил үүсэх гээд байгаа юм. Тэгэхээр бид нар.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн нэмж тодруулъя.

Б.Энхбаяр: Энэ яг албан ёсны протокол болж байгаа шүү. Хуулийн тайлбарлахад дараа нь энэ протоколыг барьдаг. Тэгэхээр Тэлмүүн даргын саяын хэлж байгаагаас логикоос харахад Монгол Улсын Засгийн газрын Лондоны арбитрын шүүх дээр Оюу толгойн татварын маргаан дээр манай талын үзүүлж байгаа байр сууриа бид өөрчлөх гэж байгаа юм байна. Хуулиар шүү. Та бол сая яг тийм агуулгатай байдал. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ гэхээр бид Лондоны арбитрын шүүхэд гаргасан гомдлоосоо Монголын төр албан ёсоор ухрах гэж байна.

Тийм учраас би асуугаад байгаа шүү дээ. Энэ Лондоны арбитрт явж байгаа маргаанд нөлөөлөх үү, нөлөөлөх гээд байна гэдэг эрсдэлийг нь би зүйл, заалтыг нь ярьж байгаад асуусан. Энэ бол саяын таны хариултаас шууд нөлөөлөхөөр тайлбар өгчихлөө шүү дээ. Энэ хэдэн их наяд төгрөгийн татварын маргаан шүү. Саяын, одоо бидний санал хураах гэж байгаа энэ заалт. Хэдэн тэрбум долларын үр өгөөж Монголын ард түмэнд ноогдох уу, үгүй юү гэдэгтээ шийдвэрлэх ийм санал хураалтыг оруулж ирчхээд байгаа байхгүй юу. Би тийм учраас ажлын хэсгээс албан бичгээр өгөөд энэ дээрээ тайлбар авмаар байна гэж хандаад байгаа нь ийм учиртай. Саяын протоколоос бол би шууд тэгж ойлголоо шүү.

Г.Тэмүүлэн: Сангийн яам 8 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Нэмж хариулъя.

Энэ тодорхойлолт урьд өмнө байсан энэ татварын тогтворжуулалтын энэ бүх өмнөх заалтуудыг хумьж байгаа. Ямар нэгэн байдлаар өргөтгөж байгаа, илүү давуу эрх олгож байгаа юм огт байхгүй. Энийг би хариуцлагатайгаар хэлье нэгдүгээрт.

Оюу толгойн гэрээний хувьд бол Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээний 15.23-д хэрэв шинээр батлагдсан хууль тогтоомж нь аль нэг талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхээр байвал гэрээний нөхцөлүүд хүчин төгөлдөр байна гэдэг заалттай. Тогтворжих гэж байгаа юм. Энэ ямар ч ашигтай юм байхгүй. Яагаад гэхээр би танд дахиад хэлэх гээд байна. Энд бол татварын хувь хэмжээ, элэгдэл тооцох хугацаа, тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа энэ гуравхныг л тогтворжуулж байгаа.

Жишээлэх юм бол Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуулийн 21 дүгээр зүйл дээр тайлангийн гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаатай асуудлыг зохицуулсан 21 хэсэг заалт байгаа. Бид нар энэ дундаас зөвхөн 4-хөн жил гэдэг нэг ийм хугацааг л тогтворжуулж байгаа юм.

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ болон тухайн үед үйлчилж байсан эрх зүйн орчинд татварын орчин буюу тэр тухайн үед үйлчилж байсан эрх зүйн иж бүрдлийг нь ойлгоно гэж байсан. Бид нар энийг ийм 3-хан параметр болгож хумьж байгаа учраас ямар нэгэн байдлаар Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ нь Монголын талд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Энийг би танд албан ёсоор хэлж байна.

Г.Тэмүүлэн: Нэг тодруулчихъя Энхбаяр гишүүн маргаантай асуудал учраас.

Б.Энхбаяр: Тэгэхээр саяын ярьж байгаа 4 параметр гэдэг нь татварын орчны бүрдэл гэдэгтэй орно гэдгийг та хэлж өгч байгаа гэж хэлээд байна шүү дээ. Тодорхой болгож.

Лондон дээр явж байгаа тэр арбитрын маргаан чинь манайх энэ 4-ийг тооцож, тооцохгүй гэж маргаад байгаа юм уу? Тооцож байгаа гэж маргаад байгаа юм уу? Бид нар энэ хэсэгтээ тооцохгүй гэж бодож татварын акт тавьчихсан юм уу, тавиагүй юм уу? Тэрнээс чинь хамаараад байна шүү дээ. Хэрвээ энэ 4-д заасан асуудлаар тэнд маргаан байгаа бол тэнд шууд нөлөөлөх гээд байна. Таны хариултаас бол би нөгөө тал бол энийг татварын тогтвортой орчиндоо оруулахгүй гэж үзээд байгаа юм уу айлын тал?

Г.Тэмүүлэн: Тэлмүүн дарга 8 номер.

Б.Тэлмүүн: Нэгдүгээрт, бид нар хөрөнгө оруулалтын гэрээний татварын орчин гэдэг энэ ерөнхий нийтлэг ойлголтыг өөрчилж байгаа. Тэгэхээр одоо энэ 3-ыг энэ тогтворжуулах татварын орчинд заасан энэ параметр гээд байгаа зүйлс ингээд тэнд нэмэгдэж ороод байгаа юм байхгүй. Хөрөнгө оруулалтын хуулийн 3.1.7-гоор 3.1.7 дахь заалтыг өөрчлөн найруулж байгаа. Тэгэхээр тогтворжуулах татварын орчин гэдэг асуудал яригдана.

Оюу толгойн арбитрын маргааны хувьд яг энэ 3 буюу хувь хэмжээ, элэгдэлд тооцох хугацаа, алданги шилжүүлэх хугацаан дээр маргасан юм байхгүй. Хөрөнгө оруулалтын гэрээнд жишээлэх юм бол алданги шилжүүлэх хугацаа жишээ нь одоогийн хуулиар 4 жил байдаг, тэднийд бол 8 жил байгаа. Тэнд юу гарч байгаа маргаан байна гэхээр дандаа давхар татварын гэрээ, үнэ шилжилт, хөрөнгийн

ангилалтай холбоотой нягтлан бодох бүртгэлийн нөгөө ангиллууд, суутган татвар гэх асуудлууд. Тэрнээс тэн дээр 5 хувь байсан уу, 10 хувь байсан уу, 25 хувь байсан уу гэдэг маргаан бол тэнд байхгүй. Эсвэл тэр элэгдэл тооцоод байгаа хугацааг 25 байсныг нь 40 байх байсан ч юм уу, 10-ыг 20 байх байсан гэдэг тийм маргаан тэнд байхгүй.

Тэгэхээр Оюу толгойн арбитрын маргаанд энэ хуулийн өөрчлөлт ямар нэгэн байдлаар сөргөөр нөлөө үзүүлэхгүй. Цааш цаашид хийгдэх хөрөнгө оруулалтын гэрээнүүд дээр Монгол Улсын тогтворжих татварын орчин илүү ойлгомжтой, хумигдмал байдалд орно.

Тэгэхээр бид бас цаашдаа энэ Орана групптэй татварын маргаан аль болох үүсэхгүй эхнээсээ ийм тодорхой орчин үүсгээд явах нь зүйтэй гэдэг байдлаар илүү тодорхой болгож тэгээд хууль хоорондын нийцлийг бас уялдуулж ингэж орж байгаа.

Г.Тэмүүлэн: Одоо санал хураалт явуулна. 5.5 дээр тээ?

Төслийн 3 дугаар зүйл дээр асуулт 3 дугаар зүйл дээр гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо ирүүлсэн саналуудыг та бүхэнд эхлээд танилцуулъя. Ажлын хэсэг 1 саналтай байгаа. Дээрээс нь нэмээд хэн хэнийх байна? Эхнээс нь танилцуулаад явъя. Сайнзориг гишүүний редакцын санал байгаа, Пүрэвдорж гишүүнийх байгаа, Эдийн засгийн байнгын хорооны 3 санал байгаа. Батчимэг гишүүнийх бас байгаа. Хамгийн сүүлд ирсэн сая ирсэн байна.

Би эхнээс нь бүгдээрэнг нь танилцуулаадахъя.

Нэгдүгээрх нь ажлын хэсгийн санал, ажлын хэсэг дэмжсэн санал байгаа.

5.5 нь 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 5.4 дэх хэсгийг 1 дүгээр зүйлд шилжүүлж, 5.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг Монгол Улсад үр өгөөжтэй байх хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэсэн ийм санал байгаа.

Үгүй, эхлээд ажлын хэсэг нь унаж байж таны санал явна гэсэн үг л дээ. Тэгэхээр таных хоёрт танилцуулагдана гэсэн үг.

Энэтэй холбоотойгоор 2 дахь нь Пүрэвдорж гишүүн гаргасан санал байгаа. Та микрофон дээр танилцуулчих эхлээд.

Б.Пүрэвдорж: Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг

харгалзан Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно гэж.

Тэгэхээр би энэ зэрэг гэдгийг хассангүй. Яагаад гэвэл энэ чинь санхүүгийн маш их олон хувилбар, гэрээ хэлцлийн маш их олон хувилбарууд байгаа. Тэр болгоныг зөвхөн энэ 3-аар хаачихлаар болохгүй байна. Тийм учраас тухай тухайн гэрээ, асуудал орж ирэхэд бас тодорхой хэмжээгээр яг энэ хуулийн заалтаа нэмэх маягаар оруулж болно.

Тэгэхээр энэ дээр би Энхбаяр гишүүний яг Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу Монгол Улсад үр өгөөжтэй байх гэдгийг хасаад, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох гэж Үндсэн хуулийн заалтын дагуу өөрчилж байгаа юм. Тэгээд энэ бол яг Уянгахишиг гишүүний саналыг редакцын хувьд л жоохон өөрчилж байгаа л гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн 2 дахь санал нь ийм гаргасан байна.

3 дахь нь Сайнзориг гишүүн ажлын хэсгийн санал дээр өөрчилж байгаа юм байна тээ? Эсвэл одоо байгаа томъёолол дээр нь үү Засгийн газрын өргөн барьсан? Болж байна уу? Энэ хэнийх болохоор Сайнзориг гишүүнийх болохоор өөрчлөх гэсний дараа дээрхийг ногдуулах гэж нэмэх гэж байгаа, аа дээрхийг хослуулах гэж нэмэх гэж байгаа юм байна.

Өөрчлөх гэсний дараа дээрхийг хослуулах гэж нэмэх гээд. Ийм хослуулах.

Гуравдугаарх нь 1, 2, 3, дөрөвдүгээрх нь юм байна шүү. Сайнзориг гишүүнийх 3 дахь нь.

Дөрөвдүгээрх нь Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байгаа. Энхтүвшин гишүүнийх. Тэгэхээр таны энэ дэмжсэн энийг хураалгах уу, эсвэл сүүлд гаргасныг яах вэ? Аль нь байх вэ? Алийг нь би танилцуулах вэ? Айн энэнээсээ татаж байна гэсэн үг үү? Болохгүй байх. Ямар ч Эдийн засгийн байнгын хорооныхыг бол.

Би эхлээд танилцуулаадахъя.

5.4.Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төр эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад өнөөгийн үнэ цэнээр эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ зүйлийн 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно гээд Энхтүвшин гишүүн Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн ийм санал байгаа юм байна.

Дахиад 5 дахь нь. 4 дэх нь Энхтүвшин гишүүнийх. 5 дахь нь Эдийн засгийн байнгын хороо нь дэмжээгүй санал байгаа шүү дахиад танилцуулчихъя.

5.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах гээд Сэддорж гишүүнээс гаргасан байна. Энэ хуулийн 5.2, 5.3-д зааснаас илүү өөрөөр, илүү хувиар гэж байна. Зааснаас илүү хувиар төр хувьцаа эзэмших тохиолдолд стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх,

төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэж.

Тэгээд одоо 6 дахь нь дахиад бас дэмжээгүй Эдийн засгийн байнгын хорооны санал байгаа юм байна. Бадамсүрэн гишүүний гаргасан.

5.4 нь стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ хууль зүйлийн 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болох бөгөөд Засгийн газар тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлсэн талаарх тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулна гээд Бадамсүрэн гишүүнийх 6 дахь нь ийм байна.

7 дахь нь Энхтүвшин гишүүнийх гаргасан санал байгаа.

Стратегийн, 5.4 стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх хувилбарыг харгалзан энэ хуулийн 5.2, 5.3-д заасан хувь, хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно гэсэн ийм саналыг Энхтүвшин гишүүн 7 дахь санал болгож гаргаж байгаа юм.

Пүрэвдорж гишүүнийхтэй бараг адилхан болчхож байх шиг байна гэж харлаа тээ? Саналуудаа тайлбарлаж болно.

Б.Бат-Эрдэнэ гишүүн 8 дахь нь. 5.4. Б.Бат-Эрдэнэ гишүүний гаргасан санал.

Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хаалтын доторх хувь хэмжээг тодорхой заасан тохиолдолд хувийг бичих гэсэн байна. Тэгээд хаалт хаагаад төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан эс үгүй бол оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ зүйлийн 5.2, 5.3-д заасан хувь хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэсэн. Ийм 8 дахь санал байна.

9 дэх нь Батчимэг гишүүн гаргасан санал байна. Ирүүлсэн.

5.4.Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төр эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан энэ зүйлийн 5.2, 5.3-д заасан хувь, хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно гэснийг хасах гэж байгаа юм байна. Хасах гэсэн ийм санал байгаа.

Ингээд ийм 9 санал ирсэн. Энэ дээрээс ажлын хэсэг 2 дугаар санал дээр Пүрэвдорж гишүүн саналаа тайлбарлачихсан. Дараачийнх нь дарааллаараа Сайнзориг гишүүн. Сайнзориг гишүүн саналаа тайлбарлая.

П.Сайнзориг: Би бол ерөнхийдөө ажлын хэсэг болон Засгийн газрын энэ ерөнхий хууль дээр туссан энэ концепцыг хадгалаад ерөнхийдөө аль алиныг нь хослуулсан байдлаар явчихъя гэж байгаа.

Ажлын хэсгийн ахлагч бас боломжтой бол зэрэг гэдэг үгээ эсвэл бусад боломжит аргыг гэдэг юм уу тийм үгээр бас орлуулж болж байна. Энэ дээр нэлээн том бусад боломжууд орж ирэх байх.

Хоёрдугаарт бас Энхбаяр гишүүн, ажлын хэсгийн ахлагчийн, Энхтүвшин гишүүний гаргаж байгаа санал дээр редакцаар ингэж болох уу би зүгээр редакцын саналаа нэгмөсөн хэлчихье л гэж байгаа юм. Яг Үндсэн хуулийн яг үг хэллэгээрээ гээд ард түмэнд гээд яачихаар тийм эзэн биегүй болчхоод байна. Яг энэ зарчмыг бариад хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээ хийхэд их хэцүү. Яг ард түмэн өөрөө сонгосон төлөөллөөрөө л энэ эрхээ хэрэгжүүлж байгаа шүү дээ гадаад, дотоодын хүмүүстэй. Тийм учраас төр гэдэг энэ институтийн хувьд хуулийн этгээдийн эрхтэйгээр энэ хөрөнгө оруулалтын гэрч нартай гэрээ хэлэлцээр хийж байгаа юм. Тэгэхээр би бас Монгол Улсад гэдэг энэ үгээрээ явчхаач. Үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад.

Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсын ард ард түмэн л байж байгаа, төр байж байгаа. Ингэж байж ингээд бас жоохон ойлгомжтой болгохгүй бол яг Үндсэн хуулийнхаа үг, үсгээр явчихаар нөгөө хөрөнгө оруулагчтай яг ард түмэнд дийлэнх нь байгаа гэдэг зарчим яриад явахаар энэ ерөөсөө хөрөнгө оруулалтын асуудал бас яг тийм эзэн биегүй болчих гээд байгаа юм уу гэсэн тийм л юм байна. Тэн дээр бас ажлын хэсгийн ахлагч болон санал гаргаж байгаа гишүүд зүгээр бодолцооч. Хэдүүлээ дараа нь ингээд маргаж байхаар.

Г.Тэмүүлэн: Одоохон, 9 санал би сая уншаад танилцуулчихсан.

10 дахь санал бас сая хоцорсон байна. 10 дахийг нь уншаад танилцуулаадахъя. Анхааралтай сонсож байгаарай 5.4 дээр С.Ганбаатар гишүүний санал байгаа. Аравдугаарх нь. Цөмийн эрчим хүчийг ашиглаж ногоон, цэвэр хямд эрчим хүч үйлдвэрлэгч орон болно гэсэн ийм заалт байна гэсэн үг.

Та саналаа тайлбарлах уу? Ганбаатар гишүүн 10 дахь санал гаргасан. Саналаа танилцуулъя. Ганбаатар гишүүн, С.Ганбаатар.

С.Ганбаатар: Энэ 5.4 дээр оруулж байгаа санал маань энэ Цөмийн эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ санал анх орж ирэхдээ гарчиг дээр нь юу гэж заасан, эхний тайлбар дээр нь юу гэж заасан бэ гэвэл цөмийн эрчим хүчээр хямд, ногоон эрчим хүч үйлдвэрлэх ийм сайхан ирээдүйн төлөө энийг оруулж ирж байна л гэж ярьсан. Монголын ард түмнийг ингэж хуурч, зүгээр шар нунтаг гаргаад, шар нунтага цөмийн эрчим хүчийг үйлдвэрлэнэ гэдгээр орлуулж сольж байгаа гэдгээ одоо бид ичих ёстой байхгүй юу. Ядаж 5.4 дотроо ирээдүйд бид цөмийн эрчим хүчээр хямд эх үүсвэрээ гаргана гэдгээ оруулчхаач ээ.

Хоёрдугаарт, түрүүн 34 хувиасаа татгалзана гэдэг бол бид өөрсдөө энэ цацраг идэвхт бодисоо, ашигт малтмалаа буцаагаад гаднын орноос гуйх хэмжээнд очихоор болчхоод байгаа юм. Ядаж энэ эрх зүйн орчин дотроо Монголын ард түмэнд ярьдаг, рекламдаг зүйлээ ядаж эрх зүйн орчиндоо оруулж өгөөч гэдэг ийм хүсэлтийг би гаргаж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүнд баярлалаа. Энхтүвшин гишүүн таны 2, 3 санал байгаа тээ? Энхтүвшин гишүүн саналаа танилцуулъя, тайлбарлая.

Д.Энхтүвшин: Эхний тэр нөгөө, 2 санал байгаа. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал дээр болохоор өнөөгийн зах зээлийн үнээр эдийн засгийн үр өгөөжтэй гэдэг заалтыг оруулсан юм. Тэгэхээр яах вэ, энэ маань бас хэлэлцээрийн явцад бас нөгөө тал маань бас энэ заалтыг өнөөгийн үнэ цэн гэдэг нэр томъёог ашиглаад бас хэлэлцээрийн давуу тал олох тийм явц байгаа учраас энэ саналыг татъя гэсэн саналтай байна.

Тэгээд энэ гол нь бол өнөөгийн үнэ цэн гэж оруулдаг нь болохоор тэр дискаун трейд гээд санхүүгийн тооцоолол дээр ганцхан хувь өөрчлөгдөхөд л энэ ард түмэнд ноогдох хувь ямар болохыг өөрчилж шийдэж байгаа. Тэгэхээр энэ нь өөрөө их субъектив заалт байсан учраас өнөөгийн үнэ цэн гэдэг үзүүлэлтүүдийг заавал оруулахгүй бол нэрлэсэн үнээр нь жишээлбэл, 20 жилийн дараах сая доллар тэр дискаун трейд-ийн 5 хувиар тооцоход 480 мянган доллар, 10 хувиар тооцоход 150 мянган доллар болж байгаа байхгүй юу. Тэгэхээр иймэрхүү зөрүү байгаа учраас бас хийдэл гарах вий гэдэг утгаар нь ийм санал оруулсан юм.

Гэхдээ саяын гишүүдийн ярьж байгаа томъёоллоор Үндсэн хуулийн энэ зарчмаар нь энэ заалтаа оруулчихвал өгөөжийн дийлэнх нь ард түмний ноогдох гэдэг байдлаар өөрчилчихвөл энэ саналыг татъя гэсэн нэгдүгээрт ийм саналтай байна.

Хоёрдугаарх нь болохоор яг энэ Үндсэн хуулийн заалтыг ашиглаж оруулсан байгаа. 6.2-ыг өөрчилж. Тэгэхээр гишүүдтэй нэлээн давхардаж энэ гол юм нь болохоор тэр ард түмэн байх уу, Монгол Улсад ноогдох уу гэдэг асуудал байна. Тэрийг редакц дээрээ засаад, нийлүүлээд саналаа нэг болгоод томъёолоод явчхаж болох юм уу? Миний хувьд бол яах вэ, ер нь ялгаагүй байх. Ногдох гэж байгаа болохоос биш өгөх гэж байхгүй. Ард түмэнд ногдох гэж байгаа болохоос биш энэ бол яг өгнө гэсэн үг биш учраас бас заавал Монгол Улс гэж Үндсэн хуулийн тэр биччихсэн заалтыг өөрчлөх бас хэрэг байна уу, үгүй юу энэ чигээр нь явчихвал яасан юм бэ? Тэгээд яах вэ, редакц дээрээ ажиллаж байгаад бүгдээрээ ижилхэн саналтай байгаа учраас энийгээ засаад нэг санал болгоод санал хураачихвал гэсэн тийм саналтай байна.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүнд баярлалаа. Ерөнхийдөө бас хэд хэдэн агуулгын хувьд давхцалтай саналууд бас гарч ирж байна 10 санал дотор.

Эхнээс нь саналаа хураалгана. Пүрэвдорж гишүүн саналын томъёоллоо жоохон найруулж байгаад тээ? Танилцуулчих уу та? 2 дээр хураагдана. Тэгэхээр та тэрнээс өмнө эхлээд саналаа танилцуулъя, тайлбарлая. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Эхний миний санал дэмжигдчих юм бол Сайнаагийн санал хураагдахгүй учраас, Сайнзоригийн санал хураагдахгүй учраас Сайнзоригийн саналыг бас зөв, зүйтэй санал байна гэж үзээд нэмж оруулж байгаа.

Энэ хуулийн 5.2-ийн 5.2, 5.3-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, дээрхийг хослуулах зэрэг

үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хуралд өөрөөр тогтоож болно гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн дахиад тайлбар. Яг зөв үү дахиад бүтнээр нь уншаадах. Сая.

Б.Пүрэвдорж: Энэ хуулийн 5.2, 5.3-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүн сая энэ найруулгатай холбогдуулаад саналаа татах уу? Татах биш энэ чинь угаасаа дэмжигдчихвэл аль яаснаараа л явах юм байна шүү дээ. Хоёрт хураагдах юм байна Пүрэвдорж гишүүний саяын санал бол.

Эхнээс нь саналуудаа хураагаад явъя. Ажлын хэсгийн санал, ажлын хэсгийн саналыг түрүүн уншаад танилцуулчихсан байгаа. Тийм, эхлээд ажлын хэсгийн саналаараа санал хураана.

Хэрэв дэмжигдэхгүй бол Пүрэвдорж гишүүний саналаар санал хураалт явагдана гэсэн үг.

Эхнийх нь ажлын хэсгийн саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай санал хураалт.

Цахим системийн алдаа гарлаа. Санал хураалтыг дахиж явуулъя. Манайхан доошоо утасдаарай техникийн алба бэлэн байна уу? Болж байна гэвэл санал хураалтыг явуулъя. Дахиад нэг туршаад явуулчихъя тэгэх үү?

Ажлын хэсгийн саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал санал хураана. Санал хураалт. Санал хураалт.

Энэ төхөөрөмж ажиллахгүй байна гэж байна. Санал хураалтыг цуцлах нь байна. Цуцалчих уу?

Төхөөрөмж сая нэгэнт бас гацлаа. Хүчингүй болгох, саяын санал хураалт бол хүчингүй. Пүрэвдорж гишүүн горимын санал гаргах нь байна.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн гаргасан 2/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт заасан ажлын хэсгийн саналыг татаж байна.

Г.Тэмүүлэн: Тэгвэл шууд 2 дахь санал хураалт. 2 дахь санал буюу Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулна. Пүрэвдорж гишүүн түрүүн саналаа танилцуулж, тайлбар хийсэн байгаа. Ингээд Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Сайнзориг гишүүн дэмжсэн юм байна. Ингээд 22, Жаргалан гишүүн дэмжсэн байна. 22-оос нийт 16 гишүүн дэмжсэн байна.

Ингээд саяын санал дэмжигдлээ.

Одоо бол угаасаа саяын санал яасан учраас бусад бүх саналууд хураагдахгүй байгаад байгаа юм. Чуулган руу орохгүй. Ингээд 5.5 дахь санал бол боллоо.

Дараагийнх нь танилцуулъя. Дараагийнх нь 3 дугаар зүйлийн Б.Энхбаяр гишүүнээс гаргасан санал байна.

Саналын томьёолол нь 3 дугаар зүйлийн 3/30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг бол Энхбаяр гишүүн гаргаж байгаа юм байна.

Өөр санал байгаа юу? Өшөө 30.1.1 дээр? Ганцхан санал байна уу? Энхбаяр гишүүн саналаа танилцуулна. Таны санал хураалгах гэж байна. Энэ дээр болохоор таны гаргасан хуулийн төслийн 30.1.1 дэх, 30.1.1 дэх хэсгийг хасах гэдэг санал байгаад байна. Саналаа тайлбарлах уу? Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би энэ заалтыг хасах асуудлыг яагаад гаргасан гэхээр түрүүн ажлын хэсэгт хүргүүлсэн санал дээрээ энэ заалт татварын орчныг тогтвортой байлгах гэдэг заалтыг тогтворжуулах татварын орчныг тогтоох болгож өөрчлөөд улмаар татвар тогтворжуулах татварын орчин гэдэгт 4 асуудлыг ойлгоно гэдэг. Энэ заалт оруулснаар Оюу толгой болон дараа Монгол Улсын байгуулах хөрөнгө оруулалтын томоохон стратегийн гэрээнд айлын талд давуу байдал үүсгэх үү гэдэг асуултыг асуугаад хариулт авах чадахгүй байсан учраас оруулсан юм.

Түрүүн Тэлмүүн, Сангийн яамны газрын дарга Тэлмүүн бол Оюу толгойн Лондоны арбитрын бирж дээр явж байгаа маргаанд манай талд сөргөөр нөлөөлөхгүй гэдгийг батлан дааж байна гэдэг үг хэлсэн. Тэгэхээр би энэ үгийг Тэлмүүн дарга бол улс төрийн албан тушаалтан биш буюу хэлсэн үгнийхээ дараа хариуцлагыг хүлээх улс төрийн албан тушаалтан биш байгаад байгаа юм. Тийм учраас би яг энэ байр суурин дээр байгаа юу гэдэг үгийг микрофонд ажлын хэсгийн ахлагч Пүрэвдорж, Засгийн газрын гишүүн Туваан, Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд гурваас микрофон дээр авч байж санал хураалгахаа шийдэх гээд байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ санал бол Засгийн газрын өргөн барьсан санал байгаа. Тэгэхээр энэ дээр ямарваа нэгэн ажлын хэсэг дээр санал хураалт болон ажлын хэсгийн гишүүдийн санал гараагүй. Тийм учраас энэ оруулж ирсэн Засгийн газрын гишүүд хариулахыг хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Туваан сайд.

Ц.Туваан: Засгийн газраас оруулж ирсэн хувилбар дээрээ байна нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь энэ оруулж ирсэн хуулийн хүрээнд оруулж ирж байгаа энэ заалт Оюу толгойн арбитр дээр явж байгаа асуудалтай хамааралгүй гэж үзэж

байгаа. Тэр дээр хэлэлцэгдэж байгаа асуудал ондоо асуудал. Дийлэнх асуудал нь энэ давхар татвар мөрдөлттэй холбоотойгоор асуудал байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Мөн энэ асуудлаар Оюу толгойтой ажлын хэсэг байгуулагдаад тэр ажлын хэсэг дээр яригдаж байгаа асуудал.

Г.Тэмүүлэн: Хууль зүйн сайд байхгүй байна. Санал тайлбар хэлэх юм уу? Уянгахишиг гишүүн ажлын хэсгийн байр суурь.

Г.Уянгахишиг: Байр суурь ч гэж дээ. Ажлын хэсэг дээр ерөнхийдөө энэ дээр би бас санал өгөөд унасан юм. Тэгээд яах вэ, ер нь бол тайлбарыг нь юу гэж ойлгосон гэхээр яг энэ хууль дээрээ бол энэ нөгөө тогтоох гэдэг үг нь байх хэрэгтэй болчихоод байгаа юм байна лээ.

Яагаад гэхээр нөгөө одоогийн байгаа оригинал заалтаараа болохоор татварын орчныг тогтворжуулах гээд орчихсон. Тэгэнгүүт татварын орчин гэдэг нь болохоороо бүүр нөгөө бүх эрх зүйн орчны бүрдлийг гээд тайлбарлачихсан байгаад байгаа байхгүй юу нэр томъёо дээрээ. Тэгэнгүүт хөрөнгө оруулалтын гэрээг яг энэ Хөрөнгө оруулалтынхаа тухай хуулиар яваад оруулаад ирэнгүүт тэр дээр, энэ 30.1.1 дээр байгаа оригинал заалтаараа явахаараа хөрөнгө оруулалтын гэрээ байгуулаад тэр дотроо татварын орчныг тогтворжуулах гээд ороод ирж байгаа юм.

Тэгэхээр ерөнхий явчхаад байна, нөгөө татварын орчин гэдэг чинь зөвхөн энэ 4-өөс гадна нэмэгдээд бүх эрх зүйн зохицуулалтууд нь орж ирчхээд байна. Тийм болохоор энийгээ яг зөвхөн тэр тогтворжуулах татварын орчноо л тогтооё гэдэг үг, хэллэгээр оруулах нь зөв болчихоод байна гэдэг Сангийн яамны тайлбарыг ерөнхийдөө зөв юм уу гэж ойлгоод тэгээд бид хэд ажлын хэсгээс дэмжээгүй явчихсан юм.

Харин энэтэй холбоотойгоор нөгөө дагалдах хуулиуд байгаа шүү дээ. Дагалдах хууль дээр Татварын ерөнхий хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль 2 дээр харин өөрчлөлтийг оруулах ёстой юу гэдэг дээр бас зарчмын зөрүүтэй саналууд бас гаргаад яваад байгаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Хэрвээ тэгж ойлговол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар энэ саналууд чуулганаар дэмжигдээд явах юм бол эрх зүйн зөрчлийг бас арилгах хүрээнд холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Байнгын хороо гаргадаг. Энэ тохиолдолд Сангийн сайдын татварын аргачлал батлах эрхийг болиулах эрхтэй.

Яагаад гэхээр Сангийн сайд аргачлалаар дамжуулж татвар өөрчлөөд байгаа юм. Ямар компаниас хэдэн төгрөг авахыг шийдээд байгаа юм тэнд нэг хүн. Үндсэн хуульд нийцэхгүй байгаа. Албан татвар тогтоох гэдэг Улсын Их Хурлын, парламентын бүрэн эрхэд халдаад байгаа. Бид нар татварын орчныг тогтвортой байлгах ёстой гэж байгаа бол Сангийн сайд өөрчлөх болгонд татвар өөрчлөгддөг тэр боломжийг олгоод байгаа үүд хаалгаа тэгвэл бүүр болиулах ёстой. Болиулах ёстой шүү дээ. Аргачлалаа өөрөө батална, акт тавьсантай холбоотой маргаанаа өөрөө Татварын маргаан зөвлөлөөрөө шийдвэрлэнэ. Тэрнээс чинь улбаалаад

Петро Чайнагийн 300 тэрбум, Оюу толгойн маргаан яваад байгаа шүү дээ. Энэ аргачлалтай чинь холбоотой шүү дээ. Нэг хүн тэнд юм өөрчлөхөөр Монгол Улсын татварын эрх зүйн орчны тогтвортой байдал өөрчлөгдөөд байгаа байхгүй юу. Тийм учраас харин тэрийгээ болиул. Хэрэв тэгэх гэж байгаа бол.

Тийм учраас чуулганы хуралдааны тэмдэглэлд, Байнгын хорооны протоколд, дүгнэлтэд дагуулж энэ асуудлыг Үндсэн хуульд нийцүүлэх гэдэг санал, дүгнэлт гаргаад эцсийн хэлэлцүүлэг дээр энийг өөрчлөх хэрэгтэй гэж.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний, биш ээ Пүрэвдорж гэнэ.

Б.Энхбаяр гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Ингээд Б.Энхбаяр гишүүний гаргасан саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт, Б.Энхбаяр гишүүн зөвшөөрсөн.

22-оос 5 гишүүн зөвшөөрч саяын санал дэмжигдсэнгүй. Ингээд чуулган дээр бол бас саналаа тайлбарлаад, шаардлагатай бол чиглэл аваад ингээд явж болох байх. Саяын санал дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн 8 дугаар санал. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 12.2 дахь хэсгийн “байцаагчийн” гэснийг “байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх)-ийн” гэж. Ийм ерөнхийдөө редакцын найруулгын шинж чанартай засвар байна. Ажлын хэсгийн саяын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Төхөөрөмж нь 2 гишүүнийх ажилласангүй. Энхнасан гишүүн, Шижир гишүүнийх.

Шижир гишүүн дахин санал хураалт явуулчих уу? Горимын санал гаргачих та.

Шижир гишүүн горимын санал.

Ө.Шижир: Байнгын хорооны дарга сая үнэхээр миний төхөөрөмж ажилласангүй. Яг Наранбаяр сайд бид хоёр яг харж байхад, хараад байхад ерөөсөө ажилласангүй. Тэгэхээр би бол дэмжсэн байдлаар саналаа өгч байгаа шүү.

Г.Тэмүүлэн: Дахин, Шижир гишүүний гаргасан саналаар дахин санал хураалтаа явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай саяын санал хураалтыг хүчингүй болгох. Саналт хураалт. Шижир гишүүний саналыг дэмжье гэдгээр, хүчингүй болгох. Дэмжих юм Цогтбаатар гишүүн.

54.5 хувиар дэмжигдлээ.

Шижир гишүүний горимын санал дэмжигдсэн учраас саяын ажлын хэсгийн саналыг дахин хураалгая. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалт явуулъя. Саналын томьёоллыг уншсан байгаа. Санал хураалт анхааралтай байгаарай.

68.2 хувиар дэмжигдлээ.

Ингээд 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

4 дүгээр зүйлтэй холбогдуулаад санал гаргасан гишүүд байна уу? Байгаа юу?

Уянга томъёоллоо энд бичсэн байна. 4 дүгээр зүйл.

Ажлын хэсгийн санал байхгүй тээ? Ажлын хэсэг санал бол 4 дүгээр зүйл дээр санал байхгүй. Энд Уянга болон Батнайрамдал гишүүд гаргасан санал байна. Саналыг уншаад танилцуулаадахъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн “20 гэж” гэсний дараа “ , мөн хэсгийн “байгуулж болох бөгөөд түүнд” гэснийг “гэрээний биелэлтийг 5 жил тутам дүгнэх, шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд” гэж” нэмэх гэсэн ийм 1 дэх санал нь байна.

2 дахь нь Батчимэг гишүүн ирүүлсэн санал байгаа юм байна. Бичгээр ирүүлсэн байна.

4 дүгээр зүйлийн, зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн 10 гэснийг 10-20 гэж тус тус өөрчилсүгэй гэсэн санал гаргаж байгаа юм байна.

Ийм 2 л санал байгаа юм байна тээ? Одоо энэнтэй холбоотойгоор тайлбар өгнө. Манай Уянга гишүүн өгөх үү? Тэгье, Уянга гишүүний микрофоныг өгье саналаа тайлбарлана. Уянга, Уянгахишиг биш. Уянга гишүүн болон Батнайрамдал гишүүд гаргасан санал байгаа.

Б.Уянга: Энэ 30.1 дүгээр заалтыг тайлбарлая. Цөмийн энергийн тухай хуулийн одоогийн яг 30.1 дээр болохоороо гэрээг 10 жил хүртэл, 10 хүртэлх жилийн хугацаатай байгуулна гэж байдаг. Тэрийг 20 жилийн хугацаатай болгоод ихэсгэж байгаа юм билээ. Тэгээд энэ дээр болохоороо Батнайрамдал гишүүн бас энэ жилтэй холбоотой хариултыг бас өгөх байх.

Ерөнхий концепц нь ийм л байгаа юм Оюу толгойн гэрээг болохоор бид нар 30 жилээр байгуулчихсан 2009 онд. 2039 он хүртэл бид нар ингээд ямар нэгэн байдлаар дүгнээд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхээ хасуулчихсан байдалтай ийм 30 жилээр түгжсэн гэрээ байдаг. Тэгээд тэр дээрээ зэсийнхаа АМНАТ-ыг 5 хувиар хүртэл ингээд барьчихсан байгаад байгаа.

Тэгэхээр энэ Цөмийн энергийн тухай хууль дээрээ энэ гэрээгээ хийхдээ хэрвээ 10 хүртэл жилийн хугацаатай байхыгаа 20 хүртэл жил гээд нэлээн удаан хугацаагаар байгуулж байгаа бол дахин эргээгээд дүгнэдэг байя. Ийм саналын

дагуу энэ заалт орж ирсэн. Тэгээд Батнайрамдал гишүүн өөр нэмэлт хариултыг бас өгөөрэй.

Г.Тэмүүлэн: Батнайрамдал гишүүн нэмж тайлбарлах юм уу? Санал гаргасан гишүүн, 2 гишүүн гаргасан байгаа. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Оюу толгойн гэрээн дээр жишээлбэл, хөрөнгө оруулалтын гэрээгээ бид нар хөндөж чадахгүй тэгээд нэг хийсэн гэрээ одоо хүртэл ингээд явж байгаа.

Тэгэхээр яах вэ, дүгнэдэг байя л гэж байгаа юм. Ер нь цаашдаа бид нар ийм хөрөнгө оруулалтын гэрээг хийхэд ерөөсөө дүгнэх концепц ойлголт ерөөсөө явахгүй тэгээд л маргаантай яваад байгаа юм л даа. Тэгэхээр хугацаатай дүгнэдэг байя, дүгнээд хэрвээ 2 талаасаа шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байх энэ агуулгыг л оруулж өгч байгаа юм. Тэр нь цаашдаа бид нар энэ Орана-тай байгуулах гэрээ ч гэсэн цаашдаа ингээд бид нар Засгийн газрын зүгээс ч гэсэн хөрөнгө оруулалтын гэрээ ингээд байгуулаад явахад яг Оюу толгой дээр гарч байгаа нийтлэг тэр том алдаануудын зарчмыг бид нар засаад л явах ёстой гэсэн зарчмын хүрээнд энэ саналыг оруулж ирж байгаа.

Г.Тэмүүлэн: Би энэ Учрал сайд. Учрал сайдаа, Туваан сайд та хэд саяын саналыг сонссон байх тээ? Яг энэ дээр та хэд маань бас яг ямар байр суурьтай байгаа юм? Тэрийгээ бас хэлээч.

Би энэ дахиад би уншаад танилцуулаадахья яг шигтгэсэн хувилбараар нь. Сая Батнайрамдал болон Уянга гишүүдийн гаргасан саналыг та хэд Засгийн газраас орж ирсэн саналын 30.1 дээр нь шигтгээд унших юм бол ингэж уншигдах нь байна шүү.

30.1 нь энэ хуулийн 15.1.2, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 10 гэж байсныг нь 20 болгож байгаа шүү. 20 хүртэл жилийн хугацаатай байгуулах тэгээд таслал нэмж орж байгаа заалт нь гэрээний биелэлтийг 5 жил тутам дүгнэх таслал шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана гэсэн. Ингэж өөрчлөгдөж байгаа юм байна шүүб

Тэгэхээр энийг айн 10.1-д 20-д болгож байна, дээрээс нь нэмж байгаа нь гэрээний биелэлтийг 5 жил тутам дүгнэх гэж нэмж орж ирж байна. Тэгээд шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээндээ нэмэлт, өөрчлөлт оруулж болно гэсэн ийм томъёолол орж байгаа юм. Энэ дээр Засгийн газар ямар байр суурьтай байна? Учрал сайд.

Н.Учрал: Энэ эрхэм гишүүд та бүхнийг бас нэг зүйлд анхаарахыг хүсэж байна. Түрүүн бас гишүүд асуугаад байна. Энэ цөмийн энергийн хууль бол нэг төсөлд зориулсан хууль ерөөсөө бас биш. Түрүүн ч гэсэн тэр төрийн эзэмшлийн 34-ийг тэр АМНАТ-аар орлуулах энэ тэр гээд зохицуулалт чинь сонголтыг л нэмэгдүүлж байгаа болохоос биш, яг хууль дээр энэ гэрээг ийм хэлбэртэй хий гэдгийг тулгаж өгч байгаа зүйл биш.

Тийм учраас нөгөө хэлэлцээний явцад бид нар хөрөнгө оруулалтын гэрээгээ хэлэлцэхдээ энэ хуульдаа нийцүүлээд аль ч хувилбарыг сонгож болно. Аль ч хувилбарыг. Түүн шиг ер нь бол нөгөө хөрөнгө оруулагч талдаа тогтвортой байх үүднээсээ 10 жил гэдэг хугацааг бол 20 жил хүртэлх нээж өгөөд тэгээд хэлэлцээний явцад тэр нь хэдэн жилээр байна уу, 5 жил тутам дүгнэнэ үү, эсвэл одоо 15 жил байх уу, 10 жил байх уу, 20 жил байх уу гэдгийг Хөрөнгө оруулалтын гэрээгээрээ зохицуулна. Тэрнээс биш заавал хууль дээр 5 жил тутам дүгнэнэ, эсвэл тэдэн жил байна, эсвэл хатуу тэгж заачхаад байгаа юм байхгүй шүү дээ. Өнөөдөр төрийн эзэмшлийн хувийг ч гэсэн АМНАТ-аар орлуулах нэг л боломж. Тэрнээс биш Хөрөнгө оруулалтын гэрээгээ танилцуулаад орж ирээд Их Хуралд орж ирэхэд бол нөгөө хэдэн хувийг нь хэдийг нь АМНАТ-аар орлуулах юм, хэдэн жилийн хугацаатай хийх юм, 5 жил тутам дүгнэх юм уу, үгүй юм уу гэдгийг бол гэрээндээ тусгаад өгөх нь бол илүү зохимжтой байх.

Яагаад гэхээр энэ Цөмийн энергийн хууль цаашдаа зөвхөн энэ Францтай холбоотой энэ хөрөнгө оруулалтын гэрээн дээр хэрэглэх биш энэ хууль, эрх зүйн орчиндоо бол бид нар цаашдаа олон төслүүдийг явуулахад хөрөнгө оруулагч нартай хэлэлцээр хийхэд бол аль аль тал нь ашигтай.

Ер нь тухайн кэйс дээр аль нь илүү зөв хувилбар вэ гэдгээ хөрөнгө оруулалтын гэрээндээ тусгаад л орж ирнэ. Тэгэхээр энэ огт хөрөнгө оруулалтын гэрээ бүрэн яригдаж эхлээгүй учраас хуулиараа нээж өгчхөөд гэрээн дээрээ тусгаад явъя. Тэгээд дараа нь бол хөрөнгө оруулалтын гэрээний төсөл орж ирэхээр тэр 5 жил тутамд дүгнэх ч гэдэг юм уу заалтуудыг оруулаад явчих нь зөв. Зүгээр босгоо бол өндөрсгөөд 20 жил хүртэлх байж болно гээд заачихвал хэдэн жилээр хийх нь бол гэрээн дээрээ тусгасан нь зөв байх гэсэн ийм байр суурьтай байна.

Г.Тэмүүлэн: Цогтбаатар, айн? Цогтбаатар гишүүн. Дэг байхгүй ч гэсэн яах вэ би танд горимын санал гаргах гэж байна гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Ийм хандлагатай ийм орчинд хүн орж ирж мөнгө, хөрөнгө оруулалт хийх алба байгаа юу? Би бүр гайхаж байна. Наадах чинь жинхэнээрээ энэ сая сайдын хэлж байгаа үнэн шүү. Нэг гэрээнд зориулсан биш энэ чинь хуульд. Хэчнээн төрлийн гэрээнд энэ хамаарна. Сонгуулийн циклээрээ авчраад Компанийн хуулиа унш л даа. Энэ Монгол Улс чинь өөрөө хуультай. Хөрөнгө оруулагч хүн хэзээ ч shareholders agreement-аа эргэж дуудаж авчраад бид нар их зөвлөлдье ярья гэхэд 5 жилийн цикл хэрэггүй. Хэзээ ч энийгээ эргээд дүгнэж байдаг. shareholders meeting гэдэг чинь жил болгон 4 сарын дотор билүү дээ Компанийн хуулиараа заавал хийгдэж байх ёстой. Тэр дээр чинь тэр хамтын ажиллагааны бүх юмнуудаа дүгнэж ярьж байдаг.

Тэгээд энэ улсад чинь хөрөнгө оруулалт хийх өндөр технологийн юмнууд оруулж ирье гэж байгаа бол ийм байж байгаа хуулиудынхаа хүрээнд л юмнуудаа ярих хэрэгтэй байхгүй юу. Түүнээс энэ дахин сонгогдохоо юм уу, улс төрөө ярьцгаагаад энд тэнд гоё харагдах энэ тухай ерөөсөө асуудал биш шүү дээ. Бид нарын гоё харагдахын үнэ цэнээр ард түмэн ядуу амьдраад байж болохгүй шүү дээ.

Тийм учраас иймэрхүү юмнууд эд нараа ийм нарийн хууль оруулж ирж байж бизнесээ илүү, яг төр оролцохлоороо ийм л юм болдог байхгүй юу. Одоо наадах чинь дунд шатны хүмүүсийн авлига нэхэх үүд хаалгыг нээж өгч байгаа юм. Их

Хурлын гишүүд энийг чинь ярихгүй шүү дээ. Доор байгаа нэг яамны хүмүүс л 5 жил болгон ярья гээд тэгээд сонгуулийнхаа мөнгийг босгох хөшүүрэг болгож ашиглана наадхыг чинь.

Г.Тэмүүлэн: Санал хураалт явуулна. 2 гишүүний гаргасан саналаар санал хураалтыг явуулъя. Батнайрамдал, Уянга гишүүдийн гаргасан санал байгаа. Гишүүдийн гаргасан саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Техник ажилласангүй. Доошоо техникийн алба руу хэлээрэй. Дахиж санал хураалт явуулах уу? Техник болохоор байна уу, болох уу? Тэгнэ ээ, техникийн алба болохоор байна уу? За болно гэж байна. Одоо дахиад санал хураалтыг явуулъя. Сая дүн нь гараагүй.

Батнайрамдал болон Уянга гишүүдийн гаргасан саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалт дэмжигдсэнгүй.

Батчимэг гишүүнийхийг хураалгая. Энэ давхацсан санал 31 дээр тээ? Энэ дэмжигдчихвэл яах вэ? Энэ дээр манайхан анхааралтай байгаарай. Гишүүд гишүүд, энэ Батчимэг гишүүний гаргасан санал байгаа. Энэ агуулга нь арай өөр юм байна шүү.

Батчимэг гишүүн бол Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “10” гэснийг “10-20” гэж тус тус өөрчилсүгэй гэж өөрчлөхөөр орж ирж байгаа юм байна. Агуулга нь “20” гэснийг нь л “10-20” болгож байгаа юм байна шүү.

Батчимэг гишүүний саналыг дэмжье гэдгээр явах юм байна. Айн айн? “10-20”. Санал хураалт.

Батчимэг гишүүний санал дэмжигдсэнгүй.

95 хувиар дэмжигдсэнгүй, 95.5 хувиар.

Ингээд 4 дүгээр зүйлээр гишүүдээс ирүүлсэн саналаар санал хураалт явуулж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Батнайрамдал гишүүнээр тасалъя. Батнайрамдал гишүүн асуулт асууна. Батнайрамдал гишүүний микрофон.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгэхээр яах вэ, энэ гэрээн дээр ер нь бид нар ингээд хөрөнгө оруулалтын гэрээ, урт хугацааны гэрээ байгуулах гээд л байна л даа. Ер нь цаашдаа ч гэсэн бид нар ялангуяа уул уурхайн салбар дээр урт хугацааны гэрээ байгуулаад явна. Гэхдээ Оюу толгойгоос гарч ирж байгаа энэ маргаанууд бол яг үнэнийг хэлэхэд өнөөдөр Оюу толгойтой бид нар хамтдаа суугаад гэрээгээ 2 талаас дүгнэх тийм агуулга байхгүй л байгаа шүү дээ. Баахан маргаантай арбитрай ингээд л яваад байгаа.

Гэхдээ 2 талаас бид нар дүгнээд суух тэр боломж, нөхцөл нь одоо хүртэл байхгүй учраас яг энийг мэдсээр байж дараагийн гэрээн дээрээ ийм алдаа гаргах вий л гэж байгаа юм. Заавал яг сая гэрээг дүгнэхийг 5 жилээр хууль дээр хатуу тусгахгүй байх бас албатай биш. Тэрийг ойлгож байна. Улс төрийн циклтэй холих юм бол сая Цогтбаатар гишүүний хэлдэгчлэн улс төрийн циклтэй холилдоод ингээд буруу аргаар ашиглагдах боломж харагдаж байна, ойлгож байна тэрийг.

Гэхдээ тэр гэрээг хөрөнгө оруулалтын гэрээ дээрээ тэгвэл бид нар 2 талаас харилцан тохиролцоод суугаад дүгнэдэг ийм л байх хэрэгтэй. Гэрээгээ бид нар дүгнэж чадахгүй бол дахиад л маргаан дараагийн 30 жилдээ, 40 жилдээ салахгүй шүү.

Тэгэхээр энийг бас протокол дээр албан ёсоор бас үлдээе гэж бодож байна. Хөрөнгө оруулалтын гэрээн дээрээ бид нар дүгнэх агуулгыг 2 талаас зарчимтай, ойлгомжтой, хэн хэндээ маргаан үүсгэхгүйгээр дүгнэдэг ийм нөхцөл байдалтай гэрээн дээрээ тусгахгүй бол дахиад л 30 жилийн, 40 жилийн тэр хаан хаагдлаа, хаасны дараа тэр мөнгө буцаад нөхөн сэргээлтээр ашиглагдах уу гэдэг дээр хүртэл ер нь маргаан гарах ийм л нөхцөл байдал, ийм л эрсдэл харагдаад байна л даа. Тэгэхээр энийгээ бас хөрөнгө оруулалтын гэрээн дээрээ бас хэрвээ тусгачих юм бол асуудалгүй. Гэхдээ хөрөнгө оруулалтын гэрээн дээрээ бас заавал тусгаж орж ирээсэй гэж протоколд үлдээе. Баярлалааб

Батнайрамдал гишүүнд баярлалаа.

Г.Тэмүүлэн: 5 дугаар зүйлээр гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хэллээ гэж ойлгож болж байна.

5 дугаар зүйлтэй холбогдуулж гишүүдийн гаргасан санал бол байхгүй байна.

Ингээд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн, таных санал байгаа юу 5 дээр үү? Компанийн тухай хууль арай болоогүй байна. Тэгэхээр болоогүй байна. Цөмийн энергийг дуусгаадахъя.

Тэгэхээр Цөмийн энергийн тухай хуулиар санал хураалт явуулж дууслаа.

Одоо Цөмийн нэрийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болох Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? 1 дүгээр зүйлтэй холбогдуулж.

Алга байна.

1 дүгээр зүйлтэй холбогдуулж бичгээр гаргасан санал байна уу?

Энхбаяр гишүүнээс гаргасан санал байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн, бүхэлд нь буцаах ийм санал байгаа юм байна. Тайлбарлах уу та? Хэрэггүй юу, саналаа тайлбарлах уу? Хэрэггүй юу? Энхбаяр гишүүн. Нэг гишүүний санал

байгаа юм байна. Энхбаяр гишүүнээс гаргасан саналаа тайлбарлана. Энхбаяр гишүүн, Б.Энхбаяр.

Б.Энхбаяр: Энэ хөрөнгө оруулалтын тухай хуульд тогтворжуулах татварын орчин гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.50-д заасныг хэлнэ гэдэг өөрчлөлт орж ирж байгаа. Тэгээд татварын орчныг тогтворжуулах гэдгийг тогтворжуулах татварын орчныг тогтоох гэж өөрчилж байгаа.

Тийм учраас би энийг албан ёсоор Улсын Их Хурлын протоколд дахин дахин үлдээж байгаа. Маргаашийн нэгдсэн чуулган дээр мөн энэ асуултаа асууна. Асуухдаа би ажлын хэсгийн ахлагч түрүүн микрофонд хариулаагүй энд, Засгийн газар хариулна гэж. Ажлын хэсгийн ахлагч би заавал хариулах ёстой гэж үзэж байгаа. Энэ Улсын Их Хурлын протоколд үлдэх ёстой. Монгол Улсын парламент энэ заалтыг ойлгохдоо ингэж ойлгож баталсан шүү гэдэг чинь ажлын хэсгийн ахлагч болон холбогдох сайд нарын албан ёсны протоколд хэлсэн үгээр дараа нь тайлбарлагдана. Энэ заалттай холбоотой Үндсэн хуулийн цэц дээр дараа нь маргаан гарахыг үгүйсгэхгүй бид.

Яагаад гэхээр Монгол Улс хэрвээ дараа нь энэ хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой, татварын үр өгөөжтэй холбоотой үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдсон эсэх асуудалтай холбоотой олон хөрөнгө оруулалтын гэрээ яригдана. Энэ яригдах болгон дээр энэ протокол эшлэгдэнэ. Тэр дотроо Үндсэн хуулийн цэц дээр.

Монгол Улс бол Үндсэн хуульдаа нийцсэн...олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй гэдэг Үндсэн хуулийн заалттай. Энэ олон улсын гэрээнд Оюу толгойн гэрээ ч орно, энэний дараа байгуулагдах Орана-гийн гэрээ ч орно, энэний дараа байгуулагдах гэрээ ч орно. Тэр үед тогтворжуулах татварын орчныг тогтоох гэдгийг бид яг ингэж ойлгож баталсан юм гэдэг энэ тайлбар дараа нь бүх маргаан дээр яригдана.

Тийм учраас би ажлын хэсгийн ахлагч Үндсэн хуульд нийцэх эсэх асуудлаар албан ёсны тайлбар өгдөг Хууль зүй, дотоод хэргийн сайд, энэ салбарын сайд нар Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр яг энэ Оюу толгойн татвартай холбогдсон маргаанд энэ айлын талд давуу байдал олгохгүй гэж албан ёсны протоколд хэлээрэй гэдгийг би албан ёсоор хэлж байгаа юм. Тийм учраас би энэ дээр дахиад тооцоо асууна шүү. Дахиад тооцоо асууна, дахиад судалгаа асууна, дахиад баталгаа асууна. Тийм учраас маргааш та бүхэн маань энэ дээр жижүүрийн үгээр биш, Тэлмүүн даргын үгийг эшилсэн байдлаар биш албан ёсоор улс төрийн хариуцлага хүлээх улс төрийн албан тушаалтны хувьд үндэслэл бүхий хариултаа бэлдэж микрофонд хариулаарай гэж хэлэх байна. Тэгээд санал хураалгаж таарна даа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүний саналаар санал хураалт явуулна. Өчигдөр ажлын хэсэг дээр ч гэсэн бид нар бас асуусан. Сангийн яам бол тодорхой хариулт өгч чадаагүй шүү. Яг энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь үндсэндээ агуулгаар уг нь бараг шаардлагагүй шахуу асуудал болчихоод байгаа. Хэрэв та хэд энэ хууль дээр өөрчлөлт оруулж байгаа бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийнхаа 4.7 дээрээ уг нь бас өөрчлөлт оруулах ёстой байсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 4.7-гоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад энэ 20 дугаар зүйл хамаарахгүй. Яг цөмийн энергийн бүх энэ гэрээ,

контракт, хөрөнгө оруулалттай холбоотой харилцаанууд бол Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулагдахаар бол заачхаад байгаа.

Тэгэхээр үндсэндээ бол нэг талдаа бас яг энэ хуулийн зөрчилтэй байна гэдэг зүйлийг бас ажлын хэсэг дээр бас бид нар ярьсан. Тэгээд энийг уг нь зөв болгож л оруулж ирэх зайлшгүй шаардлагатай байсан асуудал. Үндсэндээ энэ оруулж ирж байгаа өөрчлөлт маань бол нэг талдаа агуулгын хувьд бараг ач холбогдолгүй шахуу болчихоод байна уу гэж бол бид нар бас бичвэр талаас нь хараад байгаа юм шүү. Энийг дараа дараагийн хуулиуд оруулж ирэхдээ та нар бас анхаарч оруулж ирээрэй. Хуулийн бичвэр талаасаа алдаагүй, алдаа мадаагүй, маргаангүй зүйлийг л уг нь оруулж ирэх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм Засгийн газрын зүгээс.

Ингээд Энхбаяр гишүүний гаргасан саналаар санал хураалтыг явуулъя.

Энхбаяр гишүүний гаргасан, хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энхбаяр гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй.

Дараачийнх нь, Хөрөнгө оруулалтын 1 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууссан.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу?

Сайнзориг гишүүн. Өөр гишүүд байна уу?

Алга байна. Сайнзориг гишүүнээр тасалъя. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Энхбаяр гишүүн сая бас нэлээн анхаарал татахуйц буй, бид хэд цаашдаа яг энэ Үндсэн хуулийн 19 оны орсон өөрчлөлтийг хэрхэн, яаж зөв хэрэглэж, тайлбарлаж энэ эдийн засаг улс орныхоо аж амьдралыг авч явах вэ гэдэг зүйлийг бас ер нь санаа зовж асуугаад байна. Би энэнтэй 100 хувь санал нэг байна.

Ер нь тэр эрх бүхий албан тушаалтан нь ирээд энэ дээр тодорхой тайлбар өгөх нь зөв. Нэгэнт батлагдсан Үндсэн хуулийг дагаж мөрдөнө, нийцүүлж холбогдох шийдвэрүүдээ гаргана. Ер нь зүгээр энэ 19 оны өөрчлөлтийн 6.2 бол Монгол Улсын эдийн засгийг төлөвлөгөөт эдийн засагтай улс орон болгочихсон шүү. Уул уурхайгаас хамааралтай нийт экспортын орлогын 95 хувь нь уул уурхайгаас хамаарч байхад энэ их асуудлыг хэмжихэд маш төвөгтэй, улс төрийн аль ч байдлаар ашиглагдаж болох энэ үг, хэллэгүүд ороод өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн үйлчлэлийн дээр цаашдаа арбитрын шийд тэр гарч суух энэ өөрчлөлтийг 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлт хийчихсэн юм. Энэ дээр харин бид хэд маш болгоомжтой явж энэ хөрөнгө оруулалтын гэрээнүүд болон бусад төрлийн гэрээнүүдээ хийж явах ёстой.

Гэхдээ хэт бас энэ асуудлуудад наана цаана, буруу зөрүү ойлголцоод явах юм бол аливаа олон улсын байгууллагын арбитрын шийдвэр ер нь Үндсэн хуулиас маань давж гарах ийм нөхцөл байдлыг бас яах аргагүй энэ 19 оны өөрчлөлтийн энэ дээрийн цаана уншигддаг юм. Тэгээд энэ дээр хаа хаанаа маш болгоомжтой

маргааш яг Энхбаяр гишүүний асуугаад байгаа тэр юун дээр нь эрх бүхий сайд нар тайлбар хэлчээсэй. Ингээд протоколд үлдгээ гээд би зүгээр хэлж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Туваан сайд, Учрал сайд анхааралтай тэмдэглэж аваарай. Чуулган дээр тодорхой хариулт өгөөрэй, Сангийн сайдыг байлгаарай.

2 дугаар зүйлтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

2 дугаар зүйлтэй холбогдуулж бичгээр гаргасан санал байхгүй байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулж бичгээр гаргасан санал байна уу?

Алга байна.

Ингээд Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл тус тус бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Ингээд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Татварын ерөнхий хууль. Энхбаяр гишүүн болно. 2 гишүүн байна. Уянгахишиг гишүүн, Энхбаяр гишүүн.

Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Уянгахишиг гишүүнээр тасаллаа.

Б.Энхбаяр: Тэгэхээр Татварын ерөнхий хуулийн 6.1.50-д тогтворжуулах татварын орчин гэж татварын хувь хэмжээ, элэгдэл, хорогдол, тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг гэсэн өөрчлөлт орох гэж байгаа.

Тэгэхээр яг энэ саяын тогтворжуулах татварын орчинд оруулах гэж байгаа энэ зүйлүүд одоо Сангийн сайдын тушаалаар батлагддаг татварын аргачлалд аль нь орж зохицуулагддаг вэ? Аль нь орж зохицуулагддаг вэ? Татварын аргачлалд тооцох тэр татвар тооцоод байгаа аргачлалд энэ саяын дурдсан зүйлүүдээс оруулж зохицуулдаг, нөлөөлдөг зүйл байгаа юу? Байгаа бол байгаа, байхгүй бол байхгүй гэдгийг хариуцлагатайгаар хэлмээр байна. Хэрвээ байгаа бол тулгаж үзмээр байна Улсын Их Хурлын Тамгын газар. Бид нар энэ асуудлуудыг тогтвортой болгоно гэж хэлчихлээ. Хэрэв хуулиар тогтвортой болгоно гэж байгаа энэ асуудал Сангийн сайдын тушаалаар батлагддаг журам дотор байгаа бол энэ сайдын тушаалаар тогтворгүй байгаад байна гэсэн үг. Тогтворгүй байгаад байна гэсэн үг.

Тийм учраас Сангийн сайдын аргачлал баталдаг тэр эрх энэ хуульд нийцэж хүчингүй болох ёстой. Дараагийн логик үүсэх гээд байгаа байхгүй юу, эрх зүйн үр дагаврууд. Тийм учраас би энэ асуултыг асууж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам 8 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам, Тэлмүүн. Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Татварын хувь, хэмжээг татварын хуулиар тогтоодог. Татварын хуулиар эрх олгосон тохиолдолд Засгийн газар аймаг, нийслэлийн ИТХ, сум, дүүргийн ИТХ тогтоодог. Энийг журмаар хувь, хэмжээ тогтоодог асуудал нэгдүгээрт байхгүй.

Хоёрдугаарт, элэгдэл байгуулах хугацааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-ээр барилга байгууламжийг 40 жил, машин механизм үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг 10 жил гэх мэтчилэн хуулиар тогтоосон байдаг. Энэ хугацааг журмаар тогтоодоггүй.

Гуравдугаарт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлд татварын тайлан гаргасан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохыг 19.2 дахь хэсгээр дараалсан 4 жил гэж хуулиар тогтоосон. Энэ 4 жилийг журмаар 3 юм уу, 4 юм уу, 5 гэдэг ийм тогтоодог өөрчилдөг юм байхгүй. Тэгэхээр энэ бүгд хууль дээр энэ хугацаануудыг нь заасан байдаг.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Уянгахишиг гишүүн асуулт асууна.

Г.Уянгахишиг: Энэ нөгөө өчигдөр ажлын хэсгийн хурал дээр бас асуусан. Тэгээд бас саналаа хэлсэн. Тэгээд яах вэ, зарчмын зөрүүтэй санал уначихсан байгаа. Энэ дээр дахиад нэг асуугаад, тодруулаад бас энд Байнгын хороон дээр асуучихмаар байгаа нь юу гэхээр одоо энэ тогтворжуулах татварын орчин гэж нэр томьёо нэмж оруулах гээд байгаа юм.

Тэгэхээр Татварын ерөнхий хууль чинь жишээлбэл тогтворжуулах татварын орчин гэдэг маань заавал ингэж нэр томьёогоор тодруулж оруулахгүйгээр нөгөө татварын орчин дотроосоо тэр тогтворжуулах татварыг чинь татварын орчныг нь тогтоохыгоо хөрөнгө оруулалтын гэрээгээрээ явна гээд түрүүн зохицуулалт чинь яваад байгаа шүү дээ. Энэ 2 дээрээ ч гэсэн.

Тэгэхээр энэ дээр заавал ингэж нэр томьёо нэмж оруулахгүйгээр явах боломж байхгүй юу. Дээрээс нь одоо энэ тогтворжуулах татварын орчин гэж буцаагаад энэ хувь, хэмжээ, элэгдэл, хорогдол тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацаа гээд ингэж дурдаж оруулаад, гэтэл энэ чинь өөрөө татварын хувь, хэмжээ чинь тусдаа бас хөрөнгө оруулалтын гэрээгээрээ гэрчилгээгээр тогтворжуулах гэрчилгээгээр зохицуулаад явдаг харилцаа явж байгаа юм.

Тэгэхээр энэ нь өөрөө ингээд Татварын ерөнхий хууль дээрээ болон буцаагаад Хөрөнгө оруулалтын тухай хууль дээрээ ингээд хоорондоо зөрчилдсэн юм болчих вий. Тэгэхээр нэр томьёо оруулахгүйгээр зүгээр ажлын хэсэг дээр гаргасан миний санал юу байсан гэхээр 2 дугаар зүйлийнхээ дотор буюу энэ заавал Татварын хууль дээр бичиж байж тэр боломжийг бий болгох гээд байгаа юм бол төлөх татварын хувь хэмжээ, элэгдэл, хорогдол тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг Хөрөнгө

оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулах гээд 4.1-ийн нэгдээ оруулчихад л болчих гээд байгаа байхгүй юу. Тэрнээс энд заавал 6.1.50 дээр ингэж нэр томьёо болгож оруулж ирээд энэ нь өөрөө яг нэр томьёо шигээ хуулийн техникийн хувьд бол тийм зөв харагдахгүй байгаад байгаа учраас зүгээр тэр 4.1.1 рүүгээ шилжүүлээд явчхаж болдоггүй юм уу? Заавал энд нэр томьёо оруулаад байх шаардлага байхгүй.

Хэрвээ Хөрөнгө оруулалтын тухай хуульдаа нэр томьёогоо ашиглах гээд байгаа бол тэр чинь угаасаа л тогтворжуулах татварын орчноо тогтоох гэдэг чинь их нэр томьёо заавал оруулаад байх шаардлагагүй татварын орчин гэдэг чинь нэр томьёо дээрээ байж байгаа учраас явчхаж болохоор байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр Сангийн яам нь би удаа дараа хэлээд байгаа санаа чинь энэ шүү дээ тээ? Тэгэхгүй ингээд буцаагаад нэг хуулиас болоод Татварын ерөнхий хуулиа ингээд хөндөөд байдаг, тэн дээр ингээд янз бүрийн нэр томьёонууд нэмээд байдаг, тэр нь өөр газар очоод их хэрэглэгддэггүй тэгээд тэрэнд орвол зүгээр 4.1.1 дээрээ нэмчхаж болохгүй байсан юм уу л гэдэг асуулт яваад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. 8 номер Сангийн яам.

Б.Тэлмүүн: Татварын орчин, тогтворжуулах татварын орчин гэдэг маш чухал ойлголт татварын эрх зүйн орчинд. Энэ тодорхойлолт яг тодорхой татварын хуульдаа суугаагүйтэй холбоотой ингээд маргаанууд үүсээд байдаг. Татварын ерөнхий хуулийн үзэл баримтлал, зарчим бол татварын асуудлыг татварын хуулиар зохицуулах ёстой гэдэг.

Гэтэл өнөөдрийг хүртэл Хөрөнгө оруулалтын хуулиар татварын орчин гэж тодорхойлоод яг энэ татварын орчныг хэлсэн үг, үсгээ Хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Ашигт малтмалын хуульд тодорхой хугацаанд байсан энэ нэр томьёогоороо ингээд яваад байсан юм.

Тэгэхээр энэ өөрөө гадаадад, олон улсад ч гэсэн байдаг physical эсвэл non-physical stablation гээд энэ өөрөө энэ яг эрх зүйн орчинд байх ёстой, тодорхойлогдох ёстой нэр томьёо. Энэ зүгээр ингээд хаа нэгтээ хэрэглэгдээд явдаг биш. Хууль хэрэглээ талдаа энэ татварын орчин гээд одоогийн байгаа 3.1.7 зөвхөн хөрөнгө оруулалтын гэрээнд ашиглагддаг мөртөө маш өргөн хүрээтэй. Энэ нь өөрөө өмнөх хөрөнгө оруулалтын гэрээний маргаануудын үндэс байсан. Тэгэхээр бид нар энэ татварын орчин гээд одоо нэгэнт хууль дээр байгаа тодорхойлолтыг нэгдүгээрт, татварынхаа хууль тогтоомж руу аваачих ёстой.

Хоёрдугаарт, энийгээ маш тодорхой зааж өгөх ёстой. Тэгэхээр энэ нэр томьёоны тодорхойлолт зайлшгүй ингэж орж, энэ хууль хэрэглээндээ орох ёстой гэж л үзээд байгаа юм.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Одоо бид нар ингээд нэг төсөл явах, эсвэл ямар нэгэн хөрөнгө оруулалт хийх, ингээд ямар нэгэн үйл ажиллагаа явах болохоор Татварын тухай хуульд ингээд байнга өөрчлөлт оруулаад байгаа байхгүй юу. Ер нь Татварын тухай хууль чинь өөрөө хөдөлгөөнгүй маш сайн хууль байх ёстой шүү дээ. Тэгэхгүй ингээд явах гэж байгаа төсөл, хөтөлбөрт зориулаад, явах гэж байгаа хуулийн төсөлд зориулаад бид нар татварын хуулиудаа байнга өөрчлөөд байгаа юм.

Бизнесийн ч юм уу, эдийн засгийн харилцаанд хамгийн чухал хууль чинь татварын хууль шүү дээ. Тэгэхээр бид нар ингээд зөвхөн нэг төсөл, хөтөлбөрт зориулж татварын тухай хуулиудад өөрчлөлт оруулаад байгаа нь өөрөө хэр зохимж зохимжтой юм бэ? Ер нь бараг 1 удаа татварын хуулиа ерөнхий байдлаар нь Их Хурал дахиж нэг хэлэлцдэг юм уу, яадаг юм сайн хэлэлцээд татварын хуулиа ингээд байн байн өөрчилдөг байж болохгүй байхгүй юу.

Одоо бид нар ингээд юм болохоор л татварын хуулийг өөрчлөөд байгаа юм. Ингээд байнгын нэмэлт, өөрчлөлтүүд оруулдаг. Тэгээд Сангийн яам өөрөө энэ яг энэ одоо энэ асуудлыг өөрсдөө хариуцаж байж Татварын тухай хуулиа нэг бол бүүр нэгмөсөн багцаар нь оруулж ирж хэлэлцүүлээч. Тэгэхгүй одоо ингээд дараа нь дахиад ямар төсөл явах юм? Тэрэнд дахиад зориулж Татварын тухай хууль өөрчлөгдөх юм уу? Ер нь энэ Татварын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг бол нэг л ойлгохгүй байгаад байна. Яагаад ингээд төсөл, хөтөлбөр явах болгонд бид нар татварын хуулиудыг өөрчлөөд байгаа юм? Өөр төсөл явуулбал яах юм? Дахиад өөрчлөх юм уу? Өөрт таалагдахгүй байгаа заалтуудыг нийцүүлж оруулж ирэх юм уу? Одоо байгаа Татварын тухай хуульд л энэ бүх юм чинь нийцэж явах ёстой шүү дээ. Тэгээд нийцэхгүй юмаа өөрчилчхөөд байгаа байхгүй юу.

Тэгэхээр Сангийн яам энийг бас цаашдаа яадаг юм татварын тухай хуулиа нэг бүр олж хардаг юм уу, нэг бүр хэлэлцдэг юм уу? Тэгэхгүй ингээд л бид нар нэг юм явуулах болохоор өөрт таалагдахгүй байгаа заалтуудаа өөрчлөөд өөрчлөөд л нэмэлт, өөрчлөлт оруулаад л явчхаж байна шүү дээ.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүний асуултад хариулья. Сангийн яам 8 номер.

Б.Тэлмүүн: Энэ удаагийн өөрчлөлт бол хөрөнгө оруулалтын гэрээ сүүлд хамгийн том стратегийн орд 2009 онд байгуулагдсанаас хойш байгуулагдаагүй. Өнгөрсөн 15 жилийн хугацаанд Сангийн яам, Засгийн газар бүх шатдаа энэ хөрөнгө оруулалтын гэрээний сургамжуудыг ингээд хангалттай ярьсан. Татварын орчин тогтвортой байх ёстой. Яах вэ байн байн тогтмол реформ хийнэ гэдэг яриа энэ аль болох бага гаргах ёстой.

Тэгэхдээ хурдтай өөрчлөгдөж байгаа эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд уялдуулаад илүү боловсронгуй болгох ёстой. Цөмийн энергийн цацраг идэвхт ашигт малтмал ашиглахтай холбоотой харилцаа бол Монгол Улсад байгаагүй учраас яг энэ ашиглалт хийхтэй холбоотой татварын болон бусад хууль тогтоомжуудад тодруулга ийм боловсронгуй болгох асуудал бол зайлшгүй орохоос өөр аргагүй.

Сангийн яамны хувьд бол татварын хуулийг хамгийн бага өөрчлөх ёстой, хамгийн дэмждэггүй, татварын хууль тогтвортой байх ёстой. Ялангуяа үндсэн энэ татварын ерөнхий хууль, орлогын татварын НӨАТ болон энэ гол хуулиуд дээр өөрчлөлт оруулахыг бол эсрэг байдаг. Тантай санал нэг байдаг.

Тэгэхдээ энэ татвар тогтворжуулалт гэдэг нь өөрөө өнгөрсөн 30 жилийн хугацааны бидний том сургамж байгаа. Тэгэхээр энийгээ нэгмөр цэгцлээд цаашаа явъя гэж байгаа юм. Өөр энэ дээр татварын ямар нэгэн орчны өөрчлөлт байхгүй.

Гуравдугаарт хэлэхэд татварын орчны тогтворжуулалт өөрөө тодорхойгүй байгаа нь хөрөнгө оруулалтын орчиндоо сөрөг нөлөө үзүүлээд байгаа юм. Яг юу

тогтворжуулах юм гэдэг, хөрөнгө оруулагчтай хийж байгаа энэ маргаанаас дараагийн хөрөнгө оруулагчид ойлгомжгүй байдал үүсээд байгаа юм. Тэгэхээр бид нар энэ сургамжаасаа, сургамждаа үндэслээд хуулиа тухай бүр нь ингээд шинэчлээд явах нь зүйтэй. Татварын бодлого тодорхойлох нь Үндсэн хуулиар Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх байдаг. Тэгэхээр Улсын Их Хурал дээр энэ асуудал бол эцэслэгдээд шийдэгдэх байх. Та бүхэнд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн ойлгомжтой юу, тодруулах уу, шаардлагагүй юу? За маргааш.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2 санал байгаа. Би уншаад танилцуулаадахъя.

Нэгдүгээрх нь Б.Энхбаяр гишүүний санал хуулийн төслийг, Энхбаяр гишүүн таны санал байгаа шүү. Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналын томъёолол байна. Үүгээр санал хураах нь. Энэ чинь бол тусад нь хураах нь байна шүү дээ тээ? Энийгээ хураачхаад байж байх уу?

Энхбаяр гишүүний саналаар санал хураалтыг явуулъя. Энэ бас ийм санал байгаа юм байна. Энийг танилцуулчихъя. Түвшин гишүүний санал. Түвшин гишүүн болохоор 1 дүгээр зүйлтэй холбоотойгоор 6.1.51 дэх заалт дээр тогтворжуулахгүй татварын орчин гэж, нөгөө 6.1.50 чинь бол тогтворжуулах татварын орчин, тэрний доор нь тогтворжуулахгүй татварын орчин гэж Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтууд, тэдгээрт заасан татварын хувь, хэмжээ болон энэ хуулийн 6.1.50-д заасныг мөрдөж буй татвар төлөгчийн эрх зүйн байдлыг сайжруулсан татварын хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт гэж өгсөн байгаа.

Энэ өргөн барьсан хуулийн төсөл дээр 6.1.51 гэдэг заалт бол хөндөгдөж орж ирээгүй учраас үүгээр санал хураалгах ямар нэг боломж, бололцоо бол байхгүй байна.

Ингээд ямар ч байсан танилцууллаа.

Одоо ганцхан Энхбаяр гишүүний хуулийн төслийг бүхэлд нь хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. гишүүд анхааралтай байгаарай. Ажлын хэсгээс санал байхгүй.

Энхбаяр гишүүний саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Энхбаяр гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй. 72.7 хувиар дэмжигдсэнгүй.

Татварын хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

2 дугаар зүйлтэй холбоотой гишүүдийн гаргасан санал алга байна.

Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулж бичгээр санал гаргасан гишүүд?

Алга байна.

Ингээд Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуультай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Компанийн тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Энхбаяр гишүүн, Б.Энхбаяр гишүүн байна. Энхбаяр гишүүнээр тасалъя. Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Энэ компанийн хуульд гол орох гэж байгаа өөрчлөлт бол төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх асуудал орж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл, энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаагаар сольж болох ийм заалт орж ирсэн байгаа.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордод одоогоор 51, улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийсэн ордод 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг үнэ төлбөргүй шууд эзэмших ийм эрхтэй байгаа. Тэгэхээр энэ давуу эрхийн хувьцаагаар энгийн хувьцааг сольсноор саяын ярьж байгаа 34 хувийн, 51 хувийн энэ оролцоо өөрчлөгдөнө гэсэн үг. Саналын эрхгүй хувьцаа болно гэдэг нь бид нар үндсэндээ энэ ураны орд дээрх менежмент болон хяналтын боломжоо айлын талд өгч байгаа ийм асуудал байгаа.

Тийм учраас энэнтэй холбоотойгоор ялангуяа ноогдол ашиг тараах, Компанийн хуульд заасан ноогдол ашиг тараах, уурхайн үйл ажиллагааг нээх, хаах, түр зогсох төсөлд санхүүжилт татах, ТУЗ-д саналын эрхтэй гишүүн байлгах зэрэг энэ асуудлууд бол бидний нөгөө Үндсэн хуульд ярьсан үр өгөөжийн дийлэнх олонх Монголын ард түмэнд Монгол Улсад байх тэр асуудлуудад гол нөлөөлдөг ийм асуудал байгаа. Тийм учраас саяын ярьж байгаа бид эрхүүдээсээ татгалзах юм байна.

Тэгвэл саяын ярьж байгаа үр өгөөжийг бид ямар эрхээр нөхөх гэж байгаа вэ гэсэн ийм асуулт байгаа юм. Аль эрх бид нарт энэ үр өгөөжийг олгох юм бэ гэдэг ийм асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бол протоколд тэмдэглэх ёстой. Жишээлбэл, олон улсын санхүүгийн байгууллагуудаас энэ төсөл, хөтөлбөр хэрэгжсэн тохиолдолд гаднын эх үүсвэртэй зээлүүд татагдаж таарах байх. Санхүүжүүлэгчээс зөвшөөрөл авалгүйгээр эсвэл гэрээний хориглолтыг зөрчин ноогдол ашиг тараасан тохиолдолд энэ нь зээлийн гэрээний зөрчил гэж тооцогдож улмаар авсан зээлийг бүхэлд нь нэн даруй төлүүлэх, барьцаанд авсан хөрөнгийг худалдан борлуулах, зээлийг төлүүлэх зэрэг үр дагаварт хүргэгддэг.

Тийм учраас төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд ноогдох ноогдол ашгийн төлөлт, гаднын санхүүжүүлэгч болон хөрөнгө оруулагчаас үл хамаарсан байх асуудал Цөмийн энергийн хуульд тусгагдах ийм шаардлага байгаад байгаа юм. Тийм учраас энэ асуудал дээр өөрөөр хэлбэл бид нар давуу эрхийн хувьцаагаар хориг тавих ийм боломжтой гэж яриад байгаа. Бид нар ТУЗ-д нь байна, 2 гишүүн байна гэж яриад байгаа. Тэгэхдээ давуу эрхийн хувьцаатай болсон тохиолдолд саяын ярьж байгаа асуудлууд бүгд компанийн дүрмээр зохицуулагдана. Компанийн дүрэм бол.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Энхбаяр: Тэгэхээр компанийн дүрэм маань 9 гишүүний олонхоор батлагдаж явна. Бид хуулиар энэ компанийн дүрмийг батлахгүй шүү дээ. Хуулиар батлахгүй, хөрөнгө оруулалтын гэрээгээр батлахгүй. Компанийн хуулийн дагуу компанийн ТУЗ-өөс компанийнхаа дүрмийг батална. Бид компанийн тэр 9 гишүүн дээр бид хоёрыг авна гэж одоо зүгээр нооргоор ярьж байгаа энэ асуудал дээр яаж тэр дүрэм батлах гэх асуудалд нөлөөлөх гэж байгаа юм? Компанийн хуульд бид нар давуу эрхтний хувьцаатай болно гэснээр бид энэ дүрэмдээ Монголын талын эрх ашгийг хамгаалах тэр заалтуудыгаа тусгана гэсэн баталгаа юу байгаа юм бэ? Баталгаа?

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Учрал сайд.

Н.Учрал: Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Ер нь Засгийн газар “Орана Майнинг” компанитай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах энэ протокол дээр энэ агуулгуудыг бол дурдсан.

Тийм учраас ер нь цаашдаа зөвхөн энэ төсөл дээр ч гэлтгүй өөр төслүүд хэрэгжихэд энэ зарчмыг барих нь бол бас хамгийн зохимжтой гэж үзэж байгаа. Тийм учраас яах вэ, протокол дээр сая Энхбаяр гишүүний яг хэлж байгаагийнх нь дагуу төр эзэмшлийнхээ хувьцааг үнэ төлбөргүйгээр мэдээж эзэмшинэ. Тэгээд давуу эрхтэйгээр эзэмшсэний ач холбогдол бол төсөл хэрэгжүүлэгч компанид аливаа хэлбэрээр өөрийн хөрөнгийн болон зээлийн санхүүжилт хийх үүргийг Засгийн газар хүлээхгүй гэдгийг нь тодорхой тусгаж өгч байгаа давуу эрх учраас.

Дээрээс нь хөрөнгө оруулалтын гэрээ хэрэгжих хугацаанд талууд урьдчилан харилцан тогтоосон нөхцөлөөр тэргүүн ээлжид давуу эрхтэй ноогдол ашгийг авна. Энийг Их Хурлаар бид нар шийдүүлнэ гэдгээ протоколд тус сон.

Мөн Монгол Улсын Засгийн газар төсөл хэрэгжүүлэгч компанийн дүрэм, хувь эзэмшилд өөрчлөлт оруулах зэрэг асуудлаар хориг тавих эрхтэй байна гэж байгаа юм Засгийн газар.

Тэгэхээр таны яг хэлж байгаа нөгөө дүрэм дээр өөрчлөлт оруулъя гэх юм бол дээрээс нь компанийн дүрэмд эзэмшилд нь тодорхой өөрчлөлт орох бол хориг тавих эрх Засгийн газарт байна гэдгийг протоколд тусгасан.

Мөн Засгийн газар нь бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл болсны дагуу худалдан авах эрхтэй байна гэдгээ бас

тусгаж өгсөн. Мөн Засгийн газар нь талуудын хувьцаа эзэмшлийн хувиас үл хамааран төсөл хэрэгжүүлэгч компани, түүний үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон Компанийн хуульд заасан бүхий л мэдээллийг хөрөнгө оруулагчийн нэгэн адил авах эрхтэй гэж. Тэгэхээр яг л адилхан тэр board дээр төлөөлөлтэй байна, дүрэмд өөрчлөлт орох юм бол, хувь хэмжээнд өөрчлөлт орох юм бол, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх юм бол хориг тавих эрхийг Засгийн газар авна.

Тэгэхээр бид хэрвээ Компанийн хуулиар энгийн хувьцааг давуу эрх рүү төрлийг нь өөрчлөхийг нь хуулиар нь нээж өгч чадвал бид гэрээн дээрээ энэ асуудлыг яг энэ протоколд заасны дагуу хатуу хуульчилж өгнө. Тэгэхээр гол нь л хувьцааг нөгөө энгийн хувьцаа руу, энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаа болгох гээд байгаа бол санхүүгийн үүрэг, хариуцлагаас хөрөнгө оруулахаас бол татгалзаж байна л гэсэн үг. Бусдаар бол яг нөгөө бусад хувьцаа эзэмшигч, энгийн хувьцаатай яг адилхан эрх хэмжээг бол өөрөө хэрэгжүүлээд явна л гэсэн ийм зорилгоор орж байгаа учраас энэ заалт бол цаашдаа гэрээний хэрэгжилтийг хангуулахад хамгийн чухал заалт юм гэдгийг бас хэлэх ёстой байх.

Хэрвээ энд ингээд энгийн хувьцааг давуу эрх болгох хувьцааг төрлийг өөрчлөхийг хуульчилж өгөхгүй бол харин Монгол тал санхүүгийн үүрэг, хариуцлага хүлээх ийм эрсдэл бас учирч магадгүй.

Тийм учраас ингэж өөрчлөөд тэгээд гэрээгээ үргэлжлүүлээд хуульдаа нийцүүлнэ гэж хэлмээр байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

1 дүгээр зүйлтэй холбогдуулж бичгээр ирүүлсэн санал 1 байна Энхтүвшин гишүүн байгаа Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн хууль гэсний өмнө Цөмийн энергийн тухай гэж нэмэх гэсэн байна.

Энхтүвшин гишүүн гаргасан саналаа тайлбарлая. Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Компанийн тухай хууль дээр энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд шилжүүлж болохгүй гээд бүр тодорхой болохгүй гээд хориглосон ийм заалт байгаа. Тэгээд энэ нь бас яагаад ордог гэхээр цаанаа эдийн засгийн хариуцлагын асуудлууд ярьдаг учраас бусад хувьцаа эзэмшигчид бас нөлөөлөхөөр ийм заалт байдаг учраас, санхүүгийн хариуцлагын асуудал байдаг учраас энэ заалтыг хориглосон байгаа.

Тэгэхээр яах вэ, энэ нэг дилл/deal/-ээс болоод нэг стратегийн чухал ач холбогдолтой ордоос болоод бүтнээр нь ингэж ийм заалтыг бас нээх нь буруу юм болов уу гэж тэр үндэслэлээр энийгээ хэрвээ нээх гэж байгаа бол зөвхөн Цөмийн энергийнх тухай хуульдаа л өөрчлөлт оруулъя. Бусад ийм юмнуудыг бас ингэж нээх нь дараа нь Компанийн тухай хуулиар зохицуулахгүй өөр газруудад ингээд энэ боломжуудыг нээгээд энэ буцаад хариуцлагын тухай асуудлууд яригдах учраас хязгаарлая гэсэн ийм санаа байгаа юм.

Г.Тэмүүлэн: Их найруулга, редакц маягтай санал байна. Засгийн газар дэмжиж байгаа биз дээ? 9 номер

Н.Жамъянхүү: Байна уу?

Г.Тэмүүлэн: Овог, нэр албан тушаалаа?

Н.Жамъянхүү: Хууль зүй, дотоод хэргийн яам Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Жамъянхүү.

Тэгэхээр энэ гол нь энгийн хувьцааг бол давуу эрхийн хувьцаагаар хөрвүүлэх асуудал энэ Компанийн хууль дээр орж ирж байгаа. Тэгээд гол нь нөгөө үндэслэл нь одоо бол энэ Бадрах Энержи бол 34 хувийг Монгол тал эзэмшиж байгаа учраас энэ 34 хувийн эзэмшлийг бас тодорхой хэмжээгээр хөрвүүлэх давуу эрхийн хувьцаа руугаа хөрвүүлэх асуудал яригдаж байгаа юм. Тэгээд энэ үүднээсээ бол энэ өөрчлөлт оруулах асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр одоо яг энэ Компанийн хууль чинь өөрөө хувийн эрх зүйн хууль. Энэ дээр ингээд нөгөө шууд тусгайлаад Цөмийн энергийн хууль гээд заахаар бас техникийн хувьд, хууль зүйн техникийн хувьд бас зохимжтой бус байгаад байгаа юм.

Харин зүгээр хуульд тусгайлан зааснаас бусад гэдэг энэ агуулгаараа явж байх юм бол өөрөө бид нар энэ Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээрээ ийм тохиолдолд бол хөрвүүлж болох ийм нөхцөлийг нь заагаад өгчихсөн байгаа. Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам бол Монгол Улсад хууль зүйн нэгдсэн бодлогыг бол авч явдаг.

Тэгэхээр энэ хүрээндээ магадгүй Энхтүвшин гишүүний яриад байгаа бас болгоомжлолыг бол цаашдаа бол нөгөө хууль дээр, ялангуяа янз бүрийн дагах хуулиар бол ийм өөр тусгайлсан хууль дээр оруулж ирэх ийм боломжийг нь хаах байдлаар бас Хууль зүйн яамнаас санал өгөх, хянах ийм байдлаар бол бас аваад явчхаж бас болох боломжтой байгаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн, Б.Энхбаяр.

Б.Энхбаяр: Анхнаасаа Компанийн хууль дээр нэгэнт тогтсон том зарчим эвдэгдэж байгаа учраас дараагийн саяын ярьж байгаа логикийн зарчмууд эвдэгдэж таарч байгаа юм. Энэ дээр тэгэхээр туйлын шийдэл бол энэ орж ирэхгүй байсан байхгүй юу. Тэгж ярих юм бол энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаагаар солих ойлголт байхгүй. Одоо хууль ярих гэж байгаа бол шүү.

Тэгэхээр хууль тогтоогч Засгийн газраас орж ирсэн саналыг, болгоомжлолыг би Энхтүвшин гишүүний саналыг дэмжээд нэмэх нь олон дахин яриад байгаа энэ бусад гэрээнд нөлөөлдөг байхгүй юу даа. Хууль тогтоогчийн баталсан хөрөнгө оруулалтын гэрээнд өмнө нь байгуулсан болон дараа байгуулах гэрээнүүд нөлөөлнө. Одоо энэ Оюу толгойн гэрээнд нөлөөлнө шүү дээ тэгвэл. Наад заалт чинь Компанийн хуулийн өөрчлөлт чинь. Одоо Чайна Энержи-гийн гэрээнд нөлөөлнө шүү дээ. Байгуулах гэж байгаа. Давуу эрхийн хувьцаагаар сольчихъё л гэнэ шүү дээ. Яагаад танайх нэг улстай ийм гэрээ хийчхээд манайхтай ингээд байгаа юм, царай хараад байгаа юм уу.

Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээнд тогтчихсон маш хатуу зарчим байгаа. Адил, тэгш хандана. Ялгаварлалгүй хандана гэдэг зарчим. Яг энэ зарчмаа барих юм бол энэ хууль ерөөсөө орж ирж болохгүй. Хэрвээ тэгвэл.

Тийм учраас Цөмийн энергийн гэж ёстой нөгөө буруу харж инээж, зөв харж яана гэдэг шиг л би санал гаргаж байна гэж ойлгож дэмжих гээд сууж байгаа байхгүй юу. Хэрвээ яг төслөөрөө байлгана гэдэг дээр Засгийн газар хатуу байх юм бол энийг харин би одоо бүүр төсөл санаачлагчид нь буцаах санал гаргах гэж байна одоо. Энэ болохгүй байхгүй юу. Дараагийн гэрээнүүд шууд нөлөөлнө. Бусад бүх компаниуд энэ давуу эрхийн хувьцаагаа сольдог байдал руу орно шүү дээ. Айн юу гэсэн үг юм? Энэ чинь бүр алах гэж байна шүү дээ. Нөгөө стратегийн орд, Монголын ард түмний стратегийн ордуудын үр өгөөж, дийлэнх олонх наад Үндсэн хууль чинь будаа болно. Зөвхөн энэ заалтаар шүү. Энэний цаана хэдэн тэрбум долларын, их наядын байгалийн баялгийн үр өгөөж хаашаа очих тухай асуудал яригдана тэгвэл.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Харин түрүүн би бас асуух гээд байсан юм. Нэг хууль дагуулж оруулж ирээд дагасан хуулиудтай холбоотой асуудал хөндөгдөнгүүт мэргэжлийн Байнгын хороо нь энэ дээр яагаад дуугарахгүй байгаа юм гээд би асуух гээд байсан байхгүй юу. Түрүүн төсөвтэй холбоотой асуудал дээр Төсвийн байнгын хороо тэс өөр юман дээр санал санал гаргасан байсан. Татвартай холбоотой асуудал дээр ерөөсөө дуугараагүй байна лээ. Тэр Компанийн тухай хууль ороод ирэнгүүт би Хууль зүйн байнгын хороо руу энэ чинь орж ирсэн юм уу? Энэ чинь Хууль зүйн яам биднүүс шинжинэ гэдэг үг биш. Парламентын мэргэжлийн Байнгын хороо нь өөрийнхөө үндсэн эрхлэх асуудлынхаа гол дэд бүтэц рүү нь орж ирж байхад энэ дээр мэргэжлийн Байнгын хороо дуугарахгүй бол яг саяынх шиг асуудал болох байхгүй юу. Дагасан хуулиудаар өөр салбарын том асуудлыг хөндчихдөг, дараа нь том үр дагавар гардаг. Энэ том үр дагаврыг тэгээд хэн хариуцах юм бэ? Компанийн хууль тогтоомж дээр байж байгаа нэлээн суурь шинжтэй зохицуулалтыг эвдэх гэж байна шүү дээ.

Тэгэхээр хэрвээ ингээд Компанийн хууль ингээд Аюулгүй байдлын байнгын хороон дээр яригдахгүй шүү дээ. Энэ чинь Хууль зүйн байнгын хорооны эрхлэх эрхлэх асуудал шүү дээ. Тэгээд Хууль зүйн байнгын хороо яг энэ суурь шинжтэй бодлогынх нь өөрийнх нь эрхлэх асуудлын хамгийн суурь юмыг ингээд хөндөж байхад Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт байгаа юм уу? Энэ эдийн засгийн асуудал ерөөсөө биш. Энэ өөрөө хувийн эрх зүй дээр хуулийн этгээдийн зохион байгуулалтын хамгийн чухал асуудлынх нь нэг байхгүй юу. Энэ хувьцааны чинь хөдөлж байгаа хөдөлгөөнөөр хөрөнгө оруулагчдын өмч эзэмшигчдийн тэр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн өөрийнх нь эрх мэдэл дотроо эвдэрнэ шүү дээ. Хөдөлнө шүү дээ. Тэгээд энэ асуудал дахиад Хууль зүйн яамны Улсын Их Хурлыг давж амлалт авдаг асуудал ерөөсөө биш шүү.

Г.Тэмүүлэн: Товч бөгөөд тодорхой. Ерөнхийдөө агуулгуудаа ойлгочихлоо. Анар гишүүн. Анар гишүүн.

Ч.Анар: Энэ цөмийн энергийн, цөмийн гэж заахгүй бол нөгөө компанийн энгийн хувьцаа давуу эрх рүү хөрвөх юм бол энэ битүү залилангийн хэрэг болно шүү. Яагаад гэвэл компани өөрөө хувь эзэмшигч, хөрөнгө оруулагчид чинь хөрөнгө, санхүү хөрөнгө оруулалт болон хариуцлагаараа маш олон төрлөөр нийлж

байгуулагдаж байгаа. Тэгээд үүгээр бол гадна, дотнын хөрөнгө оруулалт гэлтгүй дотооддоо жишээ нь үүсгэн байгуулсан компани. Би жишээ нь энэ хуулийн заалтаар хөрөнгө оруулагчдаас мөнгө аваад, давуу эрхийн хувьцаа руу хөрвүүлээд өөрөө хариуцлагаас зугтах бүрэн бололцоог нээж өгч байгаа. Энэ ер нь энэ байж болохгүй. Яг практик дээр битүү залилангийн жишээний, хамгийн сонгодог жишээ болно. Үүсэх юм бол, энэ хууль өөрчилж байна.

Г.Тэмүүлэн: Окэй ойлголоо. Одоо Энхтүвшин гишүүний гаргасан саналаар санал хураана. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн хууль гэсний өмнө цөмийн энергийн тухай гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Энхтүвшин гишүүний гаргасан саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явагдана. Санал хураалт.

Энхтүвшин гишүүний гаргасан санал 54.5 хувиар дэмжигдлээ.

Батчимэг гишүүн бас санал гаргасан байсан. Энэ болохоор Компанийн тухай хуулийг, хуулийн төслийг бүхэлд нь хууль санаачлагч нь буцаах гэсэн санал байсан. Тэгээд саяын санал дэмжигдсэн учраас энэ саналыг бол хураах шаардлагагүй байна. Танилцууллаа.

1 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууссан.

2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулж бичгээр ирсэн санал алга байна.

Ингээд Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Одоо сүүлд найруулгын 1 санал байгаа. Ажлын хэсгийн гишүүд тарж байгаарай. Дэлгэрсайхан гишүүн. Энэ найруулгын санал.

1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн ийм санал байна. Ингээд ажлын хэсгийн санал байгаа найруулгын санал. Найруулгын саналыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

54.5 хувиар дэмжигдлээ.

Ингээд Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл тус бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Ингээд ажлын хэсэг, гишүүдэд баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилох шаардлагатай байгаа. Саналаараа санал, дүгнэлт танилцуулах гишүүн байна уу? Пүрэвдорж

гишүүн манай Байнгын хороонд байхгүй. Болормаа гишүүн. Болормаа гишүүнээр томилъё.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

18.05 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР